

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр, Пүрэв гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-48
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	49-111
<hr/>	
<i>1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	49-111

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 08 дугаар сарын 22-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 32 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Пүрэвдорж;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Б.Батбаатар, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Э.Одбаяр, Л.Энх-Амгалан.

**Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, шинжээч Б.Төрбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Усны газрын дарга Э.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Цэвэгдорж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гантогтох, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, мөн яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Гантулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Анар, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, Сангийн яамны Төсвийн бодлого,

төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат, Б.Баттөмөр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх П.Мөнхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Нандингэрэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлт болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нар танилцуулав.

Ажлын хэсгээс болон Байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

***Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэв.***

*Төслийн талаар ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Р.Сэддорж, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтын “улсын төсөвт тусган хэрэгжүүлэх” гэснийг “улсын төсвийн төсөлд тусган өргөн мэдүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 9

Бүгд: 17

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 4  
Бүгд: 17  
76.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 4  
Бүгд: 17  
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын бүлэг, зүйлийн нэрийн жагсаалт бүхий агуулга хэсгийг хасаж, “Өмнөтгөл” хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

## “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар олонхыг бүрдүүлсэн Монгол Ардын намаас Засгийн газрын бүрэлдэхүүнд Ардчилсан нам, ХҮН намыг урьж, хамтарсан Засгийн газрыг байгуулсан.

Засгийн газар хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч байгаа сорилтуудыг илүү хурдан, үр дүнтэйгээр шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, тогтвортой хамтран ажиллах зорилгоор “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” хамтарсан Засгийн газрын гэрээг байгуулсан. Тус гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа:

Үндэсний эв нэгдэл, үндэсний эрх ашгийг эрхэмлэж, эрх зүйт төрийн үндсэн зарчмуудыг удирдлага болгон;

Улсын эрх ашиг нэгдүгээрт, улс төрийн намын эрх ашиг хоёрдугаарт, эцэст нь хувийн эрх ашиг байх зарчмыг үнэт зүйлээ болгон;

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийг зорин;

Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан нийгмийн бодлогын шинэчлэл, бүсчилсэн хөгжлийн бодлого, авлигагүй төр, шударга ёсыг бэхжүүлэх цахим засаглал, эхлүүлсэн томоохон төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилтууд, Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт туссан хүний хөгжил, хувийн өмчийн эрхийн хамгаалалт, технологи суурьтай мэдлэгийн эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга төрийн зорилтууд, ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан эрчим хүчний болон боловсролын салбарын шинэчлэл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг шинэчлэх, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн 4 чиглэлийг тодорхойлж, тэдгээрийн хүрээнд тус бүр 4 зорилго, нийт 593 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлж, бүс бүхэнд ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх бөгөөд **Хангайн** бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс”, **Баруун** бүсийг “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс” болгон, **Хойд** бүсийг “Байгалийн аяллын жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Говийн** бүсийг “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” болгон, **Төвийн** бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Зүүн** бүсийг “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд дараах 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө:

1.“Гашуунсухайт-Ганцмод”, “Ханги-Мандал”, “Шивээхүрэн-Сэхээ” хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

2.Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 3150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдолтой өмнөд бүсийн уул уурхайн төслийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангах боломж бүрдэнэ. “Оюутолгой” ХХК-ийн БНХАУ-аас импортолж байгаа 110-120 сая ам.долларын валютын урсгалыг зогсооно. Барилга угсралтын явцад давхардсан тоогоор 2000, ашиглалтад орсноор 3000 байнгын ажлын байр шинээр бий болно.

3.Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ. Тус төслийг хэрэгжүүлснээр Жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 2027 оноос эхлэн 100 хувь найдвартай, тасралтгүй хангах боломж бүрдэж, 52,000 ахуйн хэрэглэгчийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, баруун аймгуудын 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана. ОХУ, БНХАУ-аас жил бүр импортоор авч байгаа 17.5 тэрбум төгрөгийг хэмнэнэ.

4.Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц барина. Тус төслийг хэрэгжүүлснээр эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой, шуурхай ажиллагааг хангаж, системийн эх үүсвэрийн зохистой харьцааг бүрдүүлнэ. ОХУ-д жил бүр төлдөг 25 сая ам.долларын импортын төлбөрийг хэмнэнэ. Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438,7 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулна. 5.7 тэрбум шоо метр цэвэр усны нөөц бүрдүүлж, Монгол Улсын усан хангамжийн аюулгүй байдлыг хангана.

5.Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ. Монгол Улс нь судалгаагаар 2,600 гВт сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй болох нь тогтоогдсон бөгөөд шинээр эх үүсвэрүүдийг бий болгох замаар өсөн нэмэгдэж байгаа дотоодын цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхөх, бусад улс руу экспортлох боломжтой. Сэргээгдэх эрчим хүчний салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломж бүрдэж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрс хүчлийн хийн арилжаанд оролцож, нэмэлт орлого олох боломж нээгдэнэ.

6.Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах шугам барих төслийг хэрэгжүүлнэ. Хэрлэн голын олон жилийн дундаж урсцын 5-9%-ийг битүү хоолойгоор дамжуулан Хэнтий, Чойр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг бүрэн хангана. Жилдээ 30 мян.тн хүлэмжийн хийг бууруулна. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд усны асуудлыг шийдвэрлэж, цөлжилт, хуурайшилтыг сааруулна.

Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны түвшин тогтворжиж, Онги голын дагууд оршин сууж байгаа 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах нөхцөл бүрдэнэ. Агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж, цөлжилтийг бууруулна.

7.Эрээнцав-Чойбалсан-Баруун Урт-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, тээврийн зардлыг бууруулна.

8.Монгол, Францын хамтарсан уран, атомын цахилгаан станцыг барих төсөл хэрэгжиж, үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажилласнаар жилд 2,500 тонн ураныг олборлож экспортолно. Төсөл хэрэгжих хугацаанд улс, орон нутгийн төсөвт 1 тэрбум гаруй ам.долларын татвар төлнө. Үйлдвэрлэлийн туршилтын төсөл дээр үндсэн үйлдвэрлэлийн олборлолт эхлэхэд 1,000 гаруй ажлын байр бий болно. Улс, орон нутгийн хэмжээнд томоохон худалдан авалт, бизнесийн боломж нэмэгдэнэ.

9.Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, боловсруулах

Үйлдвэрлэлийг нэг шат ахиулснаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, олон улсын түүхийн эдийн үнээс хараат байдлыг бууруулах боломж бүрдэнэ.

Кокс-химийн үйлдвэрийн нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр шатанд 10 сая тонн коксжих нүүрсийг угааж, 5.4 сая тонн баяжуулсан нүүрс, 3 сая тонн завсрын бүтээгдэхүүн (мидлинг) үйлдвэрлэнэ. 2.7 сая тонн баяжуулсан нүүрсийг боловсруулж, 2 сая тонн хатуу кокс, 107 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Дотоодын хэрэглээнээс илүү гарсан 1.5 сая тонн коксын бүтээгдэхүүнийг экспортолно. “Алтанширээт” үйлдвэрлэл технологийн паркийг байгуулснаар 140 га талбайд төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн зэрэг дагалдах үйлдвэрүүд бүхий 500 мян.тн/жил ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр ашиглалтад орно.

10.Зэс боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 125 мянган тонн катодын зэс, 72 кг алт, 38.2 тонн мөнгөн гулдмай болон 182 мянган тонн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ. Катодын зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон түлхэц үзүүлнэ. Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.

11.Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр дотоодын тасралтгүй нэмэгдэж байгаа ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулж эхний ээлжид 500 мянган тонн ширэм, 500 мянган тонн ган бэлдэц үйлдвэрлэж, ган бэлдцээс барилгын арматур, булан төмөр, төмөр утас зэрэг ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын барилгын арматурын хэрэгцээг бүрэн хангана.

12.Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.

13.Оюутолгойг түшиглэсэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ. Тус төсөл хэрэгжсэнээр жилд гадаад орны алт цэвэршүүлэх үйлдвэрт цэвэршүүлж, мөнгөжүүлдэг алтны 70 хувийг дотооддоо цэвэршүүлэх боломж бүрдэнэ. Баяжуулсан алтны хувийг нэмэгдүүлж, олон улсын зах зээлд борлуулж, валютын орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улс алтаа одоог хүртэл гадаад орнуудад цэвэршүүлж байгаа бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор үүнтэй холбогдон гарах тээвэр, даатгал, хамгаалалтын зардлыг хэмнэнэ.

14.Үндэсний хиймэл дагуулыг хөөргөнө. Монгол орны нийт газар нутгийн 26.8 хувьд 4G сүлжээ нэвтэрсэн. Үлдсэн 73.2 хувь буюу орон нутгийн иргэд, малчин айл өрхийг шилэн кабелиар интернэт сүлжээнд холбоход шаардлагатай 29.0 их наяд төгрөгийг хэмнэж, улс орны өнцөг булан бүрд интернэтийн сүлжээ нэвтэрнэ. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, ослын үед газрын сүлжээнд саад, доголдол гарсан тохиолдолд сансрын холбооны сүлжээ нь найдвартай холбооны сүлжээ болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ц.Туваан, Ж.Баярмаа, Л.Гантөмөр нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.1.1.“20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын бичиг баримтыг боловсруулж, үүнд суурилсан “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040” болон бусад хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.2.Эрчим хүчээр хангагдсан хот” зорилгод доор дурдсан агуулгатай 1.1.2.12 дахь заалт нэмэх:

“1.1.2.12.Багануурын дулааны станцын зуух, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөн шинэчилж, засварлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.3.Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт” зорилгод доор дурдсан агуулгатай 1.1.3.7 дахь заалт нэмэх:

“1.1.3.7.Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, нийслэлийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор нэг удаа орон сууцны дулаалгын ажлыг хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 16  
Бүгд: 17  
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.



6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.3.5 дахь заалтын “татварын хөнгөлөлт” гэснийг “дэмжлэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.5.3 дахь заалтын “уялдаа холбоог хангаж,” гэсний дараа “зорчигч тээврийн логистик төвийн хамт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 4  
Бүгд: 17

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.2.1, 1.2.2-ийн гарчгийн “Дагуул хотуудын” гэсний өмнө “Улсын зэрэглэлтэй болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “1.3.4.Говийн бүс-“Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1.3.4.6.Даланзадгадад 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг барина.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.2.1 дэх заалтын “Номтын аманд” гэсний дараа “эрчим хүчний хэмнэлттэй” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 4  
Бүгд: 17

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.1.5 дахь заалтыг “3.3.7.Шинжлэх ухаан, технологи, инновац” гэсэн зорилтод шилжүүлэх:

“1.2.1.5.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.5.3 дахь дараах заалтыг хасах:

“1.3.5.3.Шүрэнгийн усан цахилгаан станц барина” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

13.Ажлын хэгсийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.4.3, 3.3.3.24, 3.3.3.25, 3.3.3.26, 3.3.3.31 дэх дараах заалтуудыг тус тус хасах:

“1.3.4.3.Говийн бүсэд нар, салхины тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барина.

3.3.3.24.Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт нар, салхины нөөцийн давхцалын бүсүүдийг түшиглэн 3 ГВт-ын нар, салхины сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барьж байгуулах, экспортлох төслүүдийг дэмжинэ.

3.3.3.25.Чойрт 100 МВт салхи, 40 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.

3.3.3.26.Мандалговь 200 МВт нарны цахилгаан станц, 100 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.

3.3.3.31.Мандалговийн 2,000 Мвт нар-салхины эрчим хүчний паркийн төслийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ дээрх саналыг хүчингүйд тооцох санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.4.2.Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилт” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1.4.2.7.Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 4  
Бүгд: 17  
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.23 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.1.23.Төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 4  
Бүгд: 17  
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.3.11 дэх дараах заалтыг хасах.

“2.1.3.11.Орлого багатай иргэдийн нэмэлт орлогын эх үүсвэрээс авах татварыг бодлогоор бууруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 4  
Бүгд: 17  
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.1.9.Өсвөр үеийн охид, хөвгүүдийн дунд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, үе тэнгийн зөвлөгч бэлтгэх, тэднээр дамжуулан мэдээллийг өсвөр үеийнхэнд хүргэх, шаардлагатай үйлчилгээнд зуучлах нууцлалтай чатбот үйлчилгээг хөгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.1.11.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг баталж, төр болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.3.Нийгмийн баталгаа” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.3.17.Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.3.3 дахь заалтын “мастер төлөвлөгөөг” гэсний дараа “хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.2.7 дахь зорилтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.4.2.7.Үл хөдлөх салбарын хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.1.3.Банк, санхүү, даатгалын салбарын реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.1.3.11.Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжиж эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандартын дагуу баригдах амины орон сууцны ипотекийн зээл болон жижиг дунд үйлдвэрийн тогтвортой, ногоон зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор “Монголын ногоон санхүүгийн корпорац”-ыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.2.Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин” зорилтод доор дурдсан агуулгатай 3.2.2.14 дэх заалт нэмэх:

“3.2.2.14.Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.1.Татвар, нийгмийн даатгалын реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.2.1.8.“Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг шинэчилнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Туваан, О.Алтангэрэл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 12  
Бүгд: 17  
29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.12 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.3.12.“10,000 нарны дээвэр” хөтөлбөрийг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтын 3.3.2.18, 3.3.2.20 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.2.18.Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил дамнасан төмөр замуудыг барьж хөрш орны төмөр замтай холбоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтын 3.3.1.13, 3.3.2.17 дахь дараах заалтуудыг хасах:

“3.3.1.13.“Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.”

“3.3.2.17.“Сайншанд-Баруун-Урт-Хөөт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 16  
Бүгд: 17  
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.1 дэх заалт, 3.3.1.7 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.1.Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.2 дахь заалтын “Геологийн эрэл хайгуулын” гэснийг “Геологийн судалгаа, эрэл, хайгуулын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.3.Оюутолгойг түшиглэсэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.4 дэх дараах заалтыг хасах.

“3.3.1.4.Оюутолгойтой дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.6 дахь заалт, 3.3.1.12 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.5.Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1.Уул уурхай” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.3.1.11.Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн зэс, молибдений ордын талбайн хил заагийн хүрээнд багтаж буй Оюут болон бусад хэсгүүдэд эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг тогтоож, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлэх, эрэл, хайгуулын ажилд дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.6.Соёлын бүтээлч үйлдвэрлэл” гэсэн гарчгийг “3.3.6.Соёл урлаг, соёлын өв уламжлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.6.4.Түүхэн дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, “Соёлын биет өвийг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилгод доор дурдсан агуулгатай 3.3.2.24 дэх заалт нэмэх.

“3.3.2.24.Эрээнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилгод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.3.4.29.Мал аж ахуй, газар тариалан, жимс, хүнсний ногоо тариалалтад дэмжлэг үзүүлэх зорилготой хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн түрээсийн аж ахуйн тогтолцоог бий болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.5.Дөрвөн улирлын аялал жуулчлал” гэсэн зорилгод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.3.5.12.Дундговь аймгийн Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6



Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр, логистик” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.25 дахь заалт нэмэх:

“3.3.2.25.Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4D ангилалын болгон өргөтгөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн зорилтод “3.3.3.42.Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Чойр-Сайншанд чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг тус тус барина.” гэсэн заалт нэмж, 3.3.3.30 дахь заалтаас “Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ,” гэснийг, 3.3.3.37 дахь заалтаас “Тавантолгойн ДЦС-Оюутолгой,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17  
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.38 дахь дараах заалтыг хасах.

“3.3.3.38.Аймгийн төвүүд, сум суурин газруудын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулах, үр ашиг өндөртэй нүүрс, сэргээгдэх эрчим хүчний технологийг ашигласан станцуудыг байгуулах суурь судалгааг хийх, төслүүдийг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17  
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.41 дэх дараах заалтыг “1.4.1.Шилжилт хөдөлгөөн” гэсэн зорилтод шилжүүлэх.

“3.3.3.41.Төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг нь харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11

Бүгд: 17  
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4.4 дэх заалтын “экспортлоход анхаарна” гэснийг “экспортолно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилгод доор дурдсан агуулгатай 3.3.2.26 дахь заалт нэмэх.

“3.3.2.26.Ханх-Хатгал чиглэлийн автозамыг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.35 дахь дараах заалтыг хасах:

“3.3.3.35.Дархан УХУЦС 100 МВт төслийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.7.1 дэх заалтын “Шинжлэх ухаан” гэсний өмнө “Шинжлэх ухаан технологийн арга хэмжээний зардлыг ДНБ-ий 1%-д хүргэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.7.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.7.7.Үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн сангийн MORI платформыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэдлэгийн Data center байгуулна” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 3.3.4.3 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.4.3.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 10

Бүгд: 17

41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 9

Бүгд: 17

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4. Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.29 дэх заалт нэмэх:

“3.3.4.29.Хоршоодод “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг байгуулах, хувьцаа эзэмших, хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлж, хоршооны үйл ажиллагааг дэмжинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.4.3.Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар” зорилтод доор дурдсан агуулгатай 3.4.3.11 дэх заалт нэмэх:

“3.4.3.11.Орхон-Онги, Хэрлэн-Тоонот ус дамжуулах шугамыг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.5.Парламентын засаглал ба эрх мэдлийн хяналт, тэнцэл” зорилтын гарчиг болон 4.1.5.1 дэх заалтыг хасаж, 4.1.5.2 дахь заалтыг “4.1.1.Хүний эрх” зорилтын 4.1.1.6 дахь заалт болгон шилжүүлж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.1.5.1.Улс орны хөгжлийн амин чухал асуудлаар үндэсний зөвшилцөлд хүрч, төрийн залгамж чанар, бодлогын тогтвортой байдлыг хангах бөгөөд улс төрийн намуудыг нийтийн эрх ашгийн төлөө үйлчилдэг бодлогын институц болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, хатуу гишүүнчлэлээс татгалзаж, санхүүжилтийг ил тод болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.6.5. дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.6.5.Хууль зүйн дэд бүтцийг хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.2 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.2.“Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр” батлуулж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 12  
Бүгд: 17  
29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.15 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.15.Монгол Улсын Үндсэн хууль, хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн байгууллагын захиалгаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий Хууль судлалын институтыг байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.17 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.17.Үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.18 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.18.Хорих ял эдлүүлэх орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор "Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага"-ын цогцолбор барилгыг ашиглалтад оруулж хүний эрхийг хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.2.Хэвлэлийн эрх чөлөө” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.2.2 дахь заалт нэмэх:

“4.1.2.2.Олон нийтийн радио, телевизийн бие даасан байдлыг хангах, хариуцлагатай, хараат бус, иргэдийг соён гэгээрүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн нийтлэлийн бодлоготой болгох чиглэлээр эрх зүйн орчныг шинэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.4 дэх заалтыг хасах:

“4.2.1.4.Авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулах, хууль сахиулах байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх болон нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.15.Тагнуулын үйл ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагааны зааг ялгааг тодорхой болгож, эрх зүйн орчныг тус тусын хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.11 дэх дараах заалтыг хасах:

“4.2.3.11.Төрийн албан хаагчдын цахим мэдээллийг өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.3 дахь заалтын “Авлига” гэсний өмнө “Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг үргэлжлүүлж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.2.3.12.Хууль сахиулагчдын мэргэшил, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулж, хууль сахиулагч болон хууль сахиулах албаны эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, эрх зүйн орчныг бий болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.4.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.4.3.Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“4.2.3.Төрийн албаны шинэчлэл**

4.2.3.1. Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурласан захиргааны оновчтой, уян хатан, үр дүнтэй, үр ашигтай төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний төрлийг оновчилж, чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, цомхон, төрийн албыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулан, төрийн захиргааны албан хаагчдын тоог үе шаттайгаар зохистой хэмжээнд хүргэнэ.

4.2.3.2. Хяналт шалгалт, хүний нөөцийн аудитын тогтолцоог оновчтой бүрдүүлж, хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэл, үр дүнд суурилан үнэн зөв, бодитой хийж, олон улсын үнэлгээнд нийцүүлнэ.

4.2.3.3. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлж, төрийн мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халах, иргэн, хуулийн этгээд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.3.4. Эрх мэдлийн төвлөрөл үүсгэсэн хууль тогтоомжийг өөрчилж, хөгжлийн чиг хандлага, бүсчилсэн хөгжилд нийцүүлэн, төрийн албаны хууль тогтоомжийн шинэтгэлийг эрчимжүүлнэ.

4.2.3.5. Төрийн албанд ёс зүйн төлөвшлийг бэхжүүлж, ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг бий болгох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагад хэрэгжүүлэх, төрийн албаны чадамжид суурилсан хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд ёс зүйн хэм хэмжээ, шалгуур үзүүлэлтийг суурь болгоно.

4.2.3.6. Төрийн албан хаагчийг улс төр, удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалт, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчмыг хангах, эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамтран хамгаалах боломжийг бүрдүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгон, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.

4.2.3.7. Төрийн албаны хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулж, төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг гадаад улс орны болон ахисан түвшний сургалтад хамруулах чиглэл баримтална.

4.2.3.8. Төрийн албаны сургалтын байгууллагын бүтэц, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.2.3.9. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төрийн албан хаагчийг адил, тэгш боломжоор хангана.

4.2.3.10. Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, цахим мэдээллийг албан хаагчдад өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлэн, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хангана.



4.2.3.11.Төрийн албанд сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх, боловсруулах, монгол хэлийг ярианы болон бичгийн өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах хэлбэр, эрх зүйн орчныг шинэчлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, С.Зулпхар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 15  
Бүгд: 17  
11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

66.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.3.1.“E-Mongolia”-блок чейн-Цахим засаглал” зорилтод доор дурдан агуулгатай 4.3.1.6 дахь заалт нэмэх:

“4.3.1.6.Засгийн газрын тусгай сангуудын санхүүжилт, сонгон шалгаруулалтыг цахимжуулж ил тод болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

67.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.2.15 дахь заалтын “дээшлүүлэх шаардлага улам нэмэгдэж байна” гэснийг “дээшлүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

68.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.4.10 дахь заалтын “Гамшгийн зураглал, эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах механизмыг хөгжүүлнэ.” гэснийг “гамшгийн зураглал, байгаль орчин, уур амсгалын эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах механизмыг хөгжүүлж, олон нийтэд нээлттэй болгоно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

69.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.1.6, 4.4.1.7, 4.4.1.8, 4.4.1.9, 4.4.1.10, 4.4.1.11 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.1.6.Хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлэх, мэргэшсэн хилчин, технологид суурилсан хил хамгаалах албыг бэхжүүлэн, зэвсэглэл, инженер, дохиолол хамгаалалт, радио релейн болон хяналтын систем, цэргийн холбоо, техник, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, тусгай хэрэгслээр бүрэн хангаж, хилийн цэргийн нисэх анги байгуулан,

нисдэг тэрэг, нисэх онгоц ашиглах замаар хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн дэглэмийн гэрээг хэрэгжүүлнэ.

4.4.1.7.Хилийн боомтын сэргэлтийн бодлоготой уялдуулан авто зам, төмөр зам бүхий боомтуудад шалган нэвтрүүлэх анги байгуулж, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, ухаалаг цахим гарц, дохиолол хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, тоног төхөөрөмжөөр хангана.

4.4.1.8.Хилийн цэргийн анги, салбарын албаны барилга, орон сууцыг шинэчилж, хилчдийн алба хаах, амьдрах нөхцөлийг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

70.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.2.4 дэх дараах заалтыг хасах:

“4.4.2.4.Гадаад бодлогын үзэл баримтлалыг сансар судлал, шинжлэх ухаан, технологийн салбар дахь дэлхийн чиг хандлагатай нийцүүлэн шинэчилнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

71.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад “Үр дүн” баганад “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулах” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2023” гэж, “Суурь түвшин” баганад “76.2 %” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “77%” гэж, “2026 он” баганад “78%” гэж, “2027 он” баганад “79%” гэж, “2028 он” баганад “80%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “ҮСХ” гэж, “Мэдээлэл цуглуулах арга” баганад “Статистик мэдээ” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

72.Ажлын хэсгийн гаргасан, Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн болон хавсралтын нэр томьёог жигдлэх, бүлэг, зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Төслийн талаар бусад Байнгын хороодоос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.2.20 дахь дэд заалт нэмж, үүнтэй холбогдуулан дугаарыг өөрчлөх:

“3.3.2.20.Даянгийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Л.Гантөмөр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 14  
Бүгд: 17  
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайханы гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “1.3.5.Төвийн бүс – “Хөдөө аж ахуйн төрөлжсөн,аж үйлдвэрийн дэд бүс” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 1.3.5.7 дахь дэд заалт нэмэх:

“1.3.5.7.Дарханы арьс ширний үйлдвэрийг барьж дуусгах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1.“Уул уурхай” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.1.15 дахь заалт нэмэх:

“3.3.1.15.Нүүрс-химийн технологийг эзэмших, боловсон хүчнээ бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулан хийн түлш, нийлэг материал, ус төрөгч гарган авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.3.42 дахь заалт нэмэх:

“3.3.3.42.Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн зүйлийн “4.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” гэсэн хэсгийн “4.4.3.Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тогтолцоо” гэсэн заалтын 4.4.3.7 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.3.7.“ЭХ ОРНЫ ДУУДЛАГА - ЭР ЦЭРГИЙН АЛБА”-ны хүрээнд батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, цэргийн албаны төрлийг нэмэгдүүлэх замаар Зэвсэгт хүчин, алба хаагчийн олон нийтийн дэмжлэг, нэр хүндийг дээшлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтын “уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв,” гэсний дараа “шинжлэх ухаан,” гэж “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний” гэсний өмнө “Технологи,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн зүйлийн “4.4.Үндэсний сөрөн гэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” гэсэн хэсгийн “4.4.1.Үндэсний эв нэгдэл” гэсэн заалтын 4.4.1.3 дахь дэд заалтын “ёс суртахууны доголдол,” гэснийг хасах, 4.4.1.4 дэх дэд заалтын “ёс зүйтэй” гэснийг “хариуцлагатай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.4.2 дахь дэд заалт нэмэх:

“3.3.4.2. Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохтой холбогдуулан зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлж хоршооны гишүүн малчинд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.4.3 дахь дэд заалт нэмэх:

“3.3.4.3. Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 11

Бүгд: 17

35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.1.1. дэх заалтын “Байгалийн төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөн, хамгаалалтын менежментийг сайжруулна.” гэснийг “Байгалийн төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нэмэлт тайлбар шаардлагатай тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга дээрх саналтай холбогдуулан үг хэлэв.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 12  
Бүгд: 17  
29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.3.7 дахь дэд заалтын “үйл ажиллагааг дэмжин” гэсний дараа “Үндэсний ногоон барилгын үнэлгээний систем нэвтрүүлж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 3.4.2.9 дэх заалт нэмэх:

“3.4.2.9.Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж эрчим хүч, усны ухаалаг хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 3.3.4.29 дэх заалт нэмэх:

“3.3.4.29.Малчдад эрчим хүчний хэмнэлттэй өвлийн жишиг сууцны загвар түгээж, мэдлэг олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 9

Бүгд: 17

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.5 дахь заалтын “Төвийн бүс-Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” гэснийг “Төвийн бүс-Эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэржилт, эрчим хүчний дэд бүс.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 12

Бүгд: 17

29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4 дэх заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, залуу малчид, тариаланчдыг бэлтгэх зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4 дэх заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“Сорт, сорилын төв, үрийн аж ахуйг дэмжиж, үрийн шинэчлэл хамгаалалтыг сайжруулан, гол нэр төрлийн тариалангийн үр үйлдвэрлэлд урамшуулал олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4 дэх заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мян.тн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ёс зүй, дэгийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” хэсэгт доор дурдсан агуулгатай 4.2.3.12 гэсэн дэд хэсэг нэмэх:

“4.2.3.12 “Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” хэсэгт доор дурдсан агуулгатай 4.2.3.13 гэсэн дэд хэсэг нэмэх:

“4.2.3.13 “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” /2024-2030 он/ дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууны үнэт зүйл бүхий сэтгэл зүйг төлөвшүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” хэсэгт доор дурдсан агуулгатай 4.2.3.14 гэсэн дэд хэсэг нэмэх:

“4.2.3.14 ”Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад **13** “Үр дүн” баганад “Ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн хороо, дэд хороодын чадавхийн үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “20” гэж, “2026 он” баганад “30” гэж, “2027 он” баганад “40” гэж, “2028 он” баганад “50” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхийн судалгаа” гэж, ”Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг



удаа” гэж, 14 “Үр дүн” баганад “Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн зөрчлийн бууралт, нийгмийн нөлөөллийн үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “Батлагдсан хөтөлбөр” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “30” гэж, “2026 он” баганад “50” гэж, “2027 он” баганад “75” гэж, “2028 он” баганад “85” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Олон эх үүсвэр” гэж, ”Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил бүр” гэж, 15 “Үр дүн” баганад “Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн үзүүлэлт” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “10” гэж, “2026 он” баганад “15” гэж, “2027 он” баганад “25” гэж, “2028 он” баганад “35” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Төрийн албаны олон улсын индекс (InCiSE)-ийн ёс зүйн (INT) үзүүлэлт” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Үндэсний үзүүлэлтийн судалгаа” гэж, ”Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.21 дэх хэсгийн “стандартыг” гэсний дараа “албан байгууллага, ”гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 4  
Бүгд: 17  
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Тогтоолын төсөлд дор дурдсан агуулгатай 2.3.2.8 дахь дэд заалт нэмэх:

“2.3.2.8.сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар, цогц байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Тогтоолын төсөлд 2.1.2.10 “хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулна.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Тогтоолын төслийн 2.2.3.2-н “Багшлах эрх олгох хялбаршуулсан сургалтын тогтолцоог бий болгож” гэснийг “Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн” гэж өөрчлөн, “бэлтгэх замаар” гэсний дараа “багшлах хүний нөөцийн чадавхыг сайжруулж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.2.10 дахь хэсэгт “Суралцангаа хөдөлмөрлөх /хөдөлмөрлөнгөө суралцах хосмог ажлын байрыг нэвтрүүлэхтэй уялдуулан дадлагажигчийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.30 дахь заалтын “төрийн бүх шатны байгууллагууд залуу мэргэжилтнүүдийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.31 дахь заалтын “залуу гэр бүлд зориулсан урьдчилгаа төлбөр, хүүгийн таатай нөхцөл бүхий орон сууцны тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Тогтоолын төсөлд “4.1.3.4 иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог баталгаажуулан бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцооны тодорхой шалгуур үзүүлэлт бүхий нийтлэг журмыг батлах. Төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшинг жил бүр үйлчилгээг

хүртэгч төрийн бус байгууллага, иргэдээр үнэлүүлж индексжүүлэх.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Тогтоолын төсөлд “4.1.3.5 иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурынхны нийгэм-эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үндэсний тооцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.19 дэх заалтын ”инфляц” гэснийг “өмнөх оны инфляцийн жилийн дундаж болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Тогтоолын төслийн 2.1.2.6-н “Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж” гэсний дараа “жил бүр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Тогтоолын төсөлд “4.1.3.4 тендэр үнэлгээнд төсөл хөрөнгө оруулалт шууд дам нөлөөлөл, хүртээмж нэмэх, нийгмийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бий болгоно” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17

35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Саранчулуун нарын гаргасан, Тогтоолын төслийн 2.3.4.3 дахь заалтын “эрүүл мэндийн ажилтны” гэсний дараа “цалин хөлс,” гэж нэмэх, “алслагдсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.23 дахь заалтын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулах” гэж нэмэх, “хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 9

Бүгд: 17

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.2.2-д “Хөдөлмөрийн зах зээлд эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан цалин хөлсний тогтолцоог бий болгоно.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралт 1-н Хүний хөгжлийн бодлогын 2.1.1.2-дахь заалтын “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймагт дүүрэгт төр хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулна” гэснийг “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймагт дүүрэгт төр хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийг ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн нөхцөлийг бүрдүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 9

Бүгд: 17

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

### **Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 1.3.3.6 дахь дэд хэсэг нэмэх:

“1.3.3.6.Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт авто зам барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад “олон улсын ур чадварын үзүүлэлт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг хүүхэд хамгаалах сан, хүүхдийн эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн зарцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 4.2.1.8 дахь дэд хэсэг нэмэх:

“4.2.1.8.авлигатай тэмцэх газрын салбарыг 21 аймагт байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.2.2 дахь заалтын “Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин” гэсэн хэсэгт доор дурдсан агуулгатай дэд заалт шинээр нэмэх:

“Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний гадаад экспортыг нэг цонхны бодлогоор дэмжинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1 дэх заалтын “Уул уурхай” гэсэн хэсэгт доор дурдсан агуулгатай дэд заалт тус тус шинээр нэмэх:

“1.Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон, ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад оруулахад бэлэн болгоно.

2.Эрдэнэтийн стратегийн ордын талбайн эрэл хайгуулын ажлын хүрээнд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан дахин шинэ стратегийн орд нээж, ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 15

Бүгд: 17

11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3 дахь заалтын “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн хэсэгт доор дурдсан агуулгатай дэд заалт шинээр нэмэх:

“Эрчим хүчний салбарт реформ хийж, салбарын эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчилнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 11

Бүгд: 17

35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3 дахь заалтын 3.3.3.37 дахь дэд заалтаас “Сонгино-Дархан” гэснийг хасаж, доор дурдсан агуулгатай 3.3.3.42 дахь заалт нэмэх:

“3.3.3.42. Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** 1. Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.1. Татвар, нийгмийн даатгалын реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.1 дэх заалтыг өөрчлөн найруулах:

“4.2.3.1. чадахуйн зарчимд суурилсан оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлж, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэн, төрийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгож, төрийн захиргааны албан хаагчдын тоог зохистой хэмжээнд хүргэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.6 дахь заалтыг өөрчлөн найруулах:

“4.2.3.6. Төрийн албан хаагчийг улс төрчийн болон удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалтаас ангид байлгах, эрх ашгаа хамтран хамгаалах боломж бүрдүүлж, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.8 дахь заалтыг өөрчлөн найруулах:

“4.2.3.8.Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг төрийн албаны шинэчлэлд нийцүүлж, сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 12  
Бүгд: 17  
29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.4.“Орон нутгийн засаглалын бие даасан байдал” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийг боловсронгуй болгох замаар боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүн амын тоотой уялдуулан хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17  
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.9.Төрийн албан хаагчдын цалин хөлс нийгмийн баталгааны зохистой бодлого баримтлан орон сууцын хүртээмжийг нэмэгдүүлнэ. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэдэд хөдөлмөрлөх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэх, орлого олох, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 13  
Бүгд: 17  
23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.4.Цахимжсан боловсрол” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.2.4.5.Сургалтын байгууллагын интернэтийн дэд бүтцийг сайжруулах, хүүхэд бүрийг компьютержуулахад санхүүгийн түрээс гэх мэт арга хэрэгслийг нэвтрүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9



Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 2.2.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.2.4.1.Боловсролын бодлого, санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хүн ам, орон зайн их өгөгдөлд тулгуурласан хиймэл оюун ухаан ашиглах замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, үр ашгийг сайжруулах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр 2.2.1“Тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Үндэсний цөөнхийн бага, дунд боловсрол эзэмших эрхийг хангах, “Хос хэл”-ний бодлого, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.10.Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, мэдээллийн ил тод, үнэн зөв, бүрэн бүтэн байдалд хяналт тавих нөхцөлийг хангасан төрийн албаны хүний нөөцийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлэн, өгөгдөлд суурилсан хүний нөөцийн удирдлагын бодлогыг оновчтой, шинжлэх ухаанч байдлаар зөв төлөвлөж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.11.Төрийн албанд сэтгэлгээний болон дүн шинжилгээ хийх, асуудлыг оновчтой, шуурхай шийдвэрлэх өндөр ур чадвартай иргэнийг сонгон

шалгаруулах аргыг нэвтрүүлж, эрх зүйн орчныг шинэчилнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.13.Нууц мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчныг хүний эрхийг дээдлэх зарчимд тулгуурлан тодорхой болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 14  
Бүгд: 17  
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

13.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.43 дахь заалт нэмэх:

“3.3.3.43.Мөрөн хотод 50 мВт-аас доошгүй хүчин чадалтай дулааны цахилгаан станц байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 15  
Бүгд: 17  
11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

14.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.44 дэх заалт нэмэх:

“3.3.3.44.Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 14  
Бүгд: 17  
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.27 дахь заалт нэмэх:

“3.3.2.27.Хутаг-Өндөр сумаас Бага илэнхийн хилийн боомт хүртэл 146 км хатуу хучилттай авто замыг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 14

Бүгд: 17

17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2. Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.28 дахь заалтыг нэмэх:

“3.3.2.28 Эрдэнэт хотын доторх авто замын барилга угсралт, шинэчлэл, өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 14

Бүгд: 17

17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

17.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2 “Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.29 дэх заалт нэмэх:

“3.3.2.29.Мөрөн-Их-Уул-Рашаант-Өлзийт-Хайрхан-Тэрхийн цагаан нуур босоо чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж дуусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 13

Бүгд: 17

23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1.1.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.3.2.Цэвэрлэх байгууламжийн тархмал дэд төвүүдийг шинээр байгуулах, бие даасан, бага оврын ариун цэврийн байгууламжийн хэрэглээг бодлогоор дэмжих замаар нүхэн жорлонгийн тоог 2 дахин бууруулж, хөрсний бохирдлыг бууруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 14

Бүгд: 17  
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

19.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.5.Төрийн албаны ёс зүйн зарчмуудад үндэслэсэн суурь шалгуур үзүүлэлтийг боловсруулж, төрийн албаны чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 15  
Бүгд: 17  
11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

20.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтын “Хүүхэд” хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Хичээлээс гадуур үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17  
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

21.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.6 дахь заалт нэмэх:

“3.3.4.6.Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах үүднээс малчдын өвөлжөө, хаваржааны доорх газрын хоорондын доод зай хэмжээг, мөн гүний худгийн цооног хоорондын доод зай хэмжээг тогтоох, дээрх газруудыг эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэхийг хориглох, зөвхөн үр хүүхдэдээ өвлүүлдэг байх эрх зүйн өөрчлөлт оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 14  
Бүгд: 17  
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.4.1.Баялагтаа эзэн Монгол хүн” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг Засгийн газартай байгуулсан аж ахуйн нэгжүүд уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэлд хамруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 14  
Бүгд: 17  
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

23.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.3.Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Гэр хорооллын бүсэд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон, пассив барилгын стандарт болон ногоон санхүүжилтийн шаардлага хангахуйц бие даасан инженерийн шийдэлтэй, загвар хорооллыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн барьж байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.3.3.Сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийг пассив барилгын стандартад нийцүүлж, эрчим хүчний хэмнэлттэй технологи руу шилжих арга хэмжээ авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.4.1.Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг харгалзан боловсруулан батлуулж, үүнтэй уялдуулан төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

26.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.4.Орон нутгийн бие даасан байдал” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.4.4 заалт нэмэх:

“4.2.4.4.Хороо, багийн хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.1.Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Хүүхэд хөгжлийн STEAM боловсрол олгох ордныг дүүргүүдэд байгуулах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 10

Бүгд: 17

41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

28.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.1.Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Улс төр дэх мөнгөний зохисгүй нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах ажиллагааг зогсооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Эрсдэлийн удирдлага” гэсэн бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “4.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” гэсэн хэсэгт 4.4.5 дахь зорилт болгон шилжүүлж, 4.4.4 дэх зорилтын гарчгийн “Эрсдэлийн удирдлага” гэснийг хасах:

“4.4.5.Эрсдэлийн удирдлага

4.4.5.1.Геополитикийн тогтворгүй байдал цар тахлын үеийн болон дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, хиймэл

оюун ухаан, кибер аюулгүй байдал ба дэвшилтэт технологийн хурдацтай шилжилтийн тодорхой бус байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл болон бусад эрсдэлийг даван туулах хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай авах зорилгоор холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв мөнгөний бодлогын уялдааг хангасан эрсдэлийн удирдлагын цогц бодлого, төлөвлөгөөг гарган хэрэгжүүлнэ.

4.4.5.2.Эрсдэлийг урьдчилан илрүүлэх, үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах, хэрэгжилтэд үнэлгээ хийх системийг хөгжүүлж, эрсдэлийн удирдлагын шинэчлэлийг эхлүүлнэ.

4.4.5.3.Хамтрагч, түншлэгч талууд болон олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх, солилцох нөхцөлийг бүрдүүлж, хамтын итгэлцлийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд гадаад болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.4.5.4.Эрсдэлийн удирдлагын үе шат бүрд иргэн, хуулийн этгээдийн оролцоог хангаж, урамшуулах бодлогыг дэмжинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.3.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.4.3.5.Хот, суурин газарт үерийн эрсдэлийн үнэлгээг ерөнхий болон нарийвчилсан байдлаар хийж, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулж, үе шатаар хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.4.Орон нутгийн засаглалын бие даасан байдал” зорилтот дор дурдсан агуулгатай 4.2.4.1 дэх заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.2.4.1.Орон нутгийн засаглалын бие даасан байдлыг бэхжүүлэх хүрээнд орон нутгийн босоо удирдлагатай байгууллагуудын томилгооны асуудлыг орон нутагт нь шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтын “мэдэгдэл” гэснийг “Мэдэгдлийн” гэж, “төлөвлөгөө” гэснийг “төлөвлөгөөний” гэж, 3 дахь заалтын “төрөлжсөн” гэснийг “төрөлжсөн бүс бөгөөд” гэж тохиолдол бүрд, тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.6.1 дэх заалтын “Алтай овоо” гэснийг “Алтан овоо” гэж, 2.1.1.7 дахь заалтын “гэр бүл, хүүхэд хөгжил, хамгааллын” гэснийг “гэр бүлийн” гэж, 2.1.1.12 дахь заалтын “хөгжил, нийгмийн” гэснийг “хөгжлийн болон нийгмийн” гэж, 2.2.1.4 дэх заалтын “тохируулгад” гэснийг “тохируулгат” гэж, 2.2.1.9 дэх заалтын “чиглэнэ” гэснийг “чиглүүлнэ” гэж, 2.2.1.13 дахь заалтын “төгсдөг” гэснийг “төгсөх” гэж, 1.1.1, 3.1.3, 3.2.1, 4.2.3 дахь заалтуудын гарчгийн, мөн 3.3.3.40 дэх заалтын “реформ” гэснийг “шинэчлэл” гэж, 3.1.3.3 дахь заалтын “реформыг” гэснийг “шинэчлэлийг” гэж, 3.2.2.5 дахь заалтын “хүч” гэснийг “хүчний” гэж, 3.2.2.9, 3.2.2.10 дахь заалтын “баталж” гэснийг “батлуулж” гэж, 3.2.2.10 дахь заалтын “саад тотгорыг” гэснийг “саадыг” гэж, 3.3.5.10 дахь заалтын “марс гэдэгт” гэснийг “Марс гарагтай” гэж, 3.3.6.7 дахь заалтын “концепцоор” гэснийг “агуулгаар” гэж, 4.1.1.3 дахь заалтын “мөрдөн хавчигдсан” гэснийг мөрдөн хавчигддаггүй байх гэж, 4.1.2.1 дэх заалтын “ёс зүй” гэснийг “ёс зүйг баримтлан” гэж, 4.3.2.4 дэх заалтын “IoT” гэснийг “юмсын интернэт” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.4.1 дэх заалтын “хөдөлгөөн” гэсний өмнө “замын” гэж, 2.1.1.29 дэх заалтын “хөтөлбөрт” гэсний өмнө “сургалтын” гэж, 2.1.4.2 дахь заалтын “шигшээ” гэсний өмнө “үндэсний” гэж, 2.2.1.6 дахь заалтын “эдийн засгийн” гэсний дараа “хувьд” гэж, 3.2.2.5 дахь заалтын “төлбөрөөс” гэсний өмнө “ажлын байрны” гэж, 3.4.1.1 дэх заалтын “төрөхийн” гэсний өмнө “унаган” гэж, 4.2.1.12 дахь заалтын камерын гэсний дараа “хяналтын” гэж, 4.3.1.3 дахь заалтын “зэрэг бүх салбарт” гэснийг “болон бусад салбарт” гэж, 4.4.2.1 дэх заалтын “суурь” гэсний өмнө “гадаад бодлогын” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.1.7 дахь заалтын “дээд зэргээр” гэснийг, 2.2.4.2 дахь заалтын “дижитал” гэснийг, 3.1.1.3 дахь заалтын “Монгол Улсын Үндсэн хуульд заасан” гэснийг, 3.2.2 дахь заалтын “багц” гэснийг, 3.2.2.4 дэх заалтын “цахим” гэснийг, 3.3.4.4 дэх заалтын “ялангуяа” гэснийг, 4.3.2.5 дахь заалтын “аливаа” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.*



Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 43 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн *ирцтэйгээр* 16 цаг 15 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим,  
11 цаг 32 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Ж.Бат-Эрдэнэ хүрэлцэн ирсэн. Д.Амарбаясгалан ирээгүй байна. О.Алтангэрэл хүрэлцэн ирсэн. Б.Батбаатар хүрэлцэн ирээгүй байна. Шижир гишүүн хүрэлцэн ирсэн. Б.Баярбаатар гишүүн хүрэлцэн ирсэн. Ж.Баярмаа хүрэлцэн ирсэн. Болормаа гишүүн хүрэлцэн ирсэн. С.Бямбацогт гишүүн ирсэн. Л.Гантөмөр гишүүн хүрэлцэн ирсэн. Доржханд гишүүн хүрэлцэн ирсэн. С.Зулхар гишүүн хүрэлцэн ирсэн. Мөнхбаатар гишүүн ирээгүй байна. Найдалаа гишүүн хүрэлцэн ирсэн. Номтойбаяр гишүүн сая байсан даа. Ирсэн байсан. Э.Одбаяр алга байна. Л.Оюун-Эрдэнэ байхгүй. Б.Пүрэвдорж гишүүн алга байна. Ц.Сандаг-Очир гишүүн хүрэлцэн ирсэн. Ц.Туваан гишүүн хүрэлцэн ирсэн. О.Цогтгэрэл гишүүн хүрэлцэн ирсэн. Л.Энх-Амгалан гишүүн алга байна. Ингээд ирц бүрдсэн тул хуралдааныг эхлүүлье. Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Алга байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийн нэрс байна уу. Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрхэмбаярын Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч, Сандагийн Магнайсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, П.Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн

яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Нямдэлэгийн Мандуул Нийслэлийн Засаг даргын орлогч, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлогын зохицуулалтын газрын дарга, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Даваасамбуугийн Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Амгалангийн Ананд Гадаад харилцааны яамны Америк, ойрх Дорнод, арлын орнуудын газрын захирал, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга, Зэнээмядарын Батбаяр Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга, Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Доржсаламын Гантулга Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга, Пүрэвдоржийн Оюунаа Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Баасанжавын Болор-эрдэнэ Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Сүхбаатарын Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Малчзоогийн Мэндбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уурхай бодлогын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, Тогоогийн Гантогтох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга байлгүй дээ. Г.Энхтүвшин Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн газрын дарга, Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Отгонтогтохын Энхмөнх Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төлөвлөлтийн төсөөллийн хэлтсийн дарга, Очиржанцангийн Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого төсөөллийн хэлтсийн дарга. 2 даргатай юм уу. Эрдэнэбатын Батболд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны с, Салбарын хөгжил, Орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн дарга, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Мөнхөөгийн Батбаяр Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн яам сайдын зөвлөх, Батсуурийн Баттөмөр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх, Пэрэнлэйн Мөнхбат Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Б.Ганбат Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын

зөвлөх, Эрдэнэбатын Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч. Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Ажлын хэсгийн танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ажлын хэсгийн танилцуулга.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 38 дугаар захирамжаар тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээр ахлуулан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахшиг, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэг Улсын Их Хурлын 21 гишүүнээс 148 санал, мэдээллийн холбооны операторуудын ассоциаци, Монголын оюуны өмч хамгаалах холбоо төрийн бус байгууллагаас болон холбогдох яамнуудаас 45 санал ирүүлсэн болно.

Ажлын хэсэг тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхдээ дээрх саналууд болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бусад чуулганы нэгдсэн хуралдаанаар

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хэлэлцэх үед давхардсан тоогоор нийт 51 гишүүнээс хэлсэн саналыг судлан 72 зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэн Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Зарчмын зөрүүтэй саналуудын томъёолол агуулгын хувьд дараах хүрээг хамарч байна.

1.Тогтоолын төслийн хавсралтын өмнөтгөл хэсэгт тусгагдсан танилцуулгын шинжтэй өнөөгийн нөхцөл байдал болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээтэй давхардуулан дурдсан зарим арга хэмжээг хасаж, өмнөтгөл хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулсан болно.

2.Улсын Их Хурлын гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн саналыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн байдал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах боломжтой эсэхийг нь харгалзаж үзэж, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгах шаардлагатай төсөл, арга хэмжээг нэмж тусгалаа.

3.Өргөн мэдүүлсэн төслийн зорилт, арга хэмжээнд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах найруулгын шинэ засвар хийсэн болно.

4.Төслийн 2 дугаар хавсралтад зах зээл дэх төрийн оролцоог бууруулах гэсэн шалгуур үзүүлэлт нэмж тусгах зэргийг хамарч байгаа болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс боловсруулан оруулж байгаа зарчмын зөрүүтэй

саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Одоо бусад Байнгын хороодоос ирсэн саналыг танилцуулна. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан танилцуулна. Мөнхбаясгалан гишүүний микрофоныг нээе. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон

**Л.Мөнхбаясгалан:** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэрэг урт, дунд

хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд төсөлтэй холбогдуулан Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад албан тушаалтнаас асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.11 дэх хэсэгт заасны дагуу Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх мега төслүүд болон бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх зорилтуудтай холбоотой гаргасан зарчмын зөрүүтэй 12 саналын томъёоллыг дэмжсэн, дэмжээгүйгээр бүлэглэж Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Ганбаатар.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд танилцуулна. Эрдэнэболд гишүүний микрофоныг нээе. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

**С.Эрдэнэболд:** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 24 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа явуулаа.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Номтойбаяр гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд ирэх 4 жилийн төсөөллөө гаргасан эсэх, хөтөлбөрийн бодит хэрэгжилтийг хангахад гаднын хөрөнгө оруулалт, эдийн засгийн аюулгүй байдал ямар хэмжээнд хангагдаж байгаа талаар, банк санхүүгийн болон үндэсний аюулгүй байдлын хүрээнд ямар ажлууд хэрэгжихээр тусгагдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд эдийн засагтаа хөшүүрэг болохуйц шинэчлэлийг хийж, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг дахин шинэчлэн батлах шаардлага байгаа талаар, эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хөтөлбөр бодитоор хэрэгжих эсэх, бензин шатахууны хангамжийн талаар, Улсын

Их Хурлын гишүүн Ө.Шижир олон улсад үүсээд байгаа нөхцөл байдалтай уялдуулж эдийн засгийн бодлогоо тодорхойлж байгаа эсэх, дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа ажилтнуудын нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Монгол Улс, Оросын Холбооны Улстай байгуулсан хилийн хянан шалгах ажлын явц, эрчим хүчний систем, нар, салхи буюу сэргээгдэх эрчим хүчний системийг хэрэгжүүлэх талаар хөтөлбөрт тусгасан эсэх, Улсын Их Хуралд олон улсын гэрээ хэлэлцээрийг хэлэлцүүлэхээр оруулж ирэхдээ орчуулгын алдаа гаргахгүй байхад анхаарах, гаднаас оруулж ирж байгаа эмийн чанарт хяналт тавьдаг байх, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар батлан хамгаалах салбарын хувьд ард иргэдээ болзошгүй эрсдэлээс сэргийлэх, буудлагын талбай байгуулж галт зэвсэгтэй харьцах анхан шатын мэдлэг олгох, орон нутгийн хамгаалалтын талаар мэдлэг олгох, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслөөс тодруулж асууж, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээг хэрхэн хийх, орон нутагт ажиллаж байгаа онцгой байдлын салбарын алба хаагчдыг хэрхэн, ямар шалгуураар ажилд томилдог талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх зэрэг асуудалд хөтөлбөрт тусгагдсан эсэх, шатахууны нөөц, хадгалах сав хангалтгүйн улмаас шатахуун тасрах нөхцөл байдал үүсдэг талаар анхаарах, хөтөлбөрийг хэрхэн ямар хугацаанд хэрэгжүүлэх, тэдгээрийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, үр дүн чухал талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл тогтоолын төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, эмийн импортыг чөлөөлөхөд онцгой анхаарах, Засаг захиргаа, нутаг

дэвсгэрийн нэгжийн шинэчлэлийн асуудалд Эдийн засаг, хөгжлийн яамнаас хийс гэсэн судалгаа байгаа эсэх, Онцгой байдлын ерөнхий газрын хүний нөөц, боловсон хүчний асуудлаа анхаарах, Батлан хамгаалах яам иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэхэд анхаарч, тодорхой ажлуудыг зохион байгуулах, буруу хүрдтэй тээврийн хэрэгслийн асуудалд анхаарах талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Гадаад харилцааг хэрхэн эдийн засагжуулах, төсөв бүтэцтэй холбоотой ямар ажлууд хийх талаар, Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яам хоорондын чиг үүрэг, уялдаа холбоог хэрхэн хангаж байгаа талаар, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өрийн менежментийн асуудал, гадаад өр, зээл, эргэн төлөлтийг нарийн тооцох шаардлагатай талаар асуулт асууж, үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй 3 санал гарсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанаар санал хураалт явуулахад зарчмын зөрүүтэй саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.9 дэх хэсэгт заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын

зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун танилцуулна. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

**О.Саранчулуун:** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт заасан эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийг баримтлан 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуулийн 39.10-д заасны дагуу тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон санал гараагүй болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг миний бие танилцуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг хамгаалагдсан бүс, хамгаалагдсан аж ахуй, малын эрүүл бүс байгуулах тодорхой арга хэмжээ хөтөлбөрт туссан эсэх, Малын эрүүл мэндийг онцгой анхаарч олон улсын стандартад нийцсэн хамгаалагдсан бүсийг бүсчилсэн хэлбэрээр байгуулах, Халх голын бүтээн байгуулалт болон өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн үнэгүйдэж байгаа шалтгаан, уламжлалт мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, говийн усны нөөцийн талаар судалгаа дүгнэлт байгаа эсэх, Хэрлэн, Тоонот зэрэг томоохон төслүүдийн ТЭЗҮ хийгдсэн эсэх, ойн бэлчээрийн доройтлын талаар хэрэгжүүлж байгаа бодлого төлөвлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ малын эрүүл мэндийг анхаарч, улсын хэмжээнд вакцинжуулалтад бүрэн хамааруулах, Мал махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, хамгаалагдсан бүсийн байршлыг судалж тохиромжтой газар байгуулах, Малчдын үйлдвэрлэлийг дэмжихдээ малын түүхий эд бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг өргөтгөх шалтгаан хэрэгцээ байгаа эсэх, газрын доорх усны нөөцийг нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд зээлд нийт хамрагдсан хоршоод цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд



шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн талаар, Арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын ажлын явц, цөлжилттэй тэмцэх, говь усжуулах ажлын хүрээнд дотоодын болон олон улсын байгууллагуудын хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Сорт, сорилын төв, үрийн аж ахуй, үрийн шинэчлэлийг хэрхэн дэмжиж гол таримлын үрийн урамшууллын олгох эсэх, үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагааг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлтэй уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Биокомбинатын үйлдвэрийн шинэчлэл хийх, хөдөө аж ахуйн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан говийн бүс нутгийн гүний усны нөөцийн ашиглалт, татвар болон гүний усыг зохистой ашиглах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг агаар хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн тодорхой ажлууд хийгдэж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийн төсөл хүртээмжийг нэмэгдүүлэхэд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Хөдөө аж ахуй, Мал аж ахуйн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд дагнасан бүтэц нэгж байгуулагдах эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал уур амьсгал, байгаль, цаг уурт дасан зохицсон тэсвэр чадвартай нутгийн шилмэл малын үржлийн ажлыг явуулах, бүс нутгуудыг тодорхойлж, хөрөнгө санхүүжилтийг хөтөлбөрт тусгаж, газар тариалангийн бүс

нутагтай уялдуулж, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, Малчдаа орлогожуулж, өвс, тэжээлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтыг анхаарах, Шинэ хоршоо хөдөлгөөнийг дэмжих, чиглэлээр зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, хүүгийн зөрүү олгох асуудлыг хэлэлцүүлгийн түвшинд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж байгаа Шинэ хоршоо хөдөлгөөний үйл ажиллагаа, зээл олголтод үнэлгээ хийх, цаашид уг арга хэмжээг улам сайжруулж Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар өнгөрсөн хугацаанд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэгдсэн бодлого, хөтөлбөрүүдэд үнэлэлт дүгнэлт өгөх, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар малчдыг малжуулах, даатгалын үйлчилгээг малчдад хүргэх, хамруулах боломжийг судалж хэрэгжүүлэх зэрэг саналуудыг хэллээ.

Тогтоолын төслийг хэрэгжүүлэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй нийт 10 санал гарсан бөгөөд саналын томъёоллоор нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан саналуудыг бүлэглэн бэлтгэсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.9 дэх хэсэгт заасны дагуу Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн

шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Одоо Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн танилцуулна. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг нээе.

**Б.Хэрлэн:** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлт.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Ёс зүй, дэгийн байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.9 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдөр хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас чөлөөлөх явдал сүүлийн үед газар авч байгаад улс төржилгүй зөвхөн хуулиа сахин мөрдөж ажиллах, Ёс зүйн хорооны бүрэлдэхүүний хараат бус байдалд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал төрд учирсан хохирлыг нэхэмжлэхдээ ялгавартай хандаж байгаа эсэх талаар тус тус асуулт асууж, үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын

гишүүн Б.Баярбаатар төслийн 4 дүгээр заалтад 4.2.3.12.Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ. 4.2.3.13-д төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, ёс зүйн сахилга хариуцлагыг үлгэрлэх, соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс, суртахууны үнэт зүйл бүхий сэтгэл зүйг төлөвшүүлнэ, 4.2.3.14-д төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршилагад суурилан хэрэгжүүлнэ гэж нэмэх зарчмын зөрүүтэй санал гаргасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63.11 дэх хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их

Хурлын гишүүн Цагаанхүүгийн Мөнхбат танилцуулна. 3 номерын микрофон.

**Ц.Мөнхбат:** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Инновац, цахим бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар явууллаа.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулсан талаар дурдсан.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.7-д татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс, шинжлэх ухааны паркийг хаана байгуулах, цахим мөрийтэй тоглоом, цахим залилангийн талаар мөрийн хөтөлбөрт орж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат И-Монголиа платформын нэмэлт хөгжүүлэлт, цахимжуулах шаардлагатай төр, хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа холбоо,

үндэсний хиймэл дагуулыг нэвтрүүлэх хугацаа, улсын чанартай авто зам дагасан бүс нутгийн интернэт холболтыг үндэсний хиймэл дагуул хөөргөх хүртэл хугацаанд хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн компаниудаас гааль дээр мэдүүлж байгаа эмийн бөөний үнийг иргэдэд нээлттэй болгох талаар мөрийн хөтөлбөрт туссан эсэх, мөн эрүүл мэндийн салбарын цахим шилжилт удааширалтай байгаа талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.9 дэх хэсэгт заасны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанаас гарсан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулхар танилцуулна. Зулхар гишүүний микрофоныг нээе.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж,

төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт заасан эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.3 дахь хэсгийг баримтлан 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасан журмын дагуу тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, орон сууцжуулах бодлого, орлого нэмэгдүүлэх асуудлыг хэрхэн төлөвлөж тусгасан талаар болон Оюутан цэрэг хөтөлбөрийг үргэлжлүүлэх санхүүжилт туссан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүний хөгжлийн бодлогод эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, бүтэн өнчин хүүхдүүдийн нийгмийн хамгааллын асуудлыг хэрхэн тодорхойлж тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ирэх 4 жилд эдийн засгийн өсөлтийг даган цалин хөлсийг хэдэн хувиар нэмэгдүүлэхээр тооцож байгаа талаар, салбаруудын хүний нөөцийн хомсдолыг хэрхэн зохицуулах болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн

төсөлд туссан ажилгүйдэл ядууралыг тооцсон аргачлалын талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчих дэд бүтцийн хэсэгт бүх аж ахуйн нэгжүүдээс гадна, албан байгууллагуудыг хамруулахад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ орчны бохирдлын асуудал нь салбар дундын асуудал тул бүх салбарын чиглэлд тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен сумын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, автомашины асуудлыг тодорхой тусгаж, эмч, эмнэлгийн ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхэд анхаарах талаар тус тус саналаа хэллээ.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй нийт 16 санал гарсан бөгөөд саналын томъёоллыг 1 бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан саналуудыг бүлэглэн бэлтгэсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.9 дэх хэсэгт заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэхээр тогтлоо.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Энхсайхан.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Номинчимэг гишүүний микрофон.

**О.Номинчимэг:** Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт заасан эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.3 дахь хэсгийг баримтлан 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасан

журмын дагуу тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Г.Уянгахушиг, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэболд нарын гишүүд зарчмын зөрүүтэй 4 саналын томъёолол гаргасан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар, С.Эрдэнэболд, Г.Уянгахушиг, Д.Ганбат, Б.Бат-Эрдэнэ, М.Нарантуяа-Нара, Х.Тэмүжин нар тогтоолын төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг. Энхцэцэг гишүүний микрофон өгье.

**М.Энхцэцэг:** Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороо болон холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.9 дэх хэсэгт заасныг баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдааны тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Монголын ногоон санхүүгийн корпорацын үйл ажиллагааг дэмжих ажлуудыг хөтөлбөрт тусгасан эсэх, ногоон шилжилтийг дэмжих хүрээнд дэд бүтцээ ногоон технологиор шийдсэн амины орон сууц худалдан авахад олгох зээлийн нөхцөлийг ердийн орон сууцны зээлээс ялгаатай байдлаар тогтоох боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн бүтээн байгуулалтад үндэсний аж ахуйн нэгжүүдийг оролцуулах боломжит түвшинийг тодорхойлох тооцоолол судалгаа хийсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин экспортыг хөгжүүлэх нэг цонхны бодлогоор экспортод дэмжлэг үзүүлэх асуудлаар мөн төрийн өмчит компаниудын өмч хувьчлал төр, хувийн хэвшлийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх чиглэлд үйл ажиллагааг хөтөлбөрт тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Батишугар гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд баримтлах бодлогын талаар, Хөгжлийн банкныг

Эдийн засгийн үндсэн тулгуурт институт болгон ажиллуулахын тулд тус банкны статусыг хэрхэн тодорхойлох талаар, Монгол Улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагууд гадаад валютын орлогоо Монголбанканд бус арилжааны банкнуудаар дамжуулан арилжаалах харилцааг зохицуулах, мөн цаашид ханины эрсдэлийг хэрхэн тооцоолох талаар, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн орон нутаг дахь уул уурхайн ажиллагааг иргэд олон нийт эсэргүүцдэг шалтгаан нөхцөлийг тогтоох өргөн хүрээний судалгааг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны зүгээс хийдэг эсэх, энэ асуудлаар судалгааны ажлын хэсэг байгуулж ажиллуулах, мөн уул уурхайн салбарт нийгмийн нөхцөл байдлын үнэлгээ хийх талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг хөтөлбөрт тусгагдсан эрчим хүчний салбарт төлөвлөсөн ажлуудын санхүүжилтийн тооцоолол үндэслэлтэй эсэх, Мандалговийн 2 мянган Мвт нар салхины станц, Өмнөговийн 3 мянган мегаваттын нар салхины станц барьж экспортлох төслүүд Улаанбаатар, Шинэ Хархорины 500 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлууд нь судалгаа тооцоололтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улаанбаатар хот, “20 минутын хот” төслийн хүрээнд гэр хорооллыг орон сууцжуулах бүсчилсэн хөгжлийн хүрээнд сумдыг эдийн засгийн тооцооллоор нь нэгтгэн цөөлж, эдийн засгийн хувьд орчин үеийн интегралчилалд оруулах үйл ажиллагааны талаар тус тус асуулт асууж, санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин экспортын гол бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний гадаад экспортыг нэг цонхны бодлогоор дэмжих талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Эрдэнэтийн овооны Оюут ордны

нөөцийг тооцоолон ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад оруулахад бэлэн болгох, Эрдэнэтийн стратегийн ордын талбайн эрэл хайгуулын ажлын хүрээнд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан шинэ стратегийн орд нээж ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг эхлүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг эрчим хүчний салбарт реформ хийж, салбарын эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх, Сонгино, Дарханы чиглэлийн 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүд олонхын саналаар дэмжсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Одоо Төсвийн төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн танилцуулна. 3 номерын микрофон.

**Ц.Даваасүрэн:** Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн

мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулсан талаар танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батлут хөдөө орон нутагт ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах, боловсон хүчний тогтвортой ажиллуулах зорилгоор цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах, мэргэжил, ур чадварыг сайжруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, эрчим хүчний салбарт хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний төсөвт өртөг ажлын явц болон аудитын дүгнэлтээр баталгаажсан эсэх, цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн үнэ өөрийн өртөгтэй хэрхэн уялдах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх гол хүчин зүйл болох экспортыг нэмэгдүүлэхэд ашигт малтмалаас бусад салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр банкны салбарын шинэчлэл, зээлийн бодлого, татварын дэмжлэг үзүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тусгай бүсийг тодорхой зарлан хөгжүүлэх, уул уурхайн салбар дагасан болон хөдөө амьдарч байгаа иргэдийн орлогын тэгш бус байдлыг арилгах арга хэмжээг хэрхэн тусгасан, ашигт

малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл буюу ашиглагдахгүй байгаа тусгай зөвшөөрлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, үндэсний хиймэл дагуулыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Малчин иргэдийн амьдралыг сайжруулах чиглэлээр нүүдлийн мал аж ахуй хөгжүүлэх, бодит дэмжлэг үзүүлэх цогц бодлого тусгасан эсэх, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх, бизнес эрхлэгчид таатай нийгмийн даатгалын багц бодлогыг хэрхэн боловсронгуй болгох талаар, Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн уул уурхайн салбараас бусад салбарын үйлдвэрлэлийг бий болгох, эдийн засгийн орлогыг нэмэгдүүлэхэд экспортын орлогыг бүрдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олируулах, төсвийн зардлын дийлэнх хэсгийг бүрдүүлэх, нийгмийн халамжийг бууруулах чиглэлээр тэргүүлэх чиглэлийн салбарын шинжлэх ухаан, судалгааны хүрээлэнг түлхүү хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан өөрчлөлтийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Улаанбаатар хотын төлөвлөлтийн асуудал хуримтлагдаад байгаа нь газар зохион байгуулалт орхигдуулснаас үүдэлтэй бөгөөд хот төлөвлөлтийг Газрын багц хуулийн шинэчлэл болон газар олголттой нийцүүлэн тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут сумдад амьдрах орчныг бүрдүүлэхэд төвлөрч, дахин төлөвлөлт хийх, хүний эрхийг хангасан суурь орчныг бүрдүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бодитоор дэмжих талаар, Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц худалдан авах, барих, иргэдэд дэмжлэг үзүүлэх зориулалтаар

хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт зориулан зарцуулагдах зардлыг Сангийн сайдын багцаас Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын төсвийн багцад шилжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар малчдын үйл ажиллагаанд анхаарал хандуулж аялал жуулчлал, хонины ноосны үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал эдийн засгийг нэмэгдүүлэх, хөгжлийг тэтгэх дэд бүтцийг бий болгох, үйлдвэрлэлийн асуудлыг анхаарч тэргүүлэх чиглэлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байгаа эрдэм шинжилгээний хүрээлэнг тухайн салбарын яамдад нь шилжүүлэх, арьс шир, малын дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрийн нэгдсэн бодлогоор хөгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин махны чиглэлээр үндэсний хэмжээний тогтолцоог бүрдүүлэх, түүнийг дагасан арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажил олгогч, хувийн хэвшлийг нийгмийн даатгалаар дамжуулан дэмжих, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл хэвлэлийн эрх чөлөө, олон нийтийн үндэсний телевизийн бие даасан, хараат бус, ил тод байдлыг хангах орчныг бүрдүүлэх талаар тус тус санал гаргаж, үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Улаанбаатар, Шар хөтөл, Эрдэнэтийн авто замын барих төслийг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.16 дахь хэсэгт заасны дагуу санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал,



дүгнэлтийн хамт Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.9 дэх хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүрэл хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Асуудал руугаа оръё. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна. Ж.Энхбаяр гишүүн. Ж.Энхбаяр гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг нээе.

**Ж.Энхбаяр:** Баярлалаа гишүүд ээ. Улсын Их Хурлын тогтоолын төслийн 8 дугаар зүйл дээр 1 ийм өгүүлбэр байгаа юм. Монгол, Францын хамтарсан уран, атомын цахилгаан станц барина гэж. Энэ алдаатай томъёологдсон байна. Энийг анхаарахгүй бол Монгол, Францын хамтарсан Дорноговь аймгийн Зөөгч овоогийн ураны орд газрыг ашиглах асуудал явагдаж байгаа. Тэрнээс Францтай нийлээд бид нар атомын цахилгаан станц барих асуудал ердөө байхгүй юм байгаа юм. Энэ бол гадна талдаа ч буруу ойлгогдоно. Дотор талдаа ч буруу ойлгогдох юм байгаа юм. Энийгээ эвтэйхэн Монгол Францын хамтарсан зөөгч овоогийн ордын ашиглалтад оруулна гэж оруулаад, атомын цахилгаан станц барина гэдгийнхээ оронд атомын эрчим хүчний ашиглалтыг сайжруулна гэдэг юм уу, энэ

чиглэлээр ажиллана гэсэн талаар хэлээч. Туваан сайд энэ дээр та мэдээлэлтэй байгаа бол бас нэмэлт өгвөл их зүгээр байна. Энэ их том бодлогын бөгөөд юмны их том алдаа гарчих болов уу гэж бодоод байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Туваан сайд хариулъя.

**Ц.Туваан:** Тантай санал нэг байна. Харин бид хэд сая бас Байнгын хорооны дарга, Учрал сайд, референтүүд бид хэд ярилцаад байж байна. Яг хаана орж ирээд санал хураагдаад яачхав. Таных дээр ямар цаасан дээр орж ирсэн байгаа юм. Том төслийн 8 дээр үү. Тэр өмнөтгөл хэсэг дээр тийм юу явж байсан. Төсөл. Яг энэ зүйл заалтаараа биш, танилцуулга өмнөтгөл дээр байсан зүйлийг хэлж байх шиг байна. Энийг бид хэд анхаарч байгаа. Энэ бол алдаатай асуудал.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр гишүүн ээ, энэ хасах санал орж ирээд хасагдсан шүү. Ер нь бол хасагдсан. Ер нь бол урантай холбоотой асуудлууд өмнөтгөл дотор ч байж байгаа тийм үү. Ерөнхий том агуулгаараа бол ашиглах, цаашидаа бол цахилгаан станц барих энэ тэр гэсэн агуулга бол байгаа шүү дээ. Заавал Монгол, Франц гэсэн үг үсэгтэй орж ирсэн энэ заалт, өөрөөр хэлбэл 3.3.3.42 гэсэн нэг ийм заалт орж ирснийг ажлын хэсэг дээр хасчихсан байгаа шүү.

Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Сандаг-Очир гишүүн. Сандаг-Очир гишүүний микрофоныг нээе.

**Ц.Сандаг-Очир:** Энэ чинь ингээд бүх Байнгын хороод манай Байнгын хороо дээр нэгтгэгдэж зарчмын зөрүүтэй саналууд хураагдах юм байна. Тэгээд энэ чинь ингээд санал хураалтаар бүгдийг нь шийдчих юм уу. Тэгээд энэ олон 70, 100-аад зарчмын зөрүүтэй санал орж ирж байгаа юм байна шүү дээ. Тэгээд энэ чинь одоо нөгөө төслөөрөө бол 120 хэдэн их наядын төсөвт

өртөгтэй ажил гээд байгаа. Одоо энэ өгүүлбэр ажил болгоны цаана чинь л бас төсөв байгаа байх даа. Тэгээд хэд болж өөрчлөгдөх юм. Яаж нэмэгдэх юм. Энэ зарчмын зөрүүтэй орж ирж байгаа саналууд чинь нөгөө шалгуур шаардлагыг хангасан юм уу, үгүй юу. Нөгөө алсын хараатайгаа, дунд хугацааны бодлого, хөтөлбөртэйгөө, зураг төсөв ТЭЗҮ-тэйгээ байгаа юм уу, үгүй юу. Эд нарыг хянаж, тэгээд ингээд Байнгын хорооны гишүүдийн санал хураалтаар ингээд шийдчихээр бид нар чинь мэдэхгүй шүү дээ. Оруулж ирсэн саналууд нь зураг төсөв, ТЭЗҮ байгаа, байхгүйг. Тэгээд хэрхэн яаж шийдэх юм. Тэгээд энэ дээр Сангийн яам яаж хяналт тавьж байгаа юм. Одоо оруулж ирсэн санал болгоныг аваад байна гэсэн үг үү. Эсвэл хасаад байна гэсэн үг үү. Яах вэ. Одоо ингээд санал хураалтаар шийдэх гэж байна шүү дээ. Энэ дээр нэг тайлбар өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны даргын хувьд би хариулах байх даа. Одоо ингээд Байнгын хороо дээр ажлын хэсгийн саналууд эхлээд санал хураагдана. Ар дээр нь саяын бидэнд танилцуулсан Байнгын хороодын саналууд орж ирнэ. Тэгээд гишүүдээс бас өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд бол санал оруулж ирэх ийм боломж бололцоотой. Нээлттэй. Тэгээд энэ бүх саналуудыг хэлэлцээд Байнгын хороо дээрээ батлаад явахаас өөр арга байхгүй. Дэмжихийг нь дэмжээд, дэмжихгүйг нь дэмжихгүй. Унагаад ингээд явахаас өөр арга байхгүй.

2 дугаарт ажлын хэсгийн хүрээнд бол бид бүхэн үзэхдээ таны хэлсэнчлэн 120 их наяд төгрөгийн хүрээнд Засгийн газраас оруулж ирж байгаа санхүүжилтийн хүрээнд аль болох өшөө хөрөнгө оруулалтуудыг бол нэмэхгүй байх ийм бодлогыг бол бариад, тэгээд нөгөө бусад мөрийн хөтөлбөрүүд болоод бусад бичиг баримтууд 2050 энэ тэр гэсэн бичиг баримтуудын хүрээнд үзэж хараад, ерөнхийдөө бол хасах зүйлүүдийг нь хасаад, санал хураалтад оруулахыг нь оруулаад явчихсан байж байгаа.

Түрүүний ажлын хэсгийн танилцуулгад бас ярьсан шүү дээ. Тэгэхээр ажлын хэсгийнхэн энэ дотор сууж байгаа. Санал хураалт дээр зайлишгүй шаардлагатай бол бас ажлын хэсгийнхнээс бол саналыг нь асуугаад, тэгээд дэмжих, дэмжихгүйгээ Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүд шийдээд ингээд явна шүү. Давхардсан тоогоор бол 300-аад зарчмын зөрүүтэй санал ирсэн байгаа шүү дээ. Давхардсан тоогоор. Тэгээд эд нарыг хооронд нь яриад үг, үсэг, өгүүлбэр, юмнуудыг нь хооронд нь шингээхийг нь шингээгээд, авахыг нь аваад, хасахыг нь хасаад, тэгээд санал хураалтаар бол дэмжихийг нь дэмжээд, унах нь унаад, ингээд 72 санал орж ирж байгаа. Ажлын хэсгээс бол. Асуулт түрүүн дуусчихсан даа. Саяынх бол асуулт болчихлоо.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтыг эхлүүлбэ. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Тайлбар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэсэн байгаа. Тэгээд үүний дагуу ажлын хэсгийн санал хураалтыг эхлээд явуулъя.

Ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтын “улсын төсөвт тусган хэрэгжүүлэх” гэснийг “улсын төсвийн төсөлд тусган өргөн мэдүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Р.Сэддорж, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/.

Эхлээд төстийн санал хураалт явуулъя. Санал хураалт. Төстийн санал хураалт. Минийх болсонгүй. Санал хураалт. Болохгүй байна уу. Минийх болсонгүй. Гар өргөж болохгүй байх. Би өөрөө горимын санал гаргаадахъя. Энэ техник ажиллаагүй тул энэ санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулъя гэсэн ийм горимын саналыг оруулж байна.

Баярбаатар гишүүний микрофоныг нээе.

**Б.Баярбаатар:** Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэндээ өдрийн мэндийг хүргэе. Энэ Их Хурлын чуулганы хуралдааны болон бусад Байнгын хороодын танхимуудын санал хураалтын төхөөрөмж бол ер нь маш доголдолтой ажиллаад байгаа юм. Тэгээд нэг талаараа энэ парламент, Байнгын хороодын үйл ажиллагаагаа явуулах ийм хэвийн нөхцөл байдлыг бол хангаж чадахгүй байгаа учраас энэ дээр ер нь Тамгын газар дараа дараадаа бас шийдвэртэй арга хэмжээ авах нь зөв болов уу гэж бодож байна.

Тэгээд уг нь энэ цахим систем хөгжсөөд, бид нар дэвшилтэт зүйл яриад байдаг. Тэгээд төхөөрөмж нь ингээд гацаад явахгүй байна. Тэгэхээр өнөөдрийн манай Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр бол нэлээдгүй олон зарчмын зөрүүтэй саналууд байгаа. Тэгээд энэ төхөөрөмж чинь аягүй бол 2, 3 удаа тэгээд санал хураагаад л тэгээд цаашаа гагцхиад байгаа байхгүй юу. Тэгэхээр горимын санал гаргаад гар өргөж санал хураалт явуулах саналтай байна. Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 10 дугаар зүйлд зааснаар бол гар өргөж санал хурааж болно гэсэн заалт байж байгаа учраас.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг санал хураах ёстой. Саналаа тэгээд юугаар хураах юм. Эхлээд үүгээрээ үзэж байж бид нар явсан нь дээр байх. Тэгж

байж дараа нь гараараа санал хур хураах нь дээр. Баярбаатар даргын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Баярбаатар даргын гишүүний гаргасан горимын санал 58,8 хувиар дэмжигдсэн тул санал хураалтыг гараар явуулъя гэсэн санал дэмжигдлээ. Илээр буюу гар өргөж санал хураалт явуулъя.

Төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтын “улсын төсөвт тусган хэрэгжүүлэх” гэснийг “улсын төсвийн төсөлд тусган өргөн мэдүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Р.Сэддорж, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/. Санал хураалт. Тоолно шүү. Хэд вэ. 17-13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын бүлэг, зүйлийн нэрийн жагсаалт бүхий агуулга хэсгийг хасаж, “Өмнөтгөл” хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

### **“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар олонхыг бүрдүүлсэн Монгол Ардын намаас Засгийн газрын бүрэлдэхүүнд Ардчилсан нам, ХҮН намыг урьж, хамтарсан Засгийн газрыг байгуулсан.

Засгийн газар хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч байгаа сорилтуудыг илүү хурдан, үр дүнтэйгээр шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, тогтвортой хамтран ажиллах зорилгоор “ХҮРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” хамтарсан Засгийн газрын гэрээг байгуулсан. Тус гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам,

Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа:

Үндэсний эв нэгдэл, үндэсний эрх ашигийг эрхэмлэж, эрх зүйт төрийн үндсэн зарчмуудыг удирдлага болгон;

Улсын эрх ашиг нэгдүгээрт, улс төрийн намын эрх ашиг хоёрдугаарт, эцэст нь хувийн эрх ашиг байх зарчмыг үнэт зүйлээ болгон;

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийг зорин;

Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан нийгмийн бодлогын шинэчлэл, бүсчилсэн хөгжлийн бодлого, авлигагүй төр, шударга ёсыг бэхжүүлэх цахим засаглал, эхлүүлсэн томоохон төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилтууд, Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт туссан хүний хөгжил, хувийн өмчийн эрхийн хамгаалалт, технологи суурьтай мэдлэгийн эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга төрийн зорилтууд, ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан эрчим хүчний болон боловсролын салбарын шинэчлэл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг шинэчлэх, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн 4 чиглэлийг тодорхойлж, тэдгээрийн хүрээнд тус бүр 4 зорилго, нийт 593 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлж, бүс бүхэнд ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх бөгөөд

**Хангайн** бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс”, **Баруун** бүсийг “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс” болгон, **Хойд** бүсийг “Байгалийн аяллын жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Говийн** бүсийг “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” болгон, **Төвийн** бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Зүүн** бүсийг “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд дараах 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөвөө:

1. “Гацуунсухайт-Ганцмод”, “Ханги-Мандал”, “Шивээхүрэн-Сэхээ” хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гацуунсухайт-Ганцмод 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

2. Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 3150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдолтой өмнөд бүсийн уул уурхайн төслийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангах боломж бүрдэнэ. “Оюутолгой” ХХК-ийн БНХАУ-

аас импортолж байгаа 110-120 сая ам.долларын вальютын урсгалыг зогсооно. Барилга угсралтын явцад давхардсан тоогоор 2000, ашиглалтад орсноор 300 байнгын ажлын байр шинээр бий болно.

3.Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ. Тус төслийг хэрэгжүүлснээр Жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 2027 оноос эхлэн 100 хувь найдвартай, тасралтгүй хангах боломж бүрдэж, 52,000 ахуйн хэрэглэгчийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, баруун аймгуудын 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана. ОХУ, БНХАУ-аас жил бүр импортоор авч байгаа 17.5 тэрбум төгрөгийг хэмнэнэ.

4.Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц барина. Тус төслийг хэрэгжүүлснээр эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой, шуурхай ажиллагааг хангаж, системийн эх үүсвэрийн зохистой харьцааг бүрдүүлнэ. ОХУ-д жил бүр төлдөг 25 сая ам.долларын импортын төлбөрийг хэмнэнэ. Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438,7 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулна. 5.7 тэрбум шоо метр цэвэр усны нөөц бүрдүүлж, Монгол Улсын усан хангамжийн аюулгүй байдлыг хангана.

5.Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ. Монгол Улс нь судалгаагаар 2,600 гВт сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй болох нь тогтоогдсон бөгөөд шинээр эх үүсвэрүүдийг бий болгох замаар өсөн нэмэгдэж байгаа дотоодын цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхөх, бусад улс руу экспортлох боломжтой. Сэргээгдэх эрчим хүчний салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар уул уурхайн бус

экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломж бүрдэж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрс хүчлийн хийн арилжаанд оролцож, нэмэлт орлого олох боломж нээгдэнэ.

6.Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах шугам барих төслийг хэрэгжүүлнэ. Хэрлэн голын олон жилийн дундаж урсцын 5-9%-ийг битүү хоолойгоор дамжуулан Хэнтий, Чойр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг бүрэн хангана. Жилдээ 30 мян.тн хүлэмжийн хийг бууруулна. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд усны асуудлыг шийдвэрлэж, цөлжилт, хуурайшилтыг сааруулна.

Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны түвшин тогтворжиж, Онги голын дагууд оршин сууж байгаа 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах нөхцөл бүрдэнэ. Агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж, цөлжилтийг бууруулна.

7.Эрэнцав-Чойбалсан-Баруун Урт-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, тээврийн зардлыг бууруулна.

8.Монгол, Францын хамтарсан уран, атомын цахилгаан станцыг барих төсөл хэрэгжиж, үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажилласнаар жилд 2,500 тонн ураныг олборлож экспортолно. Төсөл хэрэгжих хугацаанд улс, орон нутгийн төсөвт 1 тэрбум гаруй ам.долларын татвар төлнө. Үйлдвэрлэлийн туршилтын төсөл дээр үндсэн үйлдвэрлэлийн олборлолт эхлэхэд 1,000 гаруй ажлын байр бий болно. Улс, орон нутгийн хэмжээнд томоохон

худалдан авалт, бизнесийн боломж нэмэгдэнэ.

9.Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, боловсруулах үйлдвэрлэлийг нэг шат ахиулснаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, олон улсын түүхийн эдийн үнээс хараат байдлыг бууруулах боломж бүрдэнэ.

Кокс-химийн үйлдвэрийн нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр шатанд 10 сая тонн коксжих нүүрсийг угаааж, 5.4 сая тонн баяжуулсан нүүрс, 3 сая тонн завсрын бүтээгдэхүүн (мидлинг) үйлдвэрлэнэ. 2.7 сая тонн баяжуулсан нүүрсийг боловсруулж, 2 сая тонн хатуу кокс, 107 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Дотоодын хэрэглээнээс илүү гарсан 1.5 сая тонн коксын бүтээгдэхүүнийг экспортолно. “Алтаниширээт” үйлдвэрлэл технологийн паркийг байгуулснаар 140 га талбайд төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжсийн зэрэг дагалдах үйлдвэрүүд бүхий 500 мян.тн/жил ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр ашиглалтад орно.

10.Зэс боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 125 мянган тонн катодын зэс, 72 кг алт, 38.2 тонн мөнгөн гулдмай болон 182 мянган тонн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ. Катодын зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон түлхэц үзүүлнэ. Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.

11.Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр дотоодын тасралтгүй нэмэгдэж байгаа ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулж эхний ээлжид 500 мянган тонн ширэм, 500 мянган тонн ган бэлдэц үйлдвэрлэж, ган бэлдцээс барилгын арматур, булан төмөр, төмөр утас зэрэг ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын барилгын арматурын хэрэгцээг бүрэн хангана.

12.Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.

13.Оюутолгойг түшиглэсэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ. Тус төсөл хэрэгжсэнээр жилд гадаад орны алт цэвэршүүлэх үйлдвэрт цэвэршүүлж, мөнгөжүүлдэг алтны 70 хувийг дотооддоо цэвэршүүлэх боломж бүрдэнэ. Баяжуулсан алтны хувийг нэмэгдүүлж, олон улсын зах зээлд борлуулж, валютын орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улс алтаа одоог хүртэл гадаад орнуудад цэвэршүүлж байгаа бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор үүнтэй холбогдон гарах тээвэр, даатгал, хамгаалалтын зардлыг хэмнэнэ.

14.Үндэсний хиймэл дагуулыг хөөргөнө. Монгол орны нийт газар нутгийн 26.8 хувьд 4G сүлжээ нэвтэрсэн. Үлдсэн 73.2 хувь буюу орон нутгийн иргэд, малчин айл өрхийг шилэн кабелиар интернэт сүлжээнд холбоход шаардлагатай 29.0 их наяд төгрөгийг

хэмнэж, улс орны өнцөг булан бүрд интернэтийн сүлжээ нэвтэрнэ. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, ослын үед газрын сүлжээнд саад, доголдол гарсан тохиолдолд сансрын холбооны сүлжээ нь найдвартай холбооны сүлжээ болно.”

Энэ өмнөтгөл ер нь юу яасан байсан шүү. 12 нүүр байсан. Тэгээд хүүрнэсэн байдлаар нэлээн задгай байсныг ингээд гол гол асуудлуудыг нэлээн эмхэтгээд, шинээр боловсруулж гаргаж та бүхэнд оруулж ирж байгаа юм шүү. Асуулт уу. Санал хэлэх үү. Учрал гишүүн.

**Н.Учрал:** Би санал хэлье. Энэ өмнөтгөлийг багасгасан байна. Тэгээд би Их Хурлын ажлын хэсгийнхэнд талархаж байна. Тэгээд мэдээж бас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ажилласан. Манай дэд ажлын хэсэгт орж ажилласан манай яамнуудын төрийн нарийн, газрын дарга нар тэгээд яах вэ, би бас 2016 оноос Их Хурлын гишүүнээр ажиллаж байна л даа. Тэгээд энэ хугацаанд нэг зүйлийг ойлгоод байгаа юм. Манай энэ төрийн албан хаагч нар, Их Хурлын гишүүдэд янз бүрийн санал бичүүлж, Засгаас орж ирсэн ажлуудад төрөл бүрийн саналыг ингэж түвшин түвшинд нь тусгадаг болоод их удаж байгаа. Одоо энэ Байнгын хороо болгон дээр гишүүдэд 1, 1 заалт өгөөд, гишүүдээр баахан санал хураалгасан байгаа шүү дээ. Өөрсдөө Засаг дээр хамт боловсруулчхаад, Их Хурал дээр орж ирэхээрээ ингээд өөр юм яриад оруулж ирдэг. Тэгээд сүүлдээ явсаар байгаад танигдахын аргагүй болдог шүү дээ. Тэгээд энэ өмнөтгөл дээр өнөөдөр нэгэнт Эдийн засгийн яам энэ Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө яг өнөөдрийн энэ олон улсын геополитик, эдийн засгийн нөхцөл байдлын үед энэ хөтөлбөрийг хийлээ шүү гээд өмнөтгөлөө үндэслэлээ тодорхой тусгаад, нэгэнт өнөөдөр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн сайд нөхцөл байдлаа

тодорхойлоод оруулж ирж байхад, тэгээд 13 хуудсыг ингээд багасгаад ийм болгож л байгаа юм л даа. Тэгэхдээ энэ бол 10 жилийн дараа бас түүх болж үлдэх хөтөлбөр шүү. Тэгэхээр тухайн үед дэлхий дахинд ямар нөхцөл байдал байсан юм. Эдийн засаг ямар байсан юм. Геополитик ямар байсан юм. Яагаад хамтарсан юм. Яагаад энэ Засгийн газар ийм 4 жилийн хөтөлбөр оруулсан юм бэ гэж дэлгэрэнгүй энэ үндэслэлээ оруулаад, бодлогоо зарлаад явж байхад, тэгээд тэр нь ингээд багасчхаж байгаа юм байна. Тэгээд яах вэ, энийг бол би нэгэнт Их Хурлын бүрэн эрх учраас хүндэтгэж үзэж байна.

Гэхдээ зүгээр яамдын манай бодлогын газрын дарга нар, төрийн нарийнуудад хэлэхэд та нар нэгэнт оруулж ирсэн Засгийн газрын хөтөлбөрөө өөрсдөө байр суурь дээрээ байх ёстой шүү. Тэрнээс орж ирээд Их Хурлын гишүүдэд янз бүрийн мэдээлэл өгөөд ингээд ингээд ийм болгочихдог. Тэгээд эхнээс нь бас хэд хэдэн саналаа хэлье.

10 дээр зэс боловсруулах үйлдвэр гээд орж ирсэн байгаа асуудал бол Оюутолгойг түшиглэсэн зэс боловсруулах цогцолбороо гэж ойлгох ёстой. Яагаад гэвэл эргээд цаашидаа үүнийг үр дүнг нь хэмжих.

13 дээр зэс нөгөө бүхэлдээ агуулгаараа алт цэвэршүүлэхтэй холбоотой төсөл шүү. Энэ Оюутолгойг түшиглэсэн зэсийн баяжмалын үйлдвэрийг эхлүүлнэ гэххэд дандаа үр дүн нь нөгөө алттай холбогдуулаад хэмжчихсэн ийм ойлгомжгүй байдал үүсчхэж байгаа юм. Тэр 13-ыг бол алт цэвэршүүлэх үйлдвэр гэж ойлгох ёстой. 10-ыг бол зэс боловсруулах цогцолбор гэж ойлгох ёстой.

8 дээр Засгийн дотор.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүний минутыг сунгая.

**Н.Учрал:** Тэгэхээр ажлын хэсгийнхнийг хүсэхэд та бүхэн маань 10 дээр байгаа заалтаа дан зэсээр нь оруулж өгөөд, 13-ыг дан алт цэвэршүүлэх гэж явахгүй бол дараа нь хэмжихэд маш төвөгтэй болох байдал харагдаж байна. Энийг ажлын хэсэг дахиж анхаарч үзээсэй гэж хүсэж байна. Энэ бол яах вэ, зүгээр найруулгын санал. Оюутолгойг түшиглэсэн зэс гэхээд, дараа алт дээр нь үр дүнг нь ингээд тавиад өг өгчихсөн байна.

8 дээр нөгөө Монгол, Францын хамтарсан ураны нөгөө Норона компанитай хөрөнгө оруулалтын гэрээгээ байгуулж, атомын цахилгаан станц барих асуудлыг судалж эхлүүлнэ гээд нөгөө яг хөтөлбөр дотроо байсан ерөнхий байдлаар нь томьёолж өгөхгүй бол шууд Монгол, Францын хамтарсан уран, атомын цахилгаан станцыг барина гэж томьёолбол энэ бол бас болохгүй байх. Тэгэхээр зүгээр Монгол, Францын хамтарсан ураны Норона компанитай хийх хөрөнгө оруулалтын гэрээгээ байгуулж, энэ төслийг эхлүүлээд, цаашид атомын цахилгаан станц барих асуудлыг судалж хэрэгжүүлнэ гэдэг байдлаар нөгөө Аж үйлдвэрийн яамны оруулаад байгаа саналаар оруулж өгөөч ээ гэж хэлмээр байна.

Тэр 11 дээр найруулга дээр Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулна гэснийг гангийн цогцолбор болгоод өөрчлөөд явах нь зөв байх. Шууд гангийн үйлдвэр гэж бичих бас зохимжтой биш байна.

Тэр 6 дээр байгаа нөгөө усны асуудал дээр Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах шугам биш нөгөө хоолой барих төслийг хэрэгжүүлнэ гэж явахгүй бол шугам гэхээр ойлгомжгүй болно. Тэгж өөрчлөгдсөн юм байна. Дээрээс нь нөгөө Хэнтийн нөгөө Хэрлэн голоос ус аваад нөгөө говийг усжуулъя гэж байгаа агуулга шүү дээ. Тэгэхээр нөгөө Хэнтий,

Чойр, Дорноговь, Өмнөговь аймгийн усны хэрэгцээг бүрэн хангана биш, тэндээс нөгөө Хэнтий гэдэг үгийг авсан байснаар нь үлдээхгүй бол нөгөө Хэнтий Хэрлэнгээс ус аваад, Чойр, Дорноговь, Өмнөговийг усаар хангана болохоос биш нөгөө Хэнтийг хангах гээд байгаа юм шиг ойлголт яваад байгаа учраас энэ дээр бас агуулга дээрээ анхаарч өгөөч гэж зүгээр санал хэлмээр байна. Тэгэхээр ажлын хэсгийнхэн маань ийм нэг найруулгын саналуудыг анхаарч өгөөч. Бусдаар бол ажлын хэсэг бол сайн ажилласан байна. Тэгээд ажлын хэсгийнхэнд баярлалаа. Сайн ажилласан байна. Зүгээр саяын тэр редакцын саналуудыг тусгаад өгөөч.

Бас нөгөө Байнгын хороод дээр гишүүд бас санал гарч байгаа дээр давхцахыг бас үгүйсгэхгүй шүү дээ. Саяын саналууд. Тэгэхээр 1 мөр нөгөө Байнгын хороодоос гишүүдийн оруулсан санал хураагдаад явсны дараа ажлын хэсэг нэгтгээд саналаа оруулахдаа бас найруулга дээрээ нэгтгээд явах нь зөв байх. Би бол тусгайлан санал хураалгахгүйгээр гишүүдийн саналыг хураалгасны дараа ажлын хэсэг нэгтгэхдээ миний энэ саналуудыг бас анхаарч өгөөч гэж хүсмээр байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Туваан сайд байж байгаарай. Хэн яриад байгаа юм бэ. Тэмүүжин гишүүн ээ. Учрал сайдад хэлэхэд ажлын хэсэг чинь яг ингэж бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаагүй шүү. Шууд матчихъя. Одоо энэ өөдөөс харж байгаа Тавинбэх байж байна. Мягмар байж байна. Мөнхцэрэн байж байна. Тэгээд ер нь бол сүүлд ажлын хэсэг бид нар шөнийн 12 цаг, 1 цаг хүртэл бараг ажилсан. Энэ үед бол тэгээд ажлын хэсэг чинь орж ирчхээд нэг мэдэхэд цөөхөн хэдэн хүн хариулах хүнгүй болоод л сууж байсан шүү. Яг ажлын хэсэг дээр бол бид нар зарим яг өөрийн чинь тайлбарлаад байгаа энэ асуудлуудыг зарим гол учир юмыг нь бол бид нар сайн ойлголгүйгээр ер нь зассан ийм тал байж байгаа шүү. Ер нь бол. Би түрүүн хэлсэн



300 орчим санал орж ирсэн. Энэ дээр бол зарим идэвхтэй ажлын хэсгийн гишүүд нь бол яг өөрсдөө Засгийн газрынхаа бодлогыг болон салбарынхаа бодлогыг шууд гаргаж ирээд, тэгээд тэрийг нь бид нар харгалзаж үзээд ингээд цаашаа явсан шүү. Тийм болохоор өнөөдөр ажлын хэсэг чинь яг ажилласан шиг ажиллаад өнөөдөр энэ гишүүдээс гарч ирж байгаа, тэр тусмаа гишүүдээс гарч ирж байгаа задгай санал дээр энэ саналуудаа гаргаж ирэхгүй бол маш олон өөрчилсөн утга учир нь олдохгүй, яг цаашдаа нөгөө 120 их наяд төгрөгийн санхүүжилт чинь юу болж хувирах юм. 200, 300 их наяд руу ч орох ч юм уу ийм одоо нөхцөл байдал бий болох байдал ер нь харагдаад байгаа шүү. Санал хураалт. Та Байнгын хорооны гишүүнийхээ хувьд уу. Эсвэл Засгийн газрын төлөөлөл гэж байгаа бол Засгийн газрын төлөөлөл чинь сая хэлчихлээ. Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Учрал сайдын хэлсэнтэй холбогдуулаад зэс боловсруулах, хайлуулахтай 2 хэсэг байгаа. 10 дээрх нь бол Эрдэнэтийнх. 13 нь бол Оюутолгой. Тэрийг протоколд авчхаарай.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярмаа гишүүн.

**Ж.Баярмаа:** Миний хэлээд байгаа өмнөтгөл хэсгийн 3 дугаар хуудсанд нөгөө эрх ашгийн дараалал байгаад байгаа шүү дээ. Улсын эрх ашиг 1 дүгээрт, улс төрийн намын эрх ашиг 2 дугаарт, хувийн эрх ашиг эцэст нь байх зарчмыг үнэт зүйл болгоно гэдэг чинь улс төрийн намын эрх ашгийг үнэт зүйл болгохоос өөр замгүй юм шиг харагдаад байна л даа. Зүй нь бол улс төрийн намын эрх ашиг чинь л өөрөө улсын эрх ашиг шүү дээ. Улс төрийн нам чинь бодлогоо хэрэгжүүлж, улсыг хөгжүүлэхийн төлөө байж байгаа нь өөрөө энэ улс төрийн намын эрх ашиг шүү дээ уг нь бол. Хувь хүний эрх ашиг гэж ерөөсөө улс төрчдөд буюу төрийн өндөр дээд албан тушаал хашиж байгаа хүмүүст бол байхгүй. Ерөөсөө байхгүй. Энэ чинь ингээд дараалуулчихаар чинь заавал 2 дугаарт

нь хангах ёстой юм шиг харагдаад байгаа байхгүй юу. 3 дугаарт нь ч гэсэн эхлээд энийг нь яачихъя, дараагийн асуудал дээр энэ 2 дахийгаа барьчихъя, дараа нь өөрийнхөө ашгийг барьчихъя гэж байгаа юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг үндэсний эрх ашиг, олон нийтийн эрх ашиг гэж л 2 үг байвал, бүү дараалуулах гээд байгаа бол үндэсний эрх ашгийг 1 дүгээрт, олон нийтийн эрх ашгийг 2 дугаарт байх зарчмыг үнэт зүйлээ болгоно гэж ингэж өөрчилж өгөөч. Тэгэхгүй бол олон нийт чинь шоолж байна шүү дээ. Өө эд нар 2, 3 дугаарт ингээд өөрсдийнхөө намынхаа эрх ашгийг тавих юм байна гээд. Тэгэхээр энийг ингээд солиод өгвөл ер нь их л зүгээр, их зохистой байх гээд байгаа юм л даа. Тэгээд хувь хүнд бол улсын эрх ашиг гэж байхгүй шүү дээ жирийн иргэдэд. Жирийн иргэдэд бол ёстой цэвэр өөрсдийнх нь л эрх ашиг гэж байгаа. Тэд нар бүгд өөрсдийнхөө эрх ашгийн төлөө явж байж тэр тусгал нь нийгэмд буудаг. Жишээлбэл өөрийгөө баяжуулахын төлөө явахаар өрсөлдөөн үүснэ. Өрсөлдсөний үндсэн дээр үнэ буурна. Үнэ буурсан нь угаасаа иргэдэд таатай орчин бүрдүүлнэ гээд. Тэгэхээр иргэн хүний эрх ашиг, улс төрч хүний эрх ашиг гэдэг чинь ёстой тэнгэр, газар шиг өөр байгаад байгаа юм. Тэгэхээр энэ өмнөтгөл хэсгээсээ энийгээ яг ингээд солиод өгвөл ер нь бид нарт бүгдэд нь аягүй аятайхан зохистой ийм юм болох гээд байгаа юм. Тэгэхгүй бол энийг би ерөөсөө хувьдаа бол огт дэмжмээргүй байгаа юм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ бол үндэсний эв нэгдэл, үндэсний эрх ашгийг эрхэмлэх биш ээ. Улсын эрх ашиг 1 дүгээрт, улс төрийн намын эрх ашиг 2 дугаарт, эцэст нь хувийн эрх ашиг байх зарчмыг үнэт зүйлээ болгон гэж энэ Засгийн газраас орж ирсэн, өөрөөр хэлбэл энэ 3 намын гэрээнийхээ хүрээнд оруулж ирсэн хувилбар шүү. Ажлын хэсэг энийг нь яг тэр чигээр нь авсан юм байгаа юм. Тэгэхээр өнөөдөр ажлын хэсгийн оруулж ирснээр бол бид нар санал хураагаад л

явчихна. Та хэрвээ шаардлагатай гэвэл өөрөө яг энэ хэсэг дээр санал хураалгаж болно. Санал хураалт. Ажлын хэсэг дээр гарсан энэ саналаараа яваад, хэрвээ та Засгийн газрын гишүүн. Тэгээд Засгийн газар чинь орж ирсэн хувилбараар бид нар тэр чигээрээ л орж ирж байгаа шүү дээ. Энэ 8 дээр чинь Монгол, Францын хамтарсан уран, атомын цахилгаан станц гэгчихсэн байна шүү дээ. Засгийн газар өөрсдөө оруулж ирсэн санал шүү дээ. Тэгвэл албан ёсоор уучлаарай бид нар буруу зүйл хэлчихжээ. Тэгээд энийгээ засаж өгнө үү гээд албан ёсныхоо хүсэлтийг гаргаадаг даа. Тэгж байгаад тэгвэл ажлын хэсгийн юун дээр засвар оруулъя. Та бүхний өргөн барьсан асуудал чинь л явж байгаа шүү дээ. Засах юм уу. Гантөмөр Шадар сайд.

**Л.Гантөмөр:** Энэ ийм байгаа юм. Монгол, Францын хамтарсан ураны төслийг хэрэгжүүлнэ. Та ингээд найруулга дээр хараадхаарай. Монгол, Францын хамтарсан ураны төслийг хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжиж үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажилласнаар жилд 2500 тонн уран олборлож экспортолно. Төсөл хэрэгжих хугацаанд улс орон нутгийн төсөвт 1 тэрбум гаруй ам.долларын татвар төлнө. Үйлдвэрлэлийн туршилтын төсөл дээр үндсэн үйлдвэрлэлийн олборлолт эхлэхэд 1 мянга гаруй ажлын байр бий болно. Улс, орон нутгийн хэмжээнд томоохон худалдан авалт бизнесийн боломж нэмэгдэнэ. Монгол Улсад атомын цахилгаан станцыг байгуулах суурийг бүрдүүлнэ гэж ингээж найруулмаар байна.

Яагаад гэвэл бид нөгөө гишүүдээс санал авахад гишүүд тийм санал гаргасан юм л даа. Уран олборлоё, атомын станцаа яах юм бэ гэж. Түүнээс биш яг энэ гэрээгээр атомын станц байгуулах тухай биш байхгүй юу. Тэгэхээр саяын миний найруулгыг аваад явчихад.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгэхээр ийм байгаа шүү. Миний гар дээр байгаа та бүхний өргөн барьсан хөтөлбөрт 8 дугаар хуудсан дээр энэ таблицар орж ирсэн. Тэгээд өмнөтгөл дотор хэрвээ таблицар орж ирэх юм бол хавсралт гэж орж ирэх нь зүйтэй байсан байх. Үг, өгүүлбэрээрээ байх ёстой байсан зүйлийг та нар яг үндсэндээ бол Монгол бичгийн хэл соёл энээ тэрээ гэсэн юм чинь энэ дээр бол дутагдаж байгаа шүү. Тэгээд энийг чинь зассан юм. Энэ дотор байж байгаа тэр үг, үсэг Монгол, Францын хамтарсан уран, атомын цахилгаан станц гэгчихсэн байж байгаа шүү.

**Л.Гантөмөр:** Харин тэгэхээр энэ 2 ингээд 2 өөр агуулгыг нэг өгүүлбэрт багтааж оролцсон байхгүй юу.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгвэл наад томъёоллоор чинь аваадахъя. Яг томъёолол чинь юу гэж байгаа юм.

**Л.Гантөмөр:** Харин би түрүүн хэллээ шүү дээ. Унишихдаа одоо яг миний хэлж байгаагаар Монгол, Францын хамтарсан ураны төслийг хэрэгжүүлнэ гэж эхлээд одоо энэ таны найруулсан өгүүлбэр бүтнээрээ яваад төгсгөл дээр нь Монгол Улсад атомын цахилгаан станц байгуулах гээд оруулчих байхгүй юу. Наадах чинь таслалтай юмыг ингээд хутгаад байгаа байхгүй юу. 2 өөр агуулгатай юмыг 1 хүснэгтэд хийчихсэн байна. Энэ 2 бол 1 төсөл юм гэж ингээж тайлбарлаад байна шүү дээ. Гэтэл энэ 2 чинь тусдаа 2 төслийг 1 абзасад оруулаад л тавьчихсан асуудал байгаа байхгүй юу.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгвэл саяын томъёоллыг чинь авах уу Учрал сайд аа. Учрал сайд.

**Н.Учрал:** Энэ бол нөгөө өмнөтгөл дээр байгаа нөгөө ерөнхий 15 төслийн жагсаалтын хүснэгтэлсэн заалтыг нөгөө өмнөтгөлийг багасгаад 3 хуудас болгохдоо ингээд нэгтгэж ингээж унишигдаад байгаа юм. Тэрнээс биш яг энэ

хөтөлбөр дотроо 3.3.3.7 гээд ингээд салгачихсан байгаа байхгүй юу. Ураны нөөцийг түшиглэн атомын цахилгаан станц барих бодлого хэрэгжүүлж, суурь судалгааг хийнэ. 3.3.1.14 дээр Зөвч овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулна гээд. Энэ бол яг Эдийн засгийн яамны үр дүнг хэмжих гээд байгаа заалт нь тусдаа. Зүгээр бид бол нөгөө 15 төслөө бичихдээ энэ 8 дээр нь Монгол, Францын хамтарсан уран таслал атомын цахилгаан станц гээд энэ төсөл нь ямар төсөл юм бэ гээд нөгөө хүснэгтэлж оруулсныг сая нөгөө ажлын хэсгээс ингээд 3 хуудас болгохдоо өгүүлбэр болгоод ороод ирэхээр буруу уншигдаад байгаа юм. Тэрнээс биш яг энүүгээрээ ингээд явахад бол хүснэгт дээр бол ямар нэгэн асуудал байхгүй. Зүгээр Эдийн засгийн яамны үндсэн чиглэлийн төслүүд дотор бол тэр 3.3.3.7, 3.3.1.14 бол тусдаа. Тэгэхээр сая Гантөмөр сайдын хэлж байгаагаар зүгээр.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэр ар талынх чинь бол заалт нь бол тэр чигээрээ байж байгаа. Тэр бол дахиад бид нар санал хураахад орж ирнэ. Тэр дээр саналаа хэлээрэй. Ямар ч байсан саяын үг өгүүлбэр дээр редакцын хувьд найруулга аваад, Учрал гишүүний хэлсэнчлэн найруулга, Гантөмөр гишүүний найруулгыг оруулаад тэгээд явчихъя. Санал хураалт. Хэд вэ. 17-12 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.1.1.“20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын бичиг баримтыг боловсруулж, үүнд суурилсан “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040” болон бусад хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тоолоорой. Тоогоо

хурдан гаргаад явчих. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.2.Эрчим хүчээр хангагдсан хот” зорилтод доор дурдсан агуулгатай 1.1.2.12 дахь заалт нэмэх:

“1.1.2.12.Багануурын дулааны станцын зуух, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөн шинэчилж, засварлана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.3.Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт” зорилтод доор дурдсан агуулгатай 1.1.3.7 дахь заалт нэмэх:

“1.1.3.7.Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, нийслэлийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор нэг удаа орон сууцны дулаалгын ажлыг хийнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Учрал гишүүн. Учрал гишүүний микрофон.

**Н.Учрал:** Энэ саналыг бол Засгийн газар дэмжих боломжгүй. Энэ чинь татвар төлөгчдийн мөнгөөр хувийн өмчийн орон сууцуудыг дулаалах гэсэн ийм нэг ийм зарчмын санал ингээд нэмээд байж болохгүй шүү дээ. Тэр чинь сууц өмчлөгчдийн байгууллага нь байна. Орон нутгийн хөгжлийн сан нь байна. Дүүрэг, орон нутгийн төсөв мөнгө нь байна. Тэгээд ингээд дулаалгыг Засгийн газрын хөтөлбөр дээр 1 удаа дулаална энэ тэр гэж энэ заалт байх тохиромжгүй байх л гэж би үзэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ ажлын хэсэг дээр орж ирсэн санал шүү. Тэгээд ер нь бол яах вэ, нийт дулааны алдагдлыг бууруулах үүднээс 1 удаадаа нэг ийм арга хэмжээ зохион байгуулчихвал, цаашидаа бол бид нарын энэ дулаан хангамжтай

холбоотой асуудал дээр боломж бололцоо нь нэмэгдэж өргөчих юм гэсэн ийм санал орж ирсэн. Тэгээд мэдээж одоо санал хураалт явуулна. Саяын Учрал сайдын хэлснийг та бүхэн тэгээд болгооно биз. Санал хураалт. 17 гишүүнээс 1 гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.3.5 дахь заалтын “татварын хөнгөлөлт” гэснийг “дэмжлэг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тоолоорой 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.5.3 дахь заалтын “уялдаа холбоог хангаж,” гэсний дараа “зорчигч тээврийн логистик төвийн хамт” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-13 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын “1.2.1, 1.2.2-ийн гарчгийн “Дагуул хотуудын” гэсний өмнө “Улсын зэрэглэлтэй болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

9.Төслийн “1.3.4.Говийн бүс-“Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1.3.4.6.Даланзадгадад 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг барина.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.2.1 дэх заалтын “Номтын аманд” гэсний дараа “эрчим хүчний хэмнэлттэй” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.1.5 дахь заалтыг “3.3.7.Шинжлэх ухаан, технологи, инновац” гэсэн зорилтод шилжүүлэх:

“1.2.1.5.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулна.” Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.5.3 дахь дараах заалтыг хасах:

“1.3.5.3.Шүрэнгийн усан цахилгаан станц барина” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-7 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

13.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.4.3, 3.3.3.24, 3.3.3.25, 3.3.3.26, 3.3.3.31 дэх дараах заалтуудыг тус тус хасах:

“1.3.4.3.Говийн бүсэд нар, салхины тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барина.

3.3.3.24.Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт нар, салхины нөөцийн давхцалын бүсүүдийг түшиглэн 3 ГВт-ын нар, салхины сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барьж байгуулах, экспортлох төслүүдийг дэмжинэ.

3.3.3.25.Чойрт 100 МВт салхи, 40 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.

3.3.3.26.Мандалговь 200 МВт нарны цахилгаан станц, 100 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.

3.3.3.31.Мандалговийн 2,000 мвт нар-салхины эрчим хүчний паркийн төслийг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Дахиад санал хураалт саяынхыг хүчингүй болгоё. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё. Энэ асуулт хариулт яваад хажуугаар будилуулаад байх шиг байна.

Салбарын төлөөлөл, ажлын хэсэг дэх төлөөлөл энэ дээр бол урьд өмнө нь хариулт өгсөн байгаа. Ажлын хэсэг дээр хариултаа өгчихсөн. Тийм болохоор санал хураалт. Санал хураалт. Алив өргөвөл өргөсөн шиг өргөөрэй. Тийм 17-10. Санал дэмжигдлээ. Хасаж байна. Энэ чинь саяын хүчингүй болсон санал. Хүчингүй болсон тийм үү. Дахиад санал хураалт. Санал хураалт хасна гэж байгаа шүү. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Анхааралтай, анхааралтай, анхааралтай. Энэ саналуудаа харж бай. Та нарын гар дээр чинь наана чинь байж байгаа шүү дээ. Араас нь хөөгөөд хар л даа:

14.Төслийн 1 дүгээр хавсралтын “1.4.2.Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилт” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1.4.2.7.Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 17-13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.23 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.1.23.Төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Зарим нь гараа нууж өргөөд байна уу, үгүй юу. Хэд вэ. 17-13 санал дэмжигдлээ. 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

16.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.3.11 дэх дараах заалтыг хасах.

“2.1.3.11.Орлого багатай иргэдийн нэмэлт орлогын эх үүсвэрээс авах татварыг бодлогоор бууруулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 17-13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

17.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.1.9.Өсвөр үеийн окид, хөвгүүдийн дунд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, үе тэнгийн зөвлөгч бэлтгэх, тэднээр дамжуулан мэдээллийг өсвөр үеийнхэнд хүргэх, шаардлагатай үйлчилгээнд зуучлах нууцлалтай чатбот үйлчилгээг хөгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

18.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.1.11.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг баталж, төр болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

19.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.3.Нийгмийн баталгаа” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.3.17.Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Дахиад униших уу.

2.1.3.17.Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө. Санал гаргасан ажлын

хэсэг. Санал хураалт. 17-12 санал дэмжигдлээ.

20.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.3.3 дахь заалтын “мастер төлөвлөгөөг” гэсний дараа “хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

21.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.2.7 дахь зорилтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.4.2.7.Үл хөдлөх салбарын хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Хэд вэ. 17-7 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

22.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.1.3.Банк, санхүү, даатгалын салбарын реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.1.3.11.Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжиж эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандартын дагуу баригдах амины орон сууцны ипотекийн зээл болон жижиг дунд үйлдвэрийн тогтвортой, ногоон зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор “Монголын ногоон санхүүгийн корпорац”-ыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тодруулах биш, зүгээр санал хэлж болно. Үг хэлж болно шүү дээ. Үг хэлье. Саналаа өгье. Найдалаа гишүүний микрофоныг нээе.

**Б.Найдалаа:** Энэ дээр товчхон 1 нэмэлт мэдээлэл өгье. Ойлгомжгүй санагдаж магадгүй. Энэ бол 1 дүгээрт шинэ зүйл ердөөсөө биш. 10-аад жил явж байгаа төсөл. Тэгээд Сангийн яам, Байгаль орчны яам, засаг дээр ингээд хуралд нь ч орчихсон байгаа юм.

2-т нь 2024 оны төсөвт тусгачихсан ажил гэж ойлгож байгаа. Одоо энэ Сангийн яамныхан, Байгаль орчны яамныхан бас нэмээд тайлбар хэлнэ биз. Тусгачихсан ажил. Энэ ямар учиртай вэ гэхээр Уур амьсгалын ногоон сан буюу нөгөө Жи Си Эф-ээс Монгол Улс анх удаагаа экюти буюу өөрийн хөрөнгийн ингээд санхүүжилт авах анхных нь улс байхгүй юу. Тэгээд 28 сая долларын жилийн 1,5 хувийн хүүтэй, маш хөнгөлөлттэй, 20 жилийн хугацаатай зээл. Дээр нь 2 сая долларын буцалтгүй тусламжтай ийм баталчихсан, 2020 онд баталчихсан юм байгаа юм. Энэ юу гэх вэ гэхээр нөгөө гэр хорооллын эрчим хүчний хэмнэлттэй байшин, цаашидаа тэр бүхий л ногоон зээлүүдийг барилгажилт өөр юу байдаг юм. Хөдөө аж ахуй, зээлүүдийг авах нөгөө платформ, санхүүгийн байгууллага нь байгуулж байгаа төсөл юм. Маш чухал. Энийг хийчих юм бол цаашидаа хөдөө аж ахуй бусад юу байдаг юм. Хүлэмжийн хий, ногоонтой, эрчим хүчний хэмнэлттэй холбоотой санхүүжилтийг татах боломж бүрдэх юм байгаа юм. Тэгэхээр энэ бол ингээд ойлгомжгүй юм шиг боловч гишүүдээ явж байгаа төсөл. Манай яамныхан бас нэмэлт мэдээлэл өгөөрэй. Төсөвт суучихсан байгаа. Харин үйл ажиллагааны хөтөлбөр яагаад ороогүй байгаа нь ойлгомжгүй байсан болохоор ингээд санал гаргаад оруулсан шүү. Хэрвээ энд ингээд батлагдахгүй бол Монгол Улс Уур амьсгалын ногоон сангийн юунд маш эвгүй байдалд орох бөгөөд цаашидаа төсөл батлахад саад болох юм байгаа юм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. Би бол үг өгөөд байгаа шүү дээ. Үг өгөөд эндээс та бүхэн тэгээд дэмжих, дэмжихгүйгээ бас тайлбар дээр нь өөрсдийнх нь шийдлийг гаргаж байгаа шүү дээ.

23.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.2.Бизнес, хөрөнгө оруулалтын

таатай орчин” зорилтод доор дурдсан агуулгатай 3.2.2.14 дэх заалт нэмэх:

**“3.2.2.14.Төсвийн**

хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

24.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.2.1 Татвар нийгмийн реформын нийгмийн, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.1.Татвар, нийгмийн даатгалын реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

**“3.2.1.8. “Ашигт**

малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг шинэчилнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хэлье гэж байна. Учрал гишүүн.

**Н.Учрал:** Энэ АМНАТ-тай холбогдох эрх зүйн зохицуулалт гэдэг ийм яг зохицуулалт бол засгийн хөтөлбөрт оруулж бол болохгүй байх. Энэ АМНАТ бол Үндсэн хуулийн зохицуулалттай татвар. Тэгээд одоо нөгөө хөрөнгө оруулалтын олон гэрээ хэлцэл хийгдэж байгаа ийм үед АМНАТ-ын эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж хөрөнгө оруулагч нарт ийм тогтворгүй байгаа юм шиг мессеж өгч болохгүй. Тэгэхээр нөгөө гэрээ хэлцэл хийгдэх гэж байгаа ийм үед одоо АМНАТ дээр ийм өөрчлөлт хийх юм байна гэдэг мессежийг өгвөл энэ хөрөнгө оруулагч нарт таатай сонсогдохгүй учраас энийг шаардлагатай бол тэр гэрээгээрээ, ажлын хэсгээрээ, Их Хурал дээр ажлын хэсэг байгуулаад шийдээд явах бүрэн бололцоотой учраас ингээж оруулах нь зохимжгүй байх гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Би ажлын хэсгийн даргын хувьд бас нэг тайлбар хэлээдэхье. Энэ АМНАТ-тай холбоотой асуудал давхардлаа гэдэг асуудлаар Цэцэд иргэнээс гомдол ирж байсан асуудал шүү дээ. Энэ дээр би өөрөө очиж асуудлыг нь сонсоод, Улсын Их Хурлын байр суурийг

хамгаалах гэж очсон хүн энэ аж ахуйн нэгжид хүндрэл учруулж байгаа юм байна гээд хамгаалж чадаагүй, хамгаалалгүйгээр буцаж байсан ийм түүхтэй юм байгаа юм шүү. Энд нэг давхардал яваад байдаг юм. Давхардаж АМНАТ авсан асуудал байдаг юм шүү. Тэгээд АМНАТ-ын давхардал гэдгээр үү. Тэгээд энийг буцаж эргэж харахгүй бол АМНАТ-д бүр том өөрчлөлт оруулж байгаа асуудал бас биш юм байгаа юм шүү. Тэгэхээр аж ахуй нэгжүүдэд хүндрэл учирч байгаа энэ АМНАТ-ын давхардлын асуудлыг гэгчих үү. Тэгвэл засвартайгаар үзэх үү. Туваан сайд.

**Ц.Туваан:** Энэ дээр манайх чинь энэ хөрөнгө оруулагчдад бол ерөөсөө маш таагүй нөхцөлийг маш олон жил бүрдүүлээд ирчихсэн. Ер нь бол манайд ер нь гаднын хөрөнгө оруулагч гэдэг хүн бараг үлдээгүй. Нөхдүүдийн ярьж байгаа зүйл нь бол уулзаад яг яриад явахаар та хэд энэ хөрөнгө оруулалтын асуудал тэр дундаа энэ АМНАТ-тай холбоотой асуудал дээр ингээд тогтворгүй байр суурийг маш их барьдаг. Тийм учраас бид нар энэ орчныг чинь харж байж хөрөнгө оруулна гээд ингээд орохгүй байгаа шүү гэдэг зүйл хэлсэн. Тэгэхээр Учрал сайдтай бол санал нэг байна. Энийг өөр байдлаар Ашигт малтмалын хуулийнхаа асуудал орох үед ч юм уу тийм байдлаар орсон нь дээр байх. Давхар энэ тэр гээд давхардаад бүр ойлгомжгүй болоод явчих байх.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалт. Үг хэлье гэж байна. Алтангэрэл. Кнопоо дар.

**О.Алтангэрэл:** Саяын Учрал сайдын бол саналыг дэмжиж байна. Тогтворгүй харагдана энэ дээр орж болохгүй гэдгийг. Тэгэхдээ АМНАТ-аа бол бид нар заавал ч үгүй хөдөлгөх ёстой байх. Тэгээд энийг бол хөдөлгөөд яваандаа ашигтайгаар хийхгүй бол тэгээд манайх дэлхийн чиг хандлага юмыг харалгүй яах вэ? Гэхдээ бид нар дотоодын уул уурхайн бодлогоо харахад

АМНАТ-аа зайлиггүй ярина. Энэ чинь бүр 1910-аад онд Богд хаант Монгол Ард улсын үед энэ уул уурхайтай холбоотой Оростой хамтарч хийх үед гарч байсан энэ ул уурхайн 4 зүйлийн бичигт хамгийн анх энэ роялтигийн тухай тусаж байсан. Манайх бас яривал 100 гаруй жилийн роялтигийн уламжлалтай улс. Тэгээд бид нар дахиж энэ хувь хэмжээг ярих ёстой. Зүгээр яг энд орох нь бол яг энэ тогтворгүй харагдана гэдэг Учрал сайдын байр суурийг дэмжиж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сайд нар минь тэгээд наад ярьсан, хэлсэн үгэндээ л байна шүү дээ. Аж ахжийн нэгжүүдэд хүндрэл учруулаад, давхардаж аваад байгаа асуудал байгаад Цэц дээр очиж хамгаалах гэсэн хүн буцаж ирээд харин эсрэгээр нөгөө хүмүүсийнх нь талд зогсоод яваад. Тэгээд Сангийн яамтай түлхэлцэж байгаад Сангийн яам нь ялаад би яаж ч чадаагүй ингээд явж байсан түүхээ ярьж байгаа юм шүү. Тэгээд аж ахуйн нэгжүүдийн тэр нөгөө тавьсан санал ингээд л унаж байсан түүхтэй юм шүү. Тэгээд энийгээ та бүхэн засаарай. Түүнээс биш одоо энэ дээр бол яах вэ, үг үсэг дээр зохицуулалтыг шинэчилнэ гэхээр бас жоохон хатуудчихаад байгаа байдал харагдаад байна. Санал хураалт 17-5 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй. Тэгээд саяынхаа хэлсэн сайд маань тэгээд үзээрэй энийгээ.

25.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.12 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.3.12. “10,000 нарны дээвэр” хөтөлбөрийг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

26.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр

логистик” зорилтын 3.3.2.18, 3.3.2.20 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.2.18.Гашиунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил дамнасан төмөр замуудыг барьж хөрш орны төмөр замтай холбоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Нэгтгэсэн шүү. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

27.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтын 3.3.1.13, 3.3.2.17 дахь дараах заалтуудыг хасах:

“3.3.1.13. “Сайншианд-Баруун-Урт-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.”

“3.3.2.17. “Сайншианд-Баруун-Урт-Хөөт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Давхардсан байсан байх энэ чинь. Санал хураалт. Зам, тээврийн яамны Болор-Эрдэнэ байна уу. Санал хураалтыг хүчингүй болгоё. Санал хураалт. Яригдсан шүү. Ер нь бол нөгөө давхардалтай байсан байх. Энэ ингэсэн шүү. Сайншиандаас явж байна тийм үү. Наад талын төмөр зам нь баригдаагүй байхад шууд Сайншиандын төмөр замаа ингээд заачихлаа гээд бодлогын хүрээнд бол яамны бодлогын хүрээнд бид энийг дэмжихгүй байгаа гэж дугарсан шүү. Бодлогын хүрээнд болбол дэмжигдэхгүй гэж хэлсэн шүү. Яг ажлын хэсэг дээр бол сууж байгаад хэлсэн. Санал хураалт 17-1 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Хүмүүс ээ, Учрал сайд аа. Ерөнхийдөө бол мэдээж бидний хувьд энэ хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд, та бүхний оруулж ирсэн хөтөлбөрийг аль болох эвдэхгүй гэсэн бодлогыг барьсан. Нэлээн ч олон гишүүдэд бас гомдол үлдээсэн.



Гомдолтой үлдээсэн. Гэхдээ ажлын хэсэг чинь жишээ нь яг энэ 27 дугаар зүйл дээр бол ажлын хэсэг чинь өөрсдөө яамны барьж байгаа бодлогын хүрээнд бол энэ зүйл заалт дэмжихгүй гээд дуугарчихсан шүү. Тэгээд энийгээ бас бодолцоорой та бүхэн минь.

28.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.1 дэх заалт, 3.3.1.7 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.1.Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Өөрчлөн найруулж байгаа шүү. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

29.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.2 дахь заалтын “Геологийн эрэл хайгуулын” гэснийг “Геологийн судалгаа, эрэл, хайгуулын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

30.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.3.Оюутолгойг түшиглэсэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. Энэ Оюутолгойг түшиглэн гэж байгаа шүү дээ. Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах. Ер нь бол нэг маргаан гарсан нь нийт зөвхөн Оюутолгойн зэсээ энд хайлуулах юм уу. Бусад ордуудаас гарсан зэсийн баяжмалыг энд авахгүй гэх асуудал бий болох вий дээ гэсэн асуудал гарч ирж байсан шүү дээ. Тэгээд тэр дээр бас цаашдаа анхаарахгүй бол.

31.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.4 дэх дараах заалтыг хасах.

“3.3.1.4.Оюутолгойтой дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.”Санал гаргасан ажлын хэсэг. Хасах гэж байгаа шүү. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ ингээд байгаа шүү дээ. Дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ гээд энэ чинь ямар нэгэн тооцоо мэдээлэл ТЭЗҮ байхгүйгээр шууд зүгээр эхлүүлнэ гэсэн үг, үсэг орчихсон байгаа шүү.

32.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.6 дахь заалт, 3.3.1.12 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.5.Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

33.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1.Уул уурхай” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.3.1.11.Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн зэс, молибдений ордын талбайн хил заагийн хүрээнд багтаж буй Оюут болон бусад хэсгүүдэд эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг тогтоож, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлэх, эрэл, хайгуулын ажилд дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

34.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.6.Соёлын бүтээлч үйлдвэрлэл” гэсэн гарчгийг “3.3.6.Соёл урлаг, соёлын өв уламжлал, соёлын бүтээлч үйлвэрлэл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ

35.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.6.4.Түүхэн дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, “Соёлын биет өвийг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

36.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.24 дэх заалт нэмэх:

“3.3.2.24.Эрэнцэв-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Барина. Заалт нэмж байгаа шүү. 17-12 гишүүн дэмжиж, 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

37.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.3.4.29.Мал аж ахуй, газар тариалан, жимс, хүнсний ногоо тариалалтад дэмжлэг үзүүлэх зорилготой хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн түрээсийн аж ахуйн тогтолцоог бий болгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

38.Төслийн Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.5.Дөрвөн улирлын аялал жуулчлал” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.3.5.12.Дундговь аймгийн Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

39.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр, логистик” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.25 дахь заалт нэмэх:

“3.3.2.25.Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4D ангиллын болгон өргөтгөнө.”Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. Их л сайн юм байгаа. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

40.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн зорилтод “3.3.3.42.Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Чойр-Сайншанд чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг тус тус барина.” гэсэн заалт нэмж, 3.3.3.30 дахь заалтаас “Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ,” гэснийг, 3.3.3.37 дахь заалтаас “Тавантолгойн ДЦС-Оюутолгой,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-6 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

41.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.38 дахь дараах заалтыг хасах.

“3.3.3.38.Аймгийн төвүүд, сум суурин газруудын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулах, үр ашиг өндөртэй нүүрс, сэргээгдэх эрчим хүчний технологийг ашигласан

станциудыг байгуулах суурь судалгааг хийх, төслүүдийг эхлүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ ерөөсөө санал хураалт явж байгаа шүү дээ. 17-6 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй шүү.

Аймгийн төвүүд, сум суурин газруудын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулах гэж байгаа шүү дээ. Чухал санал уналаа шүү дээ. Үр ашигтай хасах хасмааргүй байхгүй юу даа. Харин тийм өн яагаад үлдэж байгаа юм. Хасъя гэсэн хасахгүй гэж байгаа юм уу. Санал дэмжигдсэнгүй.

42.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.41 дэх дараах заалтыг “1.4.1.Шилжилт хөдөлгөөн” гэсэн зорилтод шилжүүлэх:

“3.3.3.41.Төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг нь харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлнэ.” гэж байна. Санал гаргасан ажлын хэсэг. Эрчим хүчний асуудал энэ зорилтод зүгээр шилжүүлж байгаа шүү дээ. Суучихсан байгаа асуудал. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.41 дэх дараах заалтыг нэгийн 4.1 шилжилт хөдөлгөөн гэсэн зорилтод шилжүүлж байгаа шүү дээ. Ийм заалт байсан байхгүй юу. Байсан заалт шүү дээ. Түрүүний санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн Баярбаатар Алив наад дээрээ хэлээрэй. Баярбаатар гишүүний микрофоныг нээе.

**Б.Баярбаатар:** Энэ ойлголтын зөрөө гарсан байна. Зарим Байнгын хороодын гишүүдийн буруу ойлголтоос болоод саяын санал дэмжигдсэнгүй болох

шиг боллоо. Тэгэхээр санал хураалтыг хүчингүй болгоод, дахиад санал хураалт явуулъя гэж оримын санал гаргаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал хураалт хүчингүй боллоо. Одоо би 42-ыг дахиад уншаадахъя. Ойлгосон уу. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. Дархан-Уул аймагт нүүнэ гэж байна шүү дээ. Үгүй ээ, үгүй оруулаагүй. Энэ чинь байсныг шилжүүлж байгаа шүү дээ.

43.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4.4 дэх заалтын “экспортлоход анхаарна” гэснийг “экспортолно” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-10. Санал дэмжигдлээ. 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

44.Төслийн Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.26 дахь заалт нэмэх.

“3.3.2.26.Ханх-Хатгал чиглэлийн автозамыг барина.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ аялал жуулчлалаа дэмжиж байгаа байлгүй дээ. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

45.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.35 дахь дараах заалтыг хасах:

“3.3.3.35.Дархан УХУЦС 100 МВт төслийг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Хасна гэсэн заалт байна. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

46.Төслийн Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.7.1 дэх заалтын “Шинжлэх ухаан” гэсний өмнө “Шинжлэх ухаан технологийн арга хэмжээний зардлыг ДНБ-ий 1%-д хүргэж,” гэж нэмэх. Санал гаргасан

ажлын хэсэг. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

47.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.7.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.7.7.Үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн сангийн MORI платформыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэдлэгийн Data center байгуулна” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

48.Төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 3.3.4.3 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.4.3.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт.

Энэ мал аж ахуйн чиглэлээр энэ юу шүү дээ. Шинэ хоршоо хөтөлбөрт чинь маш их зааварчилгаа, сургалтын асуудлууд хэрэгж, мэдээллийг шинэ хоршоо хөтөлбөрт мэдээлэл өгөх ийм заалт байгаа шүү дээ. Тэгээд миний буруу ойлголт явчих шиг боллоо гээд санал хураалтыг хүчингүй болгоё. Энэ дээр ийм санал орж ирсэн шүү. Сая шинэ хоршоо гэдэг хөдөлгөөн явсан. Энэ бол малчдыг хоршоожуулах, мал аж ахуйгаа сэргээх, мал аж ахуйг бол ер нь дээд өндөр түвшинд оруулах ийм том боломж бололцоог хангасан ийм төсөл явж байгаа. Харамсалтай нь яг газар дээрээ бол энэ төслийг хэрэгжүүлэх сургалт, судалгаа, мэдээлэл маш шаардлагатай байгаа. Зайлиггүй ийм зүйлийг хийх ёстой. Малчдын хувьд бол үнэхээр яаж явах юм. Ямар зүйл дээр хоршиж болох юм. Ямар зүйлийг үйл ажиллагаа дээр нь

анхаарах юм. Нэн тэргүүнд эхний ээлжид ямар ямар бизнесийг дэмжих боломж бололцоотой юм гэсэн ийм зүйлүүд бол маш их шаардлагатай. Малчдаас бас олон ийм саналууд ирж байгаа. Тийм болохоор энэ дээр энэ санал орж ирсэн. Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах гэж байгаа шүү. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хоршоодын загвар, төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөх, туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх гэж байгаа. Саяын очсон сургагч багш нэртэй хүмүүс маань шинэ хоршоогоо ч ойлгохгүй, хөдөө аж ахуйгаа ч ойлгохгүй ийм хүмүүс одоо газар дээрээ очсон шүү дээ. Олигтой тийм зөвлөмж тусламж бол өгч чадаагүй байхгүй юу даа. Солонгосын шинэ тосгон гэдэг хөтөлбөр хэрэгжээд өнөөдрийн Солонгос улсыг хөгжүүлэхэд маш том үүрэг гүйцэтгэсэн байгаа. Энэ дээр бол дандаа тийм зөвлөхүүд ажиллаж байж хүмүүсийг хөл дээр нь босгосон шүү дээ. Тэгээд тэр утгаар нь бол энд зөвлөн туслах үйлчилгээ бол зайлиггүй хэрэгцээтэй юм гээд. Ингээд үг хэллээ. Хүчингүй болгох санал явчихсан шүү дээ. Түрүүний санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт 17-8 гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй. Тэгэхээр энэ санал унаж байна. Хөдөө аж ахуйдаа хайргүй л хүмүүс байгаад байгаа юм даа. Энэ хүмүүс 5 төгрөгтэй болчихъё гэсэн асуудал дээр дэмжихгүй гэсэн үг үү. Наад гаргаж байгаа мөнгө чинь шинэ хоршоогоор явж байгаа дэмжлэг, энэ мөнгөний санхүүгийн дэмжлэг. Авсан дэмжлэгээ бол шууд хүмүүс газар булчхаж байгаа асуудал биш шүү дээ. Санхүүгийн дарамт болох асуудал байхгүй. Засгийн газар иймэрхүү бодлого барьж байгаа юм бол тэгээд ёстой харин наадахтай чинь үзэх ёстой юм байна даа. Цаашидаа бол.

49.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4. Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр”

зорилтод доор дурдсан агуулгатай  
3.3.4.29 дэх заалт нэмэх:

“3.3.4.29.Хоршоодод  
“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд  
малын гаралтай түүхий эд боловсруулах  
үйлдвэрийг байгуулах, хувьцаа эзэмших,  
хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлж,  
хоршооны үйл ажиллагааг дэмжинэ.”  
Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Энэ дээр зүгээр  
найруулгын юм байгаа юм. Хоршоодод  
шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд малын  
гаралтай түүхий эд боловсруулах  
үйлдвэрийг байгуулах, хувьцаа эзэмших,  
хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх,  
хоршооны үйл ажиллагааг дэмжих  
зорилготой малын эзэн, үйлдвэрийн эзэн  
гэдэг хөтөлбөр хэрэгжүүлнэ гээд энэ  
арынх нь тэр үгийг бас нэмэх хэрэгтэй  
байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Наадах чинь хаана  
орсон гэж байгаа билээ. Ардчилсан  
намын мөрийн хөтөлбөр байгаа мөн үү.  
Одоо саяын хэлсэн хүмүүс бодолцоорой.  
Ардчилсан намын мөрийн хөтөлбөр  
дотор шинэ хоршоо хөдөлгөөнөө  
дэмжих, малчдаа өөрсдөө малын түүхий  
эд боловсруулах үйлдвэрийнхээ  
өөрсдийнхөө хувьцаа эзэмшдэг өөрсдөө  
энэ үйлдвэрээ дэмждэг ийм нөхцөлийг  
бол Ардчилсан намын мөрийн хөтөлбөр  
туссан байгаа шүү. Тэгээд энэ дээр харин  
томъёоллыг дутуу өгчихсөн байсныг нь  
саяын томъёоллыг оруулна. Юу гэж  
байгаа билээ. Малын эзэн, үйлдвэрийн  
эзэн энэ нэрийг оруулах юм шүү. Малын  
эзэн, үйлдвэрийн эзэн гэсэн энэ  
өөрчлөлттэйгээр оруулчихъя. Санал  
хураалт 17-9 гишүүн дэмжиж, дөнгөн  
данган дэмжигдлээ дээ.

50.Төслийн Төслийн 1 дүгээр  
хавсралтын “3.4.3.Ногоон эдийн засаг,  
ногоон хөгжлийн загвар” зорилтод доор  
дурдсан агуулгатай 3.4.3.11 дэх заалт  
нэмэх:

“3.4.3.11.Орхон-Онги,  
Хэрлэн-Тоонот ус дамжуулах шугамыг  
барина.” Санал гаргасан ажлын хэсэг.  
Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж,  
санал дэмжигдлээ.

Гишүүд маань гишүүд маань утсаа  
харж байна уу, эсвэл энэ цаасаа харж  
байна уу.

51.Төслийн 1 дүгээр хавсралтын  
4.1.5.Парламентын засаглал ба эрх  
мэдлийн хяналт, тэнцэл” зорилтын  
гарчиг болон 4.1.5.1 дэх заалтыг хасаж,  
4.1.5.2 дахь заалтыг “4.1.1.Хүний эрх”  
зорилтын 4.1.1.6 дахь заалт болгон  
шилжүүлж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.1.5.1.Улс орны  
хөгжлийн амин чухал асуудлаар үндэсний  
зөвшилцөлд хүрч, төрийн залгамж чанар,  
бодлогын тогтвортой байдлыг хангах  
бөгөөд улс төрийн намуудыг нийтийн эрх  
ашгийн төлөө үйлчилдэг бодлогын  
институц болгох эрх зүйн орчныг  
бүрдүүлж, хатуу гишүүнчлэлээс  
татгалзаж, санхүүжилтийг ил тод  
болгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.  
Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж,  
санал дэмжигдлээ.

52.Төслийн 1 дүгээр хавсралтын  
4.1.6.5. дахь заалтыг доор дурдсанаар  
өөрчлөн найруулах:

“4.1.6.5.Хууль зүйн дэд  
бүтцийг хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлээр  
эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”  
Санал гаргасан ажлын хэсэг. Санал  
хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал  
дэмжигдлээ.

53.Төслийн 1 дүгээр хавсралтын  
4.1.1.2 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.2.“Монгол Улсад  
Хүний эрхийг хангах үндэсний II  
хөтөлбөр” батлуулж, хэрэгжүүлнэ.”  
Санал гаргасан ажлын хэсэг. Санал  
хураалт. Алтангэрэл сайд. Алтангэрэл  
сайдын микрофоныг нээе.

**О.Алтангэрэл:** Энэ дээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд 2023 онд ноднин Женевт зохион байгуулагдсан 75 жилийн ойд зориулсан өндөр дээд арга хэмжээний үеэр Монгол Улсын гадаад харилцааны сайд Батцэцэг сайд Монгол Улс хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр баталж хэрэгжүүлнэ гээд дэлхийн улс орнуудын өмнө Хүний эрхийн түгээмэл тунхаглаалд нэгдсэн НҮБ-ын гишүүн улс орнуудын өмнө амлалт авчихсан юм байна лээ. 2003 онд Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг тухайн үеийн Ерөнхий сайд Намбарын Энхбаяр, тэгээд Төмөр-Очир дарга тэргүүтэй Улсын Их Хурал баталж хэрэгжүүлсэн. Яг одоо үзвэл энэ хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан олон зүйл заалт манай улсад хэрэгжээгүй. Одоо бол тулгамдсан асуудал байгаа учраас энэ асуудлаа хэрэгжүүлэх хүрээнд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр 2-ыг баталж хэрэгжүүлнэ гэсэн ийм зорилт тавьсан. Тэгээд энэ мөрийн хөтөлбөрөөс хасагдах юм бол 1 дүгээрт энэ дэлхийн улс орнуудын өмнө өгсөн амлалт, 2 дугаарт хүний эрхийн чиглэлээр тавьсан зорилго хангагдахгүйд хүрэх ийм үр дагавартай шүү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд хөтөлбөр биш бодлогын бичиг баримттай байна гээд суулгачихсан байгаа. Богино, дунд, урт хугацааны бодлогын бичиг баримттай байна гээд. Тэгэхээр хөтөлбөр гэдэг утгаараа бол энэ хасагдаж байгаа юм шүү. Санал хураалт. 17-5 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

54.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.15 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.15.Монгол Улсын Үндсэн хууль, хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн байгууллагын захиалгаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл

ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий Хууль судлалын институтыг байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

55.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.17 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.17.Үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

56.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.18 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.18.Хорих ял эдлүүлэх орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор “Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага”-ын цогцолбор барилгыг ашиглалтад оруулж хүний эрхийг хангана.”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

57.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.2.Хэвлэлийн эрх чөлөө” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.2.2 дахь заалт нэмэх:

“4.1.2.2.Олон нийтийн радио, телевизийн бие даасан байдлыг хангах, хариуцлагатай, хараат бус, иргэдийг соён гэгээрүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн нийтлэлийн бодлоготой болгох чиглэлээр эрх зүйн орчныг шинэтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

58.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.2. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн

хэрэгжилтийг эрчимжүүлнэ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

59.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.4 дэх заалтыг хасах:

“4.2.1.4.Авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулах, хууль сахиулах байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх болон нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

60.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.15.Тагнуулын үйл ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагааны зааг ялгааг тодорхой болгож, эрх зүйн орчныг тус тусын хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгоод Учрал гишүүн санал хэлье.

**Н.Учрал:** Яах вэ, найруулга дээр зүгээр тагнуулын үйл ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно гээд л ерөнхий байдлаар найруулбал ямар бол. Тагнуулын үйл ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно гээд явах уу гэдэг зүгээр санал байна. Засгийн газрын хөтөлбөр дээр яг ингээд зааг ялгааг ингээд, тэгээд гээд нөгөө Их хурлын бараг нөгөө өргөн барих хуулиар нь хуулийг нь бүр ийм нарийвчлан зааж байгаа юм шиг хөтөлбөр байж болох уу л гэдэг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэмүүжин гишүүн тайлбар хэлье.

**Х.Тэмүүжин:** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засгийн газар

өөрөө баталчихдаг байсан бол тэгж болох байх. Энэ бол Улсын Их Хурал баталж байгаа. Улсын Их Хурал араас нь Засгийн газрыг энэ ажлаа хийж байна уу, үгүй юу гэдгийг шалгана. Хянана шүү дээ. Тийм учраас энэ Улсын Их Хурал баталж байгаа учраас Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдлаа гэдэг ойлголт бол байж болохгүй шүү дээ. Бид нар өөр өөрсдийнхөө эрхэд халдана, хязгаарлана гэдэг ойлголт байхгүй. Улсын Их Хурал олонхоороо л асуудлаа шийдэж байгаа. Энэ найруулгыг нэлээн сайжруулж байгаад оруулж ирсэн хувилбар нь энэ. Эсвэл хуучнаараа явж бас болно. Тагнуулын үйл ажиллагааны болон нууц мөрдөн шалгах ажиллагааны зааг ялгааг тодорхой болгож гээд концепцыг нь шаардаж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсэг дээр бас найруулгын нэлээн асуудлууд яригдаж байж найруулга хийсэн юм байгаа юм. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

61.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.11 дэх дараах заалтыг хасах:

“4.2.3.11.Төрийн албан хаагчдын цахим мэдээллийг өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг сайжруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

62.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.3 дахь заалтын “Авлига” гэсний өмнө “Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг үргэлжлүүлж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

63.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

**“4.2.3.12.Хууль**

сахиулагчдын мэргэшил, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулж, хууль сахиулагч болон хууль сахиулах албаны эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, эрх зүйн орчныг бий болгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

64.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.4.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“4.2.4.3.Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.”** Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

65.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“4.2.3.Төрийн албаны шинэчлэл**

**4.2.3.1.Хөгжлийн**

бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурласан захиргааны оновчтой, уян хатан, үр дүнтэй, үр ашигтай төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний төрлийг оновчилж, чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, цомхон, төрийн албыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулан, төрийн захиргааны албан хаагчдын тоог үе шаттайгаар зохистой хэмжээнд хүргэнэ.

**4.2.3.2.Хяналт шалгалт,**

хүний нөөцийн аудитын тогтолцоог оновчтой бүрдүүлж, хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэл, үр дүнд суурилан үнэн зөв, бодитой хийж, олон улсын үнэлгээнд нийцүүлнэ.

**4.2.3.3.Төрийн**

үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлж, төрийн мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халах, иргэн, хуулийн этгээд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ.

**4.2.3.4.Эрх мэдлийн**

төвлөрөл үүсгэсэн хууль тогтоомжийг өөрчилж, хөгжлийн чиг хандлага, бүсчилсэн хөгжилд нийцүүлэн, төрийн албаны хууль тогтоомжийн шинэтгэлийг эрчимжүүлнэ.

**4.2.3.5.Төрийн албанд ёс**

зүйн төлөвшлийг бэхжүүлж, ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг бий болгох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагад хэрэгжүүлэх, төрийн албаны чадамжид суурилсан хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд ёс зүйн хэм хэмжээ, шалгуур үзүүлэлтийг суурь болгоно.

**4.2.3.6.Төрийн албан**

хаагчийг улс төр, удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалт, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчмыг хангах, эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамтран хамгаалах боломжийг бүрдүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгон, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.

**4.2.3.7.Төрийн албаны**

хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, чадавхыг бэхжүүлэх, төрийн албан



хаагчийг мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулж, төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маши сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг гадаад улс орны болон ахисан түвшний сургалтад хамруулах чиглэл баримтална.

4.2.3.8. Төрийн албаны сургалтын байгууллагын бүтэц, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хувийн хэвилийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.2.3.9. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төрийн албан хаагчийг адил, тэгш боломжоор хангана.

4.2.3.10. Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, цахим мэдээллийг албан хаагчдад өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлэн, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хангана.

4.2.3.11. Төрийн албанд сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх, боловсруулах, монгол хэлийг ярианы болон бичгийн өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах хэлбэр, эрх зүйн орчныг шинэчлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хэлье гэж байна. Учрал сайд. Учрал сайдын микрофон.

**Н.Учрал:** Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн бас их том зорилт бол төрийн албаны реформ хийнэ гэдэг зорилт л доо. Тэгээд энэ зорилтын хүрээнд бол энэ төрийн албаны реформ хийх дээр маш тодорхой дэвшилтэт зорилтуудыг тусгасан юм. Тэгсэн чинь ингээд урагшилъя гэхээр урагшлахгүй гээд ингээд ажлын хэсэг дээр орж ирээд зарим нөхдүүд бас нэг ийм бүр өөрсдөдөө зориулаад нэг ийм хэдэн заалт бичсэн байна. Тэгээд та нар бол яг энэ заалтаа Засгийн газрын үйл ажиллагаа хөтөлбөр

боловсруулж байхад явуулсан. Тэгээд ийм боломжгүй гээд буцаасан. Тэгээд одоо Их Хурлын ажлын хэсэг дээр орж ийм мэдээлэл өгч байгаа юм байна л даа. Тэгээд төрийн албанд сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх чадвартай гэж энэ социализмын үг хэллэгээсээ салъя. Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх ур чадвартай. Тэр нөгөө *critical thinking* ур чадвартай гээд л ингээд л гоё бас урагшаа харсан дэвшилүүдийг тавьж өгсөн шүү дээ. Тэгэхэд Монгол хэлийг ярианы болон бичгийн өндөр ур чадвараа эзэмисэн иргэнийг сонгон шалгаруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ энэ тэр гээд ийм заалт ингээд бичээд ороод ирж байгаа шүү дээ. Одоо боль л доо. Тэгээд дараагийн даваа бол одоо энэ Их Хурлын гишүүд дээр бас ийм хэдэн заалт бичээд хураалгаж байгаа л даа. Одоо болих хэрэгтэй. Тэгээд дээрээс нь өөрсдөдөө зориулж ийм юм хийдгээ болих хэрэгтэй. Мэдээллийн систем бол нөгөө өгөгдөлд суурилсан шийдвэр гаргуулах гээд байгаа болохоос биш төрийн албан хаагч нарт өөрт нь зориулаад тоо баримт бүрдүүлж өгөх гээд байгаа хэлбэр биш шүү дээ. Тэгээд арай гэж салгах гээд тэгэхээр л буцаад оруулж ирээд хар даа. Өөрт нь зориулж мэдээлэл нэгтгэнэ ч гэх шиг. Өөрт нь нээлттэй болгох замаар иж бүрэн платформ хөгжүүлнэ энэ тэр гээд ингээд ийм 11 заалт бичиж ирсэн байна. Төрийн албаны зөвлөлийнхөн та нар болио. Тэгээд энийг дэмжиж чадахгүй. Засгийн газрын гол зорилт бол төрийн албаны реформ хийх гэж байгаа шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал сайд үг хэллээ. Санал хураалт. Кнопоо дар. Зулхар гишүүн.

**С.Зулхар:** Байнгын хорооны гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Энэ төрийн албаны реформ бол өөрөө их чухал бас ийм бидний зорилтын нэг. Гэхдээ энэ реформ бол өнөөдөр эхэлсэн биш угаасаа бараг бид бол 4 дэх, 5 дахь шат руугаа орж байгаа реформ л даа. Тэгээд өмнөх жишээ нь, оруулж

ирсэн заалтуудаар бол бүхэлд нь ер нь бол бид дэмжиж байсан. Гэхдээ бол бас өмнөх оруулж ирсэн зорилтуудтай холбоотой бас редакцын саналууд бол байгаа юм. Тэгээд редакцын саналаа би болон Эрдэнэбат гишүүн бид нар байж байна. Энэ дээр би түрүүн чуулганы хуралдаан дээр бас тодорхой хэлсэн юм. Нэр томьёо, ойлголт байгаа. Алсын хараа 2050 дээр чинь бүх юмаа бид нар тодорхой оруулчихсан байгаа байхгүй юу. Тэрийгээ бариад явж байгаа учраас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиа ер нь барьсан нь дээр байх. Сая зарим заалтууд бол Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуультай бол уялдахааргүй бас заалтууд байна. Тэгэхээр саяынхыг бол бүхэлд нь хүлээж авахгүй байдлаар саналаа хураачхаад, би зүгээр санал хэлж байгаа шүү. Дараа нь бол редакцын шинжтэй саналуудаа тусад нь дахиад хураалгавал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалт. Ядаж би дэмжээд хийчихье. 17-2 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй. Хуучнаараа үлдлээ. Тэгээд тэр дээрээ саяын редакц юмнуудаа хийгээд явчхаарай.

66.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.3.1.“E-Mongolia”-блок чейн-Цахим засаглал” зорилтод доор дурдан агуулгатай 4.3.1.6 дахь заалт нэмэх:

“4.3.1.6.Засгийн газрын тусгай сангуудын санхүүжилт, сонгон шалгаруулалтыг цахимжуулж ил тод болгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энийг дэмжсэн нь дээр байх. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

67.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.2.15 дахь заалтын “дээшлүүлэх шаардлага улам нэмэгдэж байна” гэснийг “дээшлүүлнэ” гэж өөрчлөх. Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

68.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.4.10 дахь заалтын “Гамигийн зураглал, эрсдэлийн мэдээллийн сан, гамигийн эрсдэл хуваалцах механизмыг хөгжүүлнэ.” гэснийг “гамигийн зураглал, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн мэдээллийн сан, гамигийн эрсдэл хуваалцах механизмыг хөгжүүлж, олон нийтэд нээлттэй болгоно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

69.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.1.6, 4.4.1.7, 4.4.1.8, 4.4.1.9, 4.4.1.10, 4.4.1.11 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.1.6.Хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлэх, мэргэшсэн хилчин, технологид суурилсан хил хамгаалах албыг бэхжүүлэн, зэвсэглэл, инженер, дохиолол хамгаалалт, радио релейн болон хяналтын систем, цэргийн холбоо, техник, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, тусгай хэрэгслээр бүрэн хангаж, хилийн цэргийн нисэх анги байгуулан, нисдэг тэрэг, нисэх онгоц ашиглах замаар хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн дэглэмийн гэрээг хэрэгжүүлнэ.

4.4.1.7.Хилийн боомтын сэргэлтийн бодлоготой уялдуулан авто зам, төмөр зам бүхий боомтуудад шалган нэвтрүүлэх анги байгуулж, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, ухаалаг цахим гарц, дохиолол хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, тоног төхөөрөмжөөр хангана.

4.4.1.8.Хилийн цэргийн анги, салбарын албаны барилга, орон сууцыг шинэчилж, хилчдийн алба хаах, амьдрах нөхцөлийг сайжруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

70.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.2.4 дэх дараах заалтыг хасах:

#### “4.4.2.4.Гадаад

бодлогын үзэл баримтлалыг сансар судлал, шинжлэх ухаан, технологийн салбар дахь дэлхийн чиг хандлагатай нийцүүлэн шинэчилнэ.”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

71.Төслийн 2 дугаар хавсралтад “Үр дүн” баганад “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулах” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2023” гэж, “Суурь түвшин” баганад “76.2 %” гэж, Зорилтот түвшиний “2025 он” баганад “77%” гэж, “2026 он” баганад “78%” гэж, “2027 он” баганад “79%” гэж, “2028 он” баганад “80%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “ҮСХ” гэж, “Мэдээлэл цуглуулах арга” баганад “Статистик мэдээ” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх. Энэ мэдээллийн эх сурвалж баганад ҮСХ гэж байгаа шүү. Бичгээрээ биш. Товчилсноор байна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

72.Зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн болон хавсралтын нэр томъёог жигдлэх, бүлэг, зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ажлын хэсгээс гаргасан саналыг санал хураалт явуулж дууслаа. Одоо Байнгын хороодын саналаар санал хураалт явуулна.

Ингэж байгаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.20-д төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд

ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналуудыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож эдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэж. Энэ хуулийнхаа дагуу бид нар ажлын хэсгийн саналыг эхэлж явуулна гээд ажлын хэсгийн санал явуулсан. Одоо энэ ирсэн саналуудаас ажлын хэсэгтэй санал давхардсан тохиолдолд ажлын хэсгийнхээ саналыг аваад бусад саналыг нь бол санал хураахгүй гэж энэ хуулийн заалтыг танилцуулж байна.

Тийм болохоор Аж үйлдвэржилтийн байнгын хороо дэмжсэн санал гээд саналууд дотор:

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх мега төслүүдийн хүснэгтийн 13-д тусгагдсан төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөн найруулах гээд энэ одоо ажлын хэсэг дээр санал хураачихсан тийм болохоор ажил санал хураагдахгүй юм байна. Шаардлагагүй юм байна.

2 дугаар заалт нь бас хэрэггүй болж байна. Ингээд эндээс танилцуулах юм уу. Уншаад танилцуулах уу. Тараагдсан байгаа. Аж үйлдвэржилтийн байнгын хорооны 5 дахь санал урьд өмнө хураагдаагүй санал гарч ирж байгаа юм байна. Тийм болохоор 5 дахь саналыг санал хураалт явуулъя.

#### **Аж үйлдвэржилтийн бодлогын хороо дэмжсэн санал.**

Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.2.20 дахь дэд заалт нэмж, үүнтэй холбогдуулан дугаарыг өөрчлөх:

“3.3.2.20.Даянгийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл. 17-3 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй. Үгүй ээ одоо санал хураалт явчихсан өмнө нь хэлэх байсан юм.

Зулхар гишүүний микрофоныг нээе.

**С.Зулхар:** Гишүүдэд бас дахин талархсанаа илэрхийлье. Энэ боомтын сэргэлттэй холбоотой маш чухал зорилт юм байгаа юм. Гол гол боомтуудыг бол ер нь хатуу хучилттай авто замаар холбох, цаашилаад үүгээр дамжуулсан байдлаар эдийн засгийнхаа сэргэлтийг нэмэгдүүлэх гэсэн ийм л зорилт тавьсан. Даянгийн боомт бол эдгээр боомтуудын 1 юм байгаа юм. Тэгээд Ерөнхий сайд газар дээр нь танилцаад, тэгээд энэ төслийг бол Засгийн газрын түвшинд бодлогын түвшинд дэмжээд явж байгаа ийм зорилт л доо. 2021 оны 3 сард Ерөнхий сайд Баян-Өлгий аймагт Засгийн газрын бүрэлдэхүүнтэй бүрэн очиж танилцах үедээ гаргасан саналын хүрээнд дэмжсэн санал юм. Тэгээд энийг Засгийн газар маань оруулаагүй орхичихсон байсан. Тэгээд энийг бол дэмжээд өгөөч ээ л гэж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Та тэгээд албан ёсоор дахин санал хураалт явуулъя гэсэн санал хэлсэнгүй.

**С.Зулхар:** Тийм учраас саяын санал хураалтыг би бас тайлбар хийж байгаа учраас саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгөөч гэсэн ийм хүсэлт тавьж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саяын явуулсан саналыг дахин санал хураалт явуулъя. Энэ саналыг хүчингүй болгож өгнө үү гэсэн ийм хүсэлтийн дагуу хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Гишүүний гаргасан горимын саналаар

саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 17-7 гишүүн дэмжиж, санал хураалт дэмжигдсэнгүй. Гантөмөр гишүүний микрофон.

**Л.Гантөмөр:** Энэ боомтуудыг холбох авто замыг бол хийнэ гэж байгаа юм. Тийм учраас тусгайлан боомтын нэр тавьж, авто замын төсөл бол энэ үйл ажиллагааны хөтөлбөрт ороогүй байхгүй юу. 5 тойрог гээд авто замын сүлжээг угсарна гээд ингээд багцаар нь ороод ирчихсэн байгаа байхгүй юу даа. Тэгэхээр үйл ажиллагааны хөтөлбөр лүү энэ саналаа протоколоор тэмдэглүүлээд хүргүүлчих хэрэгтэй. Төлөвлөгөө рүү оруулаад явчих хэрэгтэй. Яах вэ саяын саналууд бол ингээд бүс дамнасан төмөр замын төслүүд, боомтыг Хятадын талтай холбосон төмөр замын холбооснуудын тухай саналуудыг л би дэмжээд санал өгөөд байна л даа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны гаргасан санал.

6.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “1.3.5.Төвийн бүс – “Хөдөө аж ахуйн төрөлжсөн,аж үйлдвэрийн дэд бүс” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 1.3.5.7 дахь дэд заалт нэмэх:

“1.3.5.7.Дарханы арьс ширний үйлдвэрийг барьж дуусгах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан. 17 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны гишүүд танхимдаа ирээрэй. Хэрвээ энэ Байнгын хороодын саналыг дэмжихгүй гэж байгаа бол одоо яая гэх вэ.

Би цаашаа явлаа. Алив хэн хэн байхгүй байгааг зарлачихъя. Тэгээд тэр Байнгын хорооныхон нь өөрсдөө харна биз. Хэн дэмжихгүй байгаа, хэн дэмжиж байгаа гэдгийг хараадахъя. Туваан гишүүн байна, Учрал гишүүн байна, Гантөмөр гишүүн байна, Баярмаа

гишүүн байна, Зулхар гишүүн байна, Бат-Эрдэнэ байна. Найдалаа гишүүн байна

Байхгүй гишүүдээ дурдъя. Хэлээрэй. Ирцэд орчхоод гараад явсан гишүүдийг сайхан дурдаадахъя. Тэгээд тэр Байнгын хорооныхон өөрсдөө унасан санал дээрээ бодолцох юм байгаа биз. Хэн хэн байхгүй байна. Амарбаясгалан гишүүн алга байна. Батбаатар гишүүн алга байна. Шижир гишүүн алга байна. Баярбаатар гишүүн гарсан байна. Болормаа гишүүн алга байна. Бямбацогт гишүүн байхгүй байна. Доржханд гишүүн байхгүй байна. Мөнхбаатар гишүүн алга байна. Мөнхбаатар гишүүн чөлөөтэй. Номтойбаяр гишүүн алга байна. Одбаяр гишүүн алга байна. Оюун-Эрдэнэ гишүүн алга байна. Пүрэвдорж гишүүн алга байна. Цогтгэрэл гишүүн алга байна. Л.Энх-Амгалан гишүүн алга байна шүү.

Цаашаа явлаа. Байнгын хороод болоод оруулж ирсэн саналууд нь ингээд унаж байгаа юм байна. Та бүхэн тэр байхгүй байгаа хүмүүстээ хэлээрэй. Цаашаа явъя.

Аж үйлдвэржилтийн байнгын хорооны оруулж ирсэн саналын 7 дахь санал.

Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1. “Уул уурхай” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.1.15 дахь заалт нэмэх:

“3.3.1.15.Нүүрс-химийн технологийг эзэмших, боловсон хүчнээ бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулан хийн түли, нийлэг материал, ус төрөгч гарган авна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Найдалаа гишүүн үг хэлье гэж байна. Найдалаа гишүүний микрофоныг нээе.

**Б.Найдалаа:** Энэ ийм учиртай юм байна л даа. Монгол Улсад одоо юу ч байхгүй. Тэгсэн хэр нь асар олон мега төслийн санаа төсөл, цаас байдаг. Тэгээд энд ийм туршилтын үйлдвэр барьж байж, боловсон хүчнээ бэлдэнэ. Нөгөө нүүрс химийн технологио хөгжүүлнэ. Тэрнээс сурна, тэрнээс ингээд дараагийн төслүүд төрдөг юм байна. Тэгээд энэ бол маш чухал ажил юм байна лээ. Тэгээд ирэх жилийн төлөвлөгөөнд 4 жилийн ажилд оруулбал зөв байна. Жишээ нь Говь комбинат чинь өөрөө анх тийм контейнер маягийн жижигхэн туршилтын үйлдвэр байсан юм байна. Тэгж байж Монгол ямааны ноолуурыг ашиглаад болох юм байна, тэгэх юм байна гэж туршиж байж том төсөл рүүгээ орсон байна. Тэгэхээр энэ бол дараа дараагийн том том төслүүд явахад маш чухал ажил байгаа юм. Энийг тэгэхээр гишүүдээс дэмжээд оруулаад өгөхийг анзаараад оруулаад өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Аж үйлдвэржилтийн байнгын хорооны дэмжээгүй санал байна.

4 санал нь хураалгах шаардлагагүй юм байна. Ингээд 5 дахийг нь хураая.

#### **Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал**

5.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.3.42 дахь заалт нэмэх:

“3.3.3.42.Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга. Энэ Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье

гэснээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 17-8. Нийт 17 гишүүнээс 8 гишүүн нь дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй. Өөрөөр хэлбэл Байнгын хороо дээрээ унасан санал босоод дэмжигдэж байна гэсэн үг. Үгүй ээ, үгүй нэгэнт цаадуул чинь оруулж ирсэн шүү дээ. Оруулж ирээд бид нарын дэмжээгүй саналыг та нар санал хурааж өгөөч гэж байгаа байхгүй юу.

Алив дахиад саяынхаа нэрсийг өгөөдөх дөө. Байхгүй гишүүдийнхээ нэрсийг өгөөдөх дөө. Өнөөдөр Байнгын хорооны ирцэд бүртгэгдсэн Ө.Шижир гишүүн та хүрэлцэн ирнэ үү. Ирцэд бүртгэгдсэн Б.Баярбаатар таныг урьж байна. Ж.Баярмаа байж байна. Уучлаарай. Ирцэд бүртгэгдсэн С.Бямбацогт сайд таныг урьж байна. Ирцэд бүртгэгдээд гараад явсан Т.Доржханд гишүүн таныг урьж байна. Ирцэд бүртгэгдээд гарсан Номтойбаяр гишүүн таныг урьж байна. Ирцэд бүртгэгдээд гарсан О.Цогтгэрэл гишүүн таныг урьж байна. Одоо надад үүнээс өөр арга хэмжээ юу байх вэ. Санал хураалт. Бослоо шүү дээ. Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ. Би хэлсэн шүү дээ. Дэмжээгүй санал дэмжигдээгүй шүү дээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль. 39.22.холбогдох Байнгын хороо нь энэ хуулийн 39.3, 39.4, 39.5-д заасны дагуу бусад Байнгын хороо, нам эвслийн бүлгээс ирүүлсэн тухайн Байнгын хорооны гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн нэгдсэн хуралдаанд оруулж санал хураалгана гэж байгаа юм.

2 дугаарт зарчмын дагуу Байнгын хороо санал хураалт явуулж өгнө үү гээд дэмжсэн, дэмжээгүй саналаа наашаага албан тоотоороо, албан бичгээрээ явуулчихлаа шүү дээ. Тэгэхээр хэдүүлээ

энэ дээр нь санал хураалтаа явуулаад явахаас өөр арга байхгүй.

### Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Тогтоолын Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн зүйлийн “4.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” гэсэн хэсгийн “4.4.3.Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тогтолцоо” гэсэн заалтын 4.4.3.7 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.3.7. “ЭХ ОРНЫ ДУУДЛАГА - ЭР ЦЭРГИЙН АЛБА”-ны хүрээнд батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, цэргийн албаны төрлийг нэмэгдүүлэх замаар Зэвсэгт хүчин, алба хаагчийн олон нийтийн дэмжлэг, нэр хүндийг дээшлүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин. Санал хураалт. 17- 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 3 дахь заалтын “уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв,” гэсний дараа “шинжлэх ухаан,” гэж “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний” гэсний өмнө “Технологи,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн зүйлийн “4.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” гэсэн хэсгийн “4.4.1.Үндэсний эв нэгдэл” гэсэн заалтын 4.4.1.3 дахь дэд заалтын “ёс суртахууны доголдол,” гэснийг хасах, 4.4.1.4 дэх дэд заалтын “ёс зүйтэй” гэснийг “хариуцлагатай” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн

Х.Тэмүүжин. Санал хураалт. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

**Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:**

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.4.2 дахь дэд заалт нэмэх:

“3.3.4.2. Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохтой холбогдуулан зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлж хоршооны гишүүн малчинд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай. Санал хураалт. Одоо түрүүн унагачихсан шүү дээ. 17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.4.3 дахь дэд заалт нэмэх:

“3.3.4.3.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулна.” Зарчмаар татчихсан явж байна уу. Яах юм тэгээд та хэд чинь энийг чинь ерөөсөө л дэмжихгүй юу даа. Үгүй ээ, нээрээ тэр чинь ажлын хэсгийн санал байхгүй юу. Аргагүй, аргагүй яг энэ чинь зарчмын хувьд бол саналаа хураагаад л явъя. Яагаад гэхээр Байнгын хорооноос орж ирсэн санал шүү. Санал хураалт. Хэд вэ. 17-6. Санал дэмжигдсэнгүй.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.3.7 дахь дэд заалтын “үйл ажиллагааг дэмжин” гэсний дараа “Үндэсний ногоон барилгын үнэлгээний систем нэвтрүүлж,” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа. Санал хураалт. Дараа нь явчихъя. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.1.1. дэх заалтын “Байгалийн төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөн, хамгаалалтын менежментийг сайжруулна.” гэснийг “Байгалийн төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулна.” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга. Санал хураалт.

Энэ дээр нэг ийм юм байгаа юм биш үү. Нэг санал байсан юм байна. Яамнаас ирсэн санал нэг тайлбар байх ёстой юм байна. Тийм болохоор энэ санал хураалтыг хүчингүйд тооцоодохъё. Энэ яамнаас тайлбар хэлээдэх дээ. Ажлын хэсгийн 3 номер.

**Э.Баттулга:** Ийм байгаа юм дарга аа. Энэ нөгөө Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, тэгээд Монгол Улсын нэгдэн орсон Биологийн олон янз байдлын конвенцод тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2030 онд 30 хувьд хүргэнэ гэсэн ийм зорилт тавигдсан байгаа. Тэгээд Алсын хараа урт хугацааны хөгжлийн бодлогын маань шалгуур үзүүлэлтэд орсон асуудал. Энийг хэвээр нь үлдээж өгөөч гэж Байнгын хороодынхоо гишүүдээс хүсэх гэсэн юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалтыг дахин явуулъя. Хүчингүй болгож санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. Бямбацогт сайд орж ирсэн. Өөр хэн

байгаа билээ. Санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. 17-5 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

5.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 3.4.2.9 дэх заалт нэмэх:

**“3.4.2.9.Агаарын**

бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж эрчим хүч, усны ухаалаг хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 3.3.4.29 дэх заалт нэмэх:

**“3.3.4.29.Малчдад эрчим**

хүчний хэмнэлттэй өвлийн жишиг сууцны загвар түгээж, мэдлэг олгоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа. Санал хураалт. 17-8 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

7.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.5 дахь заалтын “Төвийн бүс-Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” гэснийг “Төвийн бүс-Эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэржилт, эрчим хүчний дэд бүс.” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал. Санал хураалт. 17-5 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

8.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4 дэх заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, залуу малчид, тариаланчдыг бэлтгэх зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.”Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал. Санал хураалт. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4 дэх заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“Сорт, сорилын төв, үрийн аж ахуйг дэмжиж, үрийн шинэчлэл хамгаалалтыг сайжруулан, гол нэр төрлийн тариалангийн үр үйлдвэрлэлд урамшуулал олгоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал. Санал хураалт. 17-11 гишүүн. Санал дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4 дэх заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мян.тн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ гурилтай холбоотой асуудлын үед яригдсан асуудал шүү дээ. 100 мянган тонн. Тогтоолтой юм байгаа шүү дээ.

Ёс зүй, дэгийн байнгын хорооноос ирүүлсэн саналаар санал хураалт явуулъя.

**Ёс зүй, дэгийн байнгын хороо**  
**дэмжсэн санал:**

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” хэсэгт доор дурдсан агуулгатай 4.2.3.12 гэсэн дэд хэсэг нэмэх:

“4.2.3.12 “Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.



2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” хэсэгт доор дурдсан агуулгатай 4.2.3.13 гэсэн дэд хэсэг нэмэх:

“4.2.3.13 “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” /2024-2030 он/ дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууны үнэт зүйл бүхий сэтгэл зүйг төлөвшүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Санал хураалт 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” хэсэгт доор дурдсан агуулгатай 4.2.3.14 гэсэн дэд хэсэг нэмэх:

“4.2.3.14 “Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршилагад суурилан хэрэгжүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Санал хураалт. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтад 13 “Үр дүн” баганад “Ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн хороо, дэд хороодын чадавхийн үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшиний “2025 он” баганад “20” гэж, “2026 он” баганад “30” гэж, “2027 он” баганад “40” гэж, “2028 он” баганад “50” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхийн судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж, 14 “Үр дүн” баганад “Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлнэ.” гэж,

“Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн зөрчлийн бууралт, нийгмийн нөлөөллийн үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “Батлагдсан хөтөлбөр” гэж, Зорилтот түвшиний “2025 он” баганад “30” гэж, “2026 он” баганад “50” гэж, “2027 он” баганад “75” гэж, “2028 он” баганад “85” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Олон эх үүсвэр” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил бүр” гэж, 15 “Үр дүн” баганад “Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршилагад суурилан хэрэгжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн үзүүлэлт” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшиний “2025 он” баганад “10” гэж, “2026 он” баганад “15” гэж, “2027 он” баганад “25” гэж, “2028 он” баганад “35” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Төрийн албаны олон улсын индекс (InCiSE)-ийн ёс зүйн (INT) үзүүлэлт” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Үндэсний үзүүлэлтийн судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Санал хураалт 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооноос оруулж ирсэн саналаар санал хураалт явуулъя.

### **Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:**

1.Тогтоолын төслийн 2.1.1.21 дэх хэсгийн “стандартыг” гэсний дараа “албан байгууллага, ”гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан. Санал хураалт. 17

гишүүнээс 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төсөлд дор дурдсан агуулгатай 2.3.2.8 дахь дэд заалт нэмэх:

“2.3.2.8 сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар, цогц байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төсөлд 2.1.2.10 “хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулна.” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 2.2.3.2-н “Багшлах эрх олгох хялбаршуулсан сургалтын тогтолцоог бий болгож” гэснийг “Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн” гэж өөрчлөн, “бэлтгэх замаар” гэсний дараа “багшлах хүний нөөцийн чадавхийг сайжруулж” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. 17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 2.1.2.10 дахь хэсэгт “Суралцангаа хөдөлмөрлөх /хөдөлмөрлөнгөө суралцах хосмог ажлын байрыг нэвтрүүлэхтэй уялдуулан дадлагажигчийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 2.1.1.30 дахь заалтын “төрийн бүх шатны байгууллагууд залуу мэргэжилтнүүдийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Санал хураалт. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 2.1.1.31 дахь заалтын “залуу гэр бүлд зориулсан урьдчилгаа төлбөр, хүүгийн таатай нөхцөл бүхий орон сууцны тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төсөлд “4.1.3.4 иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог баталгаажуулан бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцооны тодорхой шалгуур үзүүлэлт бүхий нийтлэг журмыг батлах. Төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшинг жил бүр үйлчилгээг хүртэгч төрийн бус байгууллага, иргэдээр үнэлүүлж индексжүүлэх.” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Санал хураалт. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

9.Тогтоолын төсөлд “4.1.3.5 иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурынхны нийгэм-эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үндэсний тооцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх.” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Санал хураалт. Ямар учиртай юм бол доо. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

**Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:**

Одоо тэгээд анхаарлаа хандуулаарай хүмүүс ээ.

1.Тогтоолын төслийн 2.1.1.19 дэх заалтын "инфляц" гэснийг "өмнөх оны инфляцийн жилийн дундаж болон" гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан. Санал хураалт. 17-11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2.1.2.6-н "Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж" гэсний дараа "жил бүр" гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Эрдэнэбат гишүүн тайлбар хийе.

**С.Эрдэнэбат:** Өчигдөр энийг Төрийн байгуулалт болон Төсвийн байнгын хороо дээр ярьж гэдэг байдлаар унагаачихсан юм. Яах вэ, ер нь бол жил болгон цалин хөлсний асуудлыг жил болгон цалин хөлсийг нэмэгдүүлдэг, нэмэгдүүлэх талаар хөтөлбөрт нь тодорхой болгож өгье гэдэг байдлаар би бол оруулсан юм. Тийм учраас тэрийг Байнгын хорооны төсөвтэй шууд холбоотой асуудал учраас Төрийн байгуулалт болон холбоотой тэр байнгын хороо дээр хураалгая гэдэг байдлаар унагаачихсан юм. Тэгэхээр та бүгд маань одоо бол унагаачихсаныг дэмжихгүй байвал дэмжинэ гэсэн үг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тийм санал хураалт. Одоо яах вэ дээ. 17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төсөлд "4.1.3.4 тендэр үнэлгээнд төсөл хөрөнгө оруулалт шууд дам нөлөөлөл, хүртээмж нэмэх, нийгмийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бий болгоно" гэж нэмэх. Дахиад тайлбар юм уу. Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Энэ дээр ингэсэн юм. Ер нь бид нар төсвийн болон энэ бодлогуудынхаа асуудалд хэр зэрэг хүртээмжтэй байх вэ гээд олон улсын байгууллагууд ч гэсэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт гэдэг нэр томъёог бол нэлээн ярьдаг. Энэ чиглэлээр гишүүн орнууддаа үүрэг даалгавар, чиглэл өгч

байгаа юм. Ядуурлын бууруулъя, нэг хүнд ноогдох дотоодын бүтээгдэхүүнийг өсгөе гэхчсэн яг тодорхой тоон заалтууд байгаа. Энэ дээрээ бол томоохон төсөл хөтөлбөрүүд дээр зөвхөн хамгийн бага үнийн арга ч гэдэг юм уу, эсвэл энэ томоохон төсөвтэй хамааралтай тендер мөн концесс гэх мэтчилэн эдгээр төслүүдийг хэчнээн аж ахуйн нэгж, байгууллагуудад хэчнээн ажлын байр бий болгох юм, хэчнээн тогтвортой сайн ажлын байр бий болгох юм гэх мэтчилэн ийм үзүүлэлтүүдийг олон улсын байгууллагууд бол давхар үздэг болсон байна лээ. Тийм учраас энэ чиглэл рүү нь хууль, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгоё гэдэг ийм байдлаар оруулж байгаа юм. Тийм учраас энэ саналыг бол яг өчигдөр бол бас Байнгын хороон дээр Төрийн байгуулалт болон Төсвийн байнгын хороо дээр энийгээ оруул. Манай Байнгын хороо дээр хамаарна, хамаарахгүй гэж байгаад тэгээд энэ асуудлыг дэмжээгүйгээр уначихсан юм. Тийм учраас энэ асуудал дээр бол та бүгд маань бас анхаарлаа хандуулж өгөөрэй. Энэ олон төсөл хөтөлбөр энэ тал дээр та бүгд маань дэмжиж өгөхийг хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Өгүүлбэр чинь болохгүй байна шүү дээ. Санал хураалт. Өгүүлбэр чинь ерөөсөө болохгүй байна. Наадах чинь ерөөсөө хүнд тусахгүй байна шүү дээ. 17-6 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

4.Тогтоолын төслийн 2.3.4.3 дахь заалтын "эрүүл мэндийн ажилтны" гэсний дараа "цалин хөлс," гэж нэмэх, "алслагдсан" гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Саранчулуун. Санал хураалт. 17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 2.1.1.23 дахь заалтын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулах" гэж нэмэх, "хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг

төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Санал хураалт. 17 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

6.Тогтоолын төслийн 2.1.2.2-д “Хөдөлмөрийн зах зээлд эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан цалин хөлсний тогтолцоог бий болгоно.” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн хавсралт 1-н Хүний хөгжлийн бодлогын 2.1.1.2-дахь заалтын “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймагт дүүрэгт төр хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулна” гэснийг “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймагт дүүрэгт төр хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийг ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн нөхцөлийг бүрдүүлнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан. Санал хураалт. 17-8 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Төсвийн байнгын хорооны саналаар санал хураалт явуулъя.

**Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:**

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 1.3.3.6 дахь дэд хэсэг нэмэх:

“1.3.3.6.Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт авто зам барина.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

**Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:**

1.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад “олон улсын ур чадварын үзүүлэлт” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

**Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй санал:**

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг хүүхэд хамгаалах сан, хүүхдийн эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн зарцуулах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 4.2.1.8 дахь дэд хэсэг нэмэх:

“4.2.1.8.авлигатай тэмцэх газрын салбарыг 21 аймагт байгуулах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ. Санал хураалт. 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны ирүүлсэн саналаар санал хураалт явуулъя.

**Эдийн засгийн байнгын хороо нь**  
**дэмжсэн санал:**

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.2.2 дахь заалтын “Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин” гэсэн хэсэгт доор дурдсан агуулгатай дэд заалт шинээр нэмэх:

“1.Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний гадаад экспортыг нэг цонхны бодлогоор дэмжинэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт 17-12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1 дэх заалтын “Уул уурхай” гэсэн хэсэгт доор дурдсан агуулгатай дэд заалт тус тус шинээр нэмэх:

“1.Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон, ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад оруулахад бэлэн болгоно.

2.Эрдэнэтийн стратегийн ордын талбайн эрэл хайгуулын ажлын хүрээнд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан дахин шинэ стратегийн орд нээж, ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг эхлүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж. Санал хураалт. 17-2 хүн дэмжиж, санал дэмж дэмжигдсэнгүй.

3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3 дахь заалтын “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн хэсэгт доор дурдсан агуулгатай дэд заалт шинээр нэмэх:

“1.Эрчим хүчний салбарт реформ хийж, салбарын эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчилнэ.” Санал

гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал хураалт. 17-6 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3 дахь заалтын 3.3.3.37 дахь дэд заалтаас “Сонгино-Дархан” гэснийг хасаж доор дурдсан агуулгатай 3.3.3.42 дахь заалт нэмэх:

“3.3.3.42.Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал хураалт. 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Гишүүдийн өгсөн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор яг ингээж орж ирж болно. Нээлттэй.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаарх гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулья.

3.2.1 зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Хөдөө орон нутгаас хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлэх” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт. Тайлбар хэлье. Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Энэ бүсийн ялгаатай татварын тогтолцоо бас бий болчих юм бол Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрөл, хэт их ачаалал бас буурчих болов уу гэсэн ийм асуудлыг бас бид нар ярьдаг юм. Аж ахуйн нэгжийн албан татварыг бид нар бас бүсчлээд ялгаатай тогтоочихсон. Улаанбаатарт

10 хувь, Улаанбаатараас 500-1000 км алслагдсан бол 5 хувь, 1000-аас дээш алслагдсан аймгууд 1 хувь гээд тогтоочихсон байгаа юм. Үүгээр үндсэндээ бас алслагдсан аймгуудад, хөдөө орон нутагт бас үйлдвэрүүд бас баригдах, аж ахуйн нэгжүүд бас шилжих ийм хөдөлгөөн бий болж байгаа. Яг үүнтэй адилхан хүн амын орлогын албан татвар өнөөдөр 10 хувийн татвартай байж байгаа. Баян-Өлгийд амьдарч байгаа ч адилхан, Дорнодод амьдарч байгаа ч адилхан, Өвөрхангай, Хөвсгөл ч адилхан, Улаанбаатарт ажиллаж байгаа яг адилхан 10 байгаа. Тийм болохоор энэ татварыг бас жоохон ялгаатай болгоод өгчихвөл хүн амын орлогын албан татварыг. Энэ маань бас хөдөө, орон нутаг руу шилжих, Улаанбаатар луу бас шилжиж төвлөрөхгүй байх ийм бас бололцоонууд бас бий болох хөшүүрэг болох байх. Бид нар ипотекийн зээлийн хүүг Улаанбаатарт 6 хувь, хөдөө орон нутагт 3 хувь болгочихсон байгаа. Ийм байдлаар дэмжиж байгаа. Мөн бас төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийг сумын төвд 40 хувь, сумд, аймгийн төвд 20 хувийн нэмэгдэл олгодог болчихсон байж байгаа. Тэгээд иймэрхүү байдлаар бас зөвхөн юу гэдэг юм Улаанбаатараас ингээд л албадлагаар захиргаадалтаар шахах биш, нөгөө талд нь хөдөө орон нутаг руу шилжих ийм хөшүүрэг, урамшууллыг бий болгох, цаашлаад хөдөө орон нутагт ажиллаж амьдрах юм бол илүү бас ажилтай орлоготой амьдрах таатай бололцоог бий болгох ийм боломжуудыг л дахин дахин бий болгоод бай гэж байгаа юм. Энэ агуулгаар зүгээр ийм тогтолцоог бүрдүүлэх санааг оруулчихъя. Энийг тэгээд бас Засгийн газар явц дундаа хийгээд хэрэгжүүлнэ биз дээ гэдэг үндэслэлээр л энэ саналыг гаргаж байгаа юм. Тэгээд гишүүдийг бас анхааралдаа аваад бас дэмжээд өгөхийг хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Төрийн албаны реформ 4.2.3.1 үг ойлголц ойлголтыг хасах болон нэмэх замаар өөрчлөх:

“чадахуйн зарчимд суурилсан оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлж, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэн, төрийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгож, төрийн захиргааны албан хаагчдын тоог зохистой хэмжээнд хүргэнэ.” Зулхар гишүүнээс гаргасан санал байна. Санал хураалт. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

**Б.Хэрлэн:** 4.2.3.1 саяын одоо Зулхар гишүүний дэвшүүлж байгаа саналтай ерөнхийдөө зарчмын хувьд эмжиж байна. Гэхдээ надад энд бас нөгөө найруулгын хувьд арай жаахан өөрөөр найруулж хэлсэн энэ санаагаа би хэлчих үү. Чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлэх төрийн албаны бүтээмж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг...

**Ж.Бат-Эрдэнэ:** Үгүй ээ, үгүй. Одоо зүгээр санал хэлнэ шүү дээ.

**Б.Хэрлэн:** Зарчмын хувьд бол саналыг дэмжиж байна. Дэмжиж байна. 4.2.3.1 дээр би санал хэлчих үү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Одоо санал хэлэхгүй. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Төрийн албаны реформ 4.2.3.6. үг хасах:

“төрийн албан хаагчийг улс төрчийн болон удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалтаас ангид байлгах, эрх ашгаа хамтран хамгаалах боломж бүрдүүлж, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.” Энэ ямар заалтыг ийм болгож байгаа юм. Зулхар гишүүн.

**С.Зулхар:** Байнгын хорооны гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Энэ заалт дээр зүгээр эвлэлдэнэ гэдэг гэсэн үгийг л хасъя гэсэн юм. Эвлэлдэн нэгдэх бол энэ чинь нөгөө үйлдвэрчний эвлэл байгуулна гэсэн үг байхгүй юу. Төрийн үйлчилгээний албан хаагч дээр бол үйлдвэрчний эвлэл байгуулаад явж байгаа юм. Төрийн захиргаа болон төрийн тусгай албан хаагч нар бол тусгайлсан хуулиар зохицуулагддаг. Энэ бол хязгаарлалттай байдаг байхгүй юу. Тэгэхээр энийг ингэж оруулж болохгүй гээд л энэ үгийг хасъя гэж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ямар үгийг хасаж байгаа юм.

**С.Зулхар:** Эвлэлдэн нэгдэх гэдэг “эвлэлдэн нэгдэх” гэдэг үгийг хасаж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгвэл “эвлэлдэн нэгдэх” гэдэг үгийг л хасаж байгаа юм байна шүү дээ. Үгүй ээ, үгүй. Найруулгаар орж ирж байгаа юм уу, эсвэл үг хасахаар орж ирж байгаа юм уу.

**С.Зулхар:** Тэр “эвлэлдэн нэгдэх” гэдэг үгээ хасчхаж байгаа юм. Тэгэнгүүтээ найруулга нь ингэж орж ирж байгаа байхгүй юу.

**Ж.Бат-Эрдэнэ:** Та үг хасаж, тийм үгийг хасах гэж оруулж ирж байгаа юм уу. Санал чинь эсвэл өөрчлөн найруулах гэж орж ирж байгаа юм уу.

**С.Зулхар:** Үгийг нь хасаад, өөрчлөн найруулчхаж байгаа юм. Би тайлбар тэгж хийж байгаа шүү дээ. Өөрчлөн найруулж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Өөрчлөн найруулах гэдгээр авъя. Байж бай л даа. Микрофонгүй битгий яриад бай л даа хүмүүс ээ. Найруулга гэдгээр чинь авлаа шүү дээ. 4.2.3.6-г өөрчлөн найруулах:

Төрийн албан хаагчийн улс төрчийн болон удирдлагын хууль бус шийдвэр аливаа дарамт шахалтаас ангид байлгах, эрх ашгаа хамтран хамгаалах боломж бүрдүүлж, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.” Төрийн албан хаагч чинь одоо энэ хуулийн дагуу л ажиллах ёстой шүү дээ. Энэ юун эрх ашгаа хамтран нэгдэх. Санал хураалт. Санал хураалт хэд вэ. 17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Төрийн албаны реформ 4.2.3.8 үг хасах болон нэмэх замаар өөрчлөх л гэж байна. Тэгээд аль нь болчхоод байгаа юм энэ чинь. Баахан л тайлбартай юутай байсан. Өөрчлөн найруулах юм уу. Үг хасах, өөрчлөн найруулах гэж байна.

Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг төрийн албаны шинэчлэлд нийцүүлж, сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.” Санал хураалт. 17-5 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

4.2.4.Орон нутгийн засаглалын бие даасан байдал шинээр нэмж заалт оруулах гэж байна. энэ чинь харин ойлгомжтой юм орж ирлээ.

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийг боловсронгуй болгох замаар боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүн амын тоотой уялдуулан хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.” Та нар энэ юмнуудыг нь аятайхан шиг оруулаад ир л дээ. Үг хасах энэ тэр гэж байгаа бол үг хасахаар нь оруулаад, найруулга, өөрчлөн найруулах гэж байгаа бол өөрчлөн найруулахаар нь оруулж ир.

Дахиад униъя. “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийг боловсронгуй болгох замаар боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүн амын тоотой уялдуулан хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулхар. Санал

хураалт. 17-6 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

4.2.3.9 нэмж өөрчлөх, үг хасах, өөрчлөн найруулах:

“Төрийн албан хаагчдын цалин хөлс нийгмийн баталгааны зохистой бодлого баримтлан орон сууцын хүртээмжийг нэмэгдүүлнэ. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэдэд хөдөлмөрлөх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэх, орлого олох, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.” Санал хураалт 17-4 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

2.2.4.5 заалт нэмэх. Сургалтын байгууллагын интернэтийн дэд бүтцийг сайжруулах, хүүхэд бүрийг компьютержуулахад санхүүгийн түрээс гэх мэт арга хэрэгслийг нэвтрүүлэх” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулпхар. Санал хураалт 17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

Цахимжсан боловсрол.2.2.4.1-ийг нэмж өөрчлөх гэж байна. Энэ өөрчлөн найруулах л юм байна л даа.

“Боловсролын бодлого, санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хүн ам, орон зайн их өгөгдөлд тулгуурласан хиймэл оюун ухаан ашиглах замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, үр ашгийг сайжруулах.” санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт 17 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

2.2.1-д шинээр нэмж оруулах шинэ заалт нэмэх:

“Үндэсний цөөнхийн бага, дунд боловсрол эзэмших эрхийг хангах, “Хос хэл”-ний бодлого, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. 17-8 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

4.2.3.10 Өөрчлөн найруулах:

“Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, мэдээллийн ил тод, үнэн зөв, бүрэн бүтэн байдалд хяналт тавих нөхцөлийг хангасан төрийн албаны хүний нөөцийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлэн, өгөгдөлд суурилсан хүний нөөцийн удирдлагын бодлогыг оновчтой, шинжлэх ухаанч байдлаар зөв төлөвлөж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг. Номинчимэг гишүүн тайлбар юм уу. Номинчимэг гишүүний микрофоныг нээе.

**О.Номинчимэг:** Манай нөгөө Төрийн албаны зөвлөл дээр дата мэдээллүүд цугладаг. Төрийн албаны шинэчлэлийг бас хийх гэж байна. Тэгээд энэ төрийн албаны шинэчлэлийг хийхийн тулд зөв дата мэдээлэл маань бүрдсэн байх ёстой. Тэгэхээр энэ дата дээрээ суурилсан шийдвэр гаргалтыг Evidence-based policymaking гэдэг. Энийг бас нэвтрүүлээд төрийн үйл ажиллагааг ч гэсэн оновчлох шаардлагатай гэж үзэж байгаа юм. Ингэснээрээ бид бол илүү нөгөө чиглэл чиглэлийн мэргэшсэн бас боловсон хүчнүүдээ төрийн албыгаа чадавхжуулах боломж нь нээгдэнэ гэсэн утгаар одоо гарсан байгаа энэ 2 давхар санал гарчихсан юу байна лээ. Үйл ажиллагааны хөтөлбөр дээр. Төрийн албан хаагчид өөрсдөд нь датаг нь өгнө гээд. Энийг өөрчлөн найруулах замаар ингэж өөрчилье гэсэн санал гаргаж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалт. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг. Санал хураалт 17-8 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

4.2.3.11.Өөрчлөн найруулах:

“Төрийн албанд сэтгэлгээний болон дүн шинжилгээ хийх, асуудлыг оновчтой, шуурхай шийдвэрлэх өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах аргыг нэвтрүүлж, эрх зүйн орчныг шинэчилнэ.”



Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг. Саналаа тайлбарлая. Номинчимэг гишүүний микрофон.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.10, 4.2.3.11 2 яг адилхан үг үсэгтэй өгүүлбэрүүд орж ирсэн байгаа юм. Төрийн албан хаагчдын цахим мэдээллийг өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, мэдээллийн үнэн зөв бүрэн гүйцэт байдлыг сайжруулна. 2 давхардсан. Тэгэхээр 1 дүгээрт энэ 11-ийг бол илүү өөрчилье гэсэн санал байгаа. Энэ саналын гол эссенз нь бол бид нар төрийн албаны шалгалт гээд нэг ийм зузаан номд ийм тест боловсруулчихсан байдаг. Тэгээд ерөөсөө тэр тестээ цээжилсэн хүн бол тэр тестийг хугацаанд нь бөглөөд л тэнцчихдэг. Энэ тест бол ерөөсөө өөрөө хүний тэр сэтгэн бодох, анализ хийх юу гэдэг юм тэр хандлага юу байдаг юм ур чадварыг үнэлэхдээ үнэлж чаддаггүй ийм тест. Ерөөсөө цээжлээд ордог тест. Тэгэхээр бид нар төрийн албаа чадавхжуулъя гэж байвал орох хаалгаа маш чанга болгох ёстой. Чадвартай хүмүүсээ авъя. Орчихсон хойноо энэ бол өөрөө тогтвортой ажиллах боломжийг нь бүрдүүлье. Дээр нь цалин хангамж байдаг юм уу энийг нь сайжруулъя гэдэг энэ схемээр явахын тулд ерөөсөө энэ ордог хаалгаа бид нар илүү ур чадвартай хүнээ сонгон шалгаруулж авдаг ийм зохион байгуулалт руу орох эрх зүйн орчныг нь сайжруул гэсэн ийм агуулгатай санал байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Та хэд энэ өгүүлбэрээ нэг жоохон аятайхан болгооч. Эндээс чинь ерөөсөө юу ч харагдахгүй байна шүү дээ. Санал хураалт. Дахиад уншаадахъя. Алив уучлаарай. Дахиад уншаадахъя. Энэ чинь гараар биччихсэн байгаа болохоор би бас юу яачихсан байж магадгүй.

“Төрийн албанд сэтгэлгээний болон дүн шинжилгээ хийх, асуудлыг оновчтой, шуурхай шийдвэрлэх өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах аргыг нэвтрүүлж, эрх зүйн орчныг шинэчилнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг. 17 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй. Томьёоллуудаа зөв хийцгээе хэдүүлээ. Ярихдаа бол сайхан ярьчих юм. Тэгээд энэ томьёолол чинь байхгүй болохоор яг энэ чигээрээ орчих юм бол болохоо байчихна шүү дээ. Наадах чинь.

4.2.1.13. Өөрчлөн найруулах юм байна. “Нууц мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчныг хүний эрхийг дээдлэх зарчимд тулгуурлан тодорхой болгоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг. Санал гаргасан гишүүн л тайлбарлана. Түүрүүн нэг орсон шүү дээ ер нь. Тайлбараа хий дээ Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Энэ яах вэ, ажлын хэсэг дээр хөндөгдөөгүй заалт бас хөндөгдөх болов уу гээд хүлээж байсан учраас Байнгын хороон дээр гаргаагүй байсан. Одоо хувь гишүүний хувиар гаргаж байгаа юм. Тэгээд нөгөө нууц мөрдөн шалгах үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчныг ер нь бол тодорхой болгох цаг болсон гэдэг дээр бол санал нэгдэж байгаа. Гэхдээ энэ дээр Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр дээр бүүр ямар арга замаар вэ гэдгийг маш тодорхой ингээд заагаад өгчихсөн нь хэр оновчтой вэ гэдэг л асуулт байгаа юм. Мэдээж энийг бид нар хууль, эрх зүйн хувьд оновчтой, ойлгомжтой болгоод цэгцлэх ёстой. Энэ замбараагүй байгаа байдлыг бид нар хууль, эрх зүйн хүрээнд яаж зөв болох вэ гэдгийг харах ёстой. Тэрийг салбарын яам өөрөө судлаад үнэхээр тэр шүүхэд хандахаар юм уу, иргэнд нь энэ мэдээллийг өгөхөөр ямар үр нөлөөлөл гарах юм. Дараа нь ямар сөрөг үл үр нөлөөлөл гарах юм гэдэг нь яам өөрөө Монгол Улсдаа хийсэн судалгаа, үүнтэйгээ харьцуулсан судалгаануудыг

гаргаж ирээд энийг бол бодлогын хүрээнд бид нар бол илүү зөвшилцөж байж, ярилцаж байж энэ арга замыг нь шийдвэрлэх ёстой гэсэн саналтай байгаа. Мөрийн хөтөлбөр дээр бол бүр нарийвчилчихсан ерөөсөө л ингэж шийднэ гээд орчихсон байгаа. Энийг нь би бол үнэхээр бодлогын яамны бас байр суурь юм уу, үгүй юм уу гэдгийг бас мэдэхгүй байна. Тэгэхээр энийг бол илүү ерөнхийлсөн байдлаар хүний эрхийг мэдээж дээдлэх зарчмыг хангаад, энэ нууц мөрдөх үйл ажиллагаагаа илүү тодорхой эрх зүйн орчныг нь тодорхой болгоё гэдэг ерөнхий томъёоллоор сольё, өөрчилъе гэсэн ийм санал байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Номинчимэг гишүүн ээ. Энэ нууц мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчныг тодорхой болгоно гэдэг чинь яах вэ, энэ доор нь тодорхойлсон юман дээр нь хүний эрхийг дээдэлсэн гэж. Энэ 2.4.2.1.15 дээр тагнуулын үйл ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагааны зааг ялгааг тодорхой болгож эрх зүйн орчныг тус тусын хуулиар зохицуулна. Тэгэхээр энэ чинь ерөнхийдөө агуулга нь байгаа юм биш үү.

**О.Номинчимэг:** Тэгэхээр 4 2.1.13 дээр дахиад энэ чинь нууц мөрдөн шалгах үйл ажиллагааны юуг яана гэсэн энэ яг арга замыг нь тодорхойлсон заалт нь байгаа. Энэ бол ажлын хэсэг дээр хөндөгдөөгүй заалт байгаа байхгүй юу. Тэгээд тэр дээр ерөөсөө ерөнхийлөөд байгаа гэвэл нэг бол энийгээ хасах ийм санал гаргаж байна. Эсвэл өөрчлөн найруулах. Илүү тодорхой болгоё гэвэл.

**Ж.Бат-Эрдэнэ:** Давхцал үүсээд байна шүү дээ. Санал хураалт 17-3 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар, Даваасүрэн, Энх-Амгалан, Бат-Эрдэнэ, Батлут, Үүрийнтуяа нараас гаргасан санал байна.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3. “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.43 дахь заалт нэмэх:

“3.3.3.43.Мөрөн хотод 50 мВт-аас доошгүй хүчин чадалтай дулааны цахилгаан станц байгуулах бэлтгэл ажлыг хангана.” Санал хураалт. 17-2 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3. “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.44 дэх заалт нэмэх:

“3.3.3.44.Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.” Тэнд ер нь бол цахилгаан хангамж дутуу байгаа шүү. Эрдэнэтэд. Санал гаргасан Мөнхбаатар, Даваасүрэн, Энх-Амгалан, Батлут, Б.Бат-Эрдэнэ, Үүрийнтуяа. Санал хураалт. 17-3 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2 “Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.27 дахь заалт нэмэх:

“3.3.2.27.Хутаг-Өндөр сумаас Бага илэнхийн хилийн боомт хүртэл 146 км хатуу хучилттай авто замыг барина.” Санал хураалт. 17-3 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2 “Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.28 дахь заалтыг нэмэх:

“3.3.2.28 Эрдэнэт хотын доторх авто замын барилга угсралт, шинэчлэл, өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгэнэ.” Санал хураалт. 17 гишүүнээс 3 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын  
3.3.2 “Боомтын шинэчлэл, тээвэр  
логистик” зорилтод доор дурдсан  
агуулгатай 3.3.2.29 дэх заалт нэмэх:

“3.3.2.29.Мөрөн-Их-Уул-  
Рашаант-Өлзийт-Хайрхан-Тэрхийн  
цагаан нуур босоо чиглэлийн хатуу  
хучилттай авто замыг барьж дуусгана.”  
энэ бол нөгөө аялал жуулчлалтай  
холбоотой 5 заалт орж ирж байгаа байх  
шүү. Санал хураалт. 17-4 гишүүн  
дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

“1.1.3.2 өөрчлөн найруулах:

“Цэвэрлэх байгууламжийн тархмал  
дэд төвүүдийг шинээр байгуулах, бие  
даасан, бага оврын ариун цэврийн  
байгууламжийн хэрэглээг бодлогоор  
дэмжих замаар нүхэн жорлонгийн тоог  
2 дахин бууруулж, хөрсний бохирдлыг  
бууруулна.” Санал гаргасан Улсын Их  
Хурлын гишүүн Батбаярын Жаргалан.  
Санал хураалт 17 гишүүнээс 3 гишүүн  
дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

4.2.3.1.Өөрчлөн найруулах:

“Чадварлаг, цомхон чадахуйн  
зарчимд суурилсан, төрийн албыг  
бэхжүүлэх, төрийн албан хаагчийн  
ажлын бүтээмж, зорилгоор төрийн  
албаны бүтэц, зохион байгуулалт,  
төрийн байгууллагын чиг үүрэг,  
үйлчилгээний төрлийг оновчилж, эрх зүйн  
орчныг боловсронгуй болгох замаар  
төрийн албан хаагчийн ажлын  
гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг  
сайжруулан, төрийн захиргааны албан  
хаагчдын тоог зохистой хэмжээнд  
хүргэнэ.” Санал гаргасан Улсын Их  
Хурлын гишүүн Батбаярын Жаргалан.

Тэгвэл наадах чинь Дэгийн тухай  
хуулиар санал хураалт явуулахгүй юм  
байна.

4.2.3.5 Өөрчлөх:

“Төрийн албаны ёс зүйн зарчмуудад  
үндэслэсэн суурь шалгуур үзүүлэлтийг  
боловсруулж, төрийн албаны чадамжид  
суурилсан хүний нөөцийн бодлогын  
хэрэгжилтийг үнэлж дүгнэнэ.” Санал  
гаргасан Улсын Их Хурлын гишүүн  
Б.Хэрлэн. Санал хураалт. 17-2 гишүүн  
дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

2.1.1 Нэмэх.

“Хичээлээс гадуур үйл ажиллагаа  
буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан,  
сургалтын төвүүд, түүний багш нарт  
санхүүжилтийн болон байр, тоног  
төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.” Санал  
гаргасан Улсын Их Хурлын гишүүн  
М.Бадамсүрэн. Санал хураалт.  
Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.  
Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг  
нээчих.

**М.Бадамсүрэн:** Гол нь та бүхэн  
ойлгоорой. Нөгөө хөгжсөн хүүхэд  
хамгаалагдана гэдэг. Тэгээд манай энэ  
мөрийн хөтөлбөр дээр ерөөсөө хүүхэд  
хөгжлийн талаар 1 ч заалт байхгүй.  
Дандаа хамгаалал гээд 4, 5 заалт байгаа.  
Тийм учраас хүүхдүүд цахимаас хараат  
бус байх, донтолтоос сэргийлэх, тэгээд  
бие бялдрын хувьд ч гэсэн зөв байхын  
тулд энэ ковидын дараа бүх улс орнууд  
хүүхдийг хөгжүүлэх нэмэлт ийм секц  
дугуйланг маш их дэмжиж байгаа.  
Тэгээд энэ утгаараа яах вэ, манай  
аймагт бол туршигдсан олон төслүүд  
байгаа л даа. Тэр утгаараа энэ нь зөв  
зүйтэй гэж үзэж байгаа. Тийм учраас  
хүүхэд хөгжлийг дэмжих чиглэлээр  
заавал санхүүжилт юу ч гээд хэрэггүй л  
дээ. Зүгээр ер нь бодлогоор дэмжинэ гээд  
л оруулчихвал.

**Ж.Бат-Эрдэнэ:** Таны томъёолол  
чинь сургалтын төвүүд, түүний багш  
нарт санхүүжилтийн болон байр, тоног  
төхөөрөмжийн гэсэн байна.

**М.Бадамсүрэн:** Багш нарын  
бодлогоор дэмжинэ гээд. Яах вэ

санхүүтэй холбоотой юм гарчихвал төсөв дээр.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалт. 17-5 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй. 6 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

“3.3.4.6.Бэлчээрийн зохистой ашиглах, хамгаалах үүднээс малчдын өвөлжөө хаваржааны доорх газрын хоорондын доод зай хэмжээг, мөн гүний худгийн цооног хоорондын доод зай хэмжээг тогтоох, дээрх газруудыг эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэхийг хориглох, зөвхөн үр хүүхдэдээ өвлүүлдэг байх эрх зүйн өөрчлөлт оруулна.”

Нэгэнт өгсөн саналаар санал хураалгүй яах вэ. Ямар ч байсан ч та өөрөө сая зассангүй. Тэгээд яг би саяын бичсэнээр чинь би чадан ядан хүргэлээ шүү. Санал хураалт 17-3 гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй.

2.4.1 нэмэх гэж байна. За та өөрөө унших. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

**М.Бадамсүрэн:** Энэ ер нь нөгөө газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг чинь Засгийн газартай байгуулсан шүү дээ. Үндсэндээ бид бол Монгол Улс бол ингэж хувь нийлүүлсэн гэсэн үг байхгүй юу. Эхлээд тосоо олборлоод борлуулаад, зөрүү зардлаа дараад гарсан ашгийг нь хувааж байгаа ийм л тогтолцоогоор явж байгаа шүү дээ. Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь. Гэтэл ямар тохиолдол үүсээд байна гэхээр зардлаа үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж байгаа хиймлээр. Энэ бол аудит тэгээд тогтооно, тогтоож чадахгүй янз бүр л байгаа юм. Яривал их дэлгэрэнгүй юм болно.

Тийм учраас энийг ил тод болгох хэрэгтэй. Худалдан авах ажиллагаа бараа, ажил үйлчилгээг. Тэгэхгүй бол баахан юмныхаа үнийг нэмэгдүүлээд л,

хилээр оруулж ирж байгаа тоног төхөөрөмж бусад юу байдаг юм. Тэгээд Монголд ноогдож байгаа ашиг бол маш бага байгаа шүү дээ яг үнэндээ. Тийм учраас энийг ил тод болгох үүднээс ил тод байдлыг ил тод болгож өгөөч. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг Засгийн газартай байгуулсан аж ахуйн нэгжүүдийг худалдан авах ажиллагаагаа ил тод байлгах ийм эрх зүйн өөрчлөлт рүү явъя гэдэг ийм л санал байгаа юм.

Тэгээд би гуравхан санал л дэвшүүлсэн л дээ. Яг орон нутагт амьдрал дээр тулгамдаж байгаа л асуудлууд байгаа. Тэгээд гишүүнийхээ хувьд боломжтой гэж үзээд энд Байнгын хорооны даргад би өмнө нь бас хуралдаан эхлэхэд өнөөдөр би маш олон цаг сууж байгаа байхгүй юу. Тэгээд хуралдаан эхлэхэд би асуугаад зөвшөөрөл аваад, тэгээд тэвчээртэй сууж байгаад эхлэхээс нь дуусах хүртэл сууж байгаад л хураалгаж байгаа шүү дээ Баярбаатар дарга аа. Тэгээд энэ дээр бас шинэ гишүүд бас мэдэхгүй ойлгохгүй юм бас байхыг үгүйсгэхгүй шүү дээ. Анх удаа энэ хэлэлцүүлэг дээр оролцож байна. Тэгээд энийг хүндэтгэж үзээч л гэж хүсэж байгаа юм. Тулгамдсан гуравхан л асуудлаар санал хураалгаж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ тэгээд саналыг чинь хүндэтгээд хураалгаж байгаа шүү дээ. Санал хураалт. 17-7 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

1.1.3 нэмэх гэж байна.

“Гэр хорооллын бүсэд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон, пассив барилгын стандарт болон ногоон санхүүжилтийн шаардлага хангахуйц бие даасан инженерийн шийдэлтэй загвар хорооллыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн барьж байгуулах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Санал хураалт. Санал гаргасан Бямбацогт. Үгүй ээ, энэ санал гаргасан дээр чинь

ингээж болж байгаа юм уу. Лувсанжамц гэдгээр явж байгаа.

### 3.3.3.3 өөрчлөн найруулах:

“3.3.3.3.Сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийг пассив барилгын стандартад нийцүүлж, эрчим хүчний хэмнэлттэй технологи руу шилжих арга хэмжээ авна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Дэмжигдэх байх. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 4.2.4.1 өөрчлөн найруулах:

“4.2.4.1.Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг харгалзан боловсруулан батлуулж, үүнтэй уялдуулан төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Санал хураалт 17-8 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

### 4.2.4 Нэмэх:

“4.2.4.4.Хороо, багийн хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөрийн холбоогоор гүйцэтгүүлнэ.” Тайлбар Лувсанжамц Лувсанжамцын микрофоныг нээе. Одоо наадах чинь асчихлаа.

**Г.Лувсанжамц:** Энэ одоо нөгөө хөрийн холбоо, иргэдийн бүлэг гээд байгаад байдаг. Тэгээд өөрсдөө ингээд яг хороо дотроо хэрэгжүүлэх гэж байгаа жижигхэн дугуйн зам, явган зам, ногоон байгууламж энэ тэрийг өөрсдөө хийх юм бол өртөг хямд мөртөө, илүү чанартай. Иргэд өөрсдөө оролцоотой болохоор дараа нь арчилгаа нь бас маш сайн

байгаад байдаг. Одоо ингээд шууд гаднын компани хүрч ирээд хийхлээр нөгөө өөрсдөд нь зориулж хийж байгаа гэсэн өөриймсөг үзэл, хандлага нь байхгүй болохоор хүүхдүүд очоод тоглоё гэхээр тэр хавийн архичин ах нар очоод суучихдаг ч юм уу. Эсрэгээрээ ингээд хүүхдүүд нь, оршин суугчид нь өөрсдөө оролцоод явахлаар түүнийгээ хамгаалдаг тийм байдал байгаа болохоор энийг дэмжиж өгөхийг хүсээж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалт. 17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.2.1. Нэмэлт. “Хүүхэд хөгжлийн STEAM боловсрол олгох ордныг дүүргүүдэд байгуулах” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Санал хураалт. Тайлбар авах юм уу. Санал хураалт. 17-7 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Үгүй ээ, эхлээд би чамаас ингээд л байхад чинь тэгээд л хэлсэнгүй шүү дээ.

2.2.4.5 нэмэх. Сургалтын байгууллагын интернэтийн дэд бүтцийг сайжруулах, суралцагч бүрийг ухаалаг хэрэгслээр хангахад санхүүгийн түрээсийн системийг нэвтрүүлэх” Санал гаргасан. Тэр дээрээ өөрийнхөө нэрийг оруулчих тэгвэл.

### 4.2.1.нэмэх:

“Улс төр дэх мөнгөний зохисгүй нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах ажиллагааг зогсооно.” Хэний санал юм. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Тайлбар хэлэх юм уу.

**Ж.Баярмаа:** Яах вэ, сонгуулийн эрх зүйн орчныг сайжруулна гэж оруулсан юм. Тэгээд сонсоод байсан чинь ерөөсөө шулуухан шулуухан оруулаад байхаар нь би ч гэсэн ер нь шулуухан оруулъя гэж шийдсэн юм. Тэгээд ер нь бодит байдал үнэн шүү дээ. Бид нар бүгд мэдээж байгаа

шүү дээ. Санал худалдан авах ажиллагаа битүү явагддаг. Ер нь бол зарчмын хувьд хууль бус сурталчилгаа гэж үздэг шүү дээ. 48.1-ээр. Хууль бус сурталчилгаа гээд дотор нь баахан юм жагсаагаад, гагцхүү сонгуулийн жилд л хийж болохгүй. Сонгуулийн жил бус үед болохоор болдог гээд маш тийм логикгүй юм явж байгаа байхгүй юу. Ер нь бол зарчмын хувьд буруу. Гэхдээ сонгуулийн бус үед бол зөв болчихдог ийм юм байж болохгүй шүү дээ. Тэгэхээр явсаар аяндаа санал худалдан авах ажиллагаа гэхээр наадах чинь тэгээд эд нарыг чинь хасах л болж байгаа байхгүй юу. Үгүй ээ, одоо бэлэг тараана гэвэл арай бас шараа шүү дээ. Санал худалдан авах ажиллагаа гэхээр аяндаа энэ 48.1-д 4 жил хориглоно гээд орчих юм. Тэгэхээр сонгуулийн жилээс дараагийн сонгуулийн жил хүртэлх 4 жил болохгүй, бусад цагт бол болно шүү дээ. Энийг оруулахгүй бол тэгээд энэ мөнгөний нөлөөллөөс бид нар хэзээ ч ангижрахгүй. Хэзээ ч о нөгөө бид нарын хүсдэг эрдэм мэдлэгтэй гэдэг хүмүүс нь орох боломж нь хязгаарлагдмал л байна. Өөрсдийгөө ч гэсэн зовоодог биз дээ. Одоо ний нуугүй хэлэхэд махаа иддэг биз дээ. Үгүй ээ, дэвшихгүй хүнд бол болно шүү дээ. Би 2032 онд дэвшинэ гэж байгаа хүн бол тарааж болж байгаа байхгүй юу. Нэг сонгуулийн жилийн хооронд буюу 4 жил л болохгүй. Одоо 2028 онд дэвших гэж байгаа хүн бол 2024-2028 оны хооронд 4 жил болохгүй.

Одоо Доржханд гишүүн бол бүр дэмжихээс өөр замгүй заалт. Ингэвэл нээрээ бүгд амарна шүү. Яс амарна шүү. Тэгээд би яасан юм амар энэ чинь сонгуулиар хориглочихсон гээд л сууж байна шүү дээ. Нөгөө боов ажиллагаа, нөгөө амралт ажиллагаа эд нар чинь бүгд ингээд байхгүй болно шүү дээ. Бүгд амарна шүү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Би нэрээ бичүүлчих үү. Болохгүй билүү энэ чинь. Санал хураалт. Дэг дээр харин яаж байна. Ингэж урьд нь лоббидож болж байна уу

үгүй юу. 17-10. Санал дэмжигдлээ. Редакцын завсартай оруулъя. Саяынхыг.

Ажлын хэсэг дээр бид нар техникийн хүрээнд нэг хэсэг зүйл үлдчихээд байгаа юм. Яг техникийн хүрээнд. Тэгээд тэрийгээ би бас өөрийнхөө нэрээр оруулчихдаг юм уу гэсэн ийм саналыг оруулж ирж байна.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын Эрсдэлийн удирдлага гэсэн бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.4 үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар ба амар тайван нийгэм гэсэн хэсэгт 4.4.5 дахь зорилт болгон шилжүүлж, 4.4.4 дэх зорилтын гарчгийн “Эрсдэлийн удирдлага гэснийг хасах:

#### “4.4.5.Эрсдэлийн удирдлага

4.4.5.1.Геополитикийн тогтворгүй байдал цар тахлын үеийн болон дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал ба дэвшилтэт технологийн хурдацтай шилжилтийн тодорхой бус байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл болон бусад эрсдэлийг даван туулах хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай авах зорилгоор холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв мөнгөний бодлогын уялдааг хангасан эрсдэлийн удирдлагын цогц бодлого, төлөвлөгөөг гарган хэрэгжүүлнэ.

#### 4.4.5.2.Эрсдэлийг

урьдчилан илрүүлэх, үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах, хэрэгжилтэд үнэлгээ хийх системийг хөгжүүлж, эрсдэлийн удирдлагын шинэчлэлийг эхлүүлнэ.

#### 4.4.5.3.Хамтрагч,

түншилэгч талууд болон олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх, солилцох нөхцөлийг бүрдүүлж, хамтын итгэлцлийг нэмэгдүүлэх, эрсдэлийн

удирдлага, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд гадаад болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

#### 4.4.5.4. Эрсдэлийн

удирдлагын үе шат бүрд иргэн, хуулийн этгээдийн оролцоог хангаж, урамшуулах бодлогыг дэмжинэ.” Санал хураалт 17-10 гишүүн дэмжиж, дэмжигдлээ. Баярлалаа.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.3.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.4.3.5.Хот, суурин газарт үерийн эрсдэлийн үнэлгээг ерөнхий болон нарийвчилсан байдлаар хийж, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулж, үе шатаар хэрэгжүүлнэ.” Санал хураалт 17-10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.4.Орон нутгийн засаглалын бие даасан байдал” зорилтот дор дурдсан агуулгатай 4.2.4.1 дэх заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.2.4.1.Орон нутгийн засаглалын бие даасан байдлыг бэхжүүлэх хүрээнд орон нутгийн босоо удирдлагатай байгууллагуудын томилгооны асуудлыг орон нутагт нь шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” Энэ ёстой зүйтэй биз дээ. Санал хураалт. 17-10 санал өгч, санал дэмжигдлээ.

#### **Найруулгын санал:**

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтын “мэдэгдэл” гэснийг “Мэдэгдлийн” гэж, “төлөвлөгөө” гэснийг “төлөвлөгөөний” гэж, 3 дахь заалтын “төрөлжсөн” гэснийг “төрөлжсөн бүс бөгөөд” гэж тохиолдол бүрд, тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.6.1 дэх заалтын “Алтай овоо” гэснийг “Алтан овоо” гэж, 2.1.1.7 дахь заалтын “гэр бүл,

хүүхэд хөгжил, хамгааллын” гэснийг “гэр бүлийн” гэж, 2.1.1.12 дахь заалтын “хөгжил, нийгмийн” гэснийг “хөгжлийн болон нийгмийн” гэж, 2.2.1.4 дэх заалтын “тохируулгад” гэснийг “тохируулгат” гэж, 2.2.1.9 дэх заалтын “чиглэнэ” гэснийг “чиглүүлнэ” гэж, 2.2.1.13 дахь заалтын “төгсдөг” гэснийг “төгсөх” гэж, 1.1.1, 3.1.3, 3.2.1, 4.2.3 дахь заалтуудын гарчгийн, мөн 3.3.3.40 дэх заалтын “реформ” гэснийг “шинэчлэл” гэж, 3.1.3.3 дахь заалтын “реформыг” гэснийг “шинэчлэлийг” гэж, 3.2.2.5 дахь заалтын “хүч” гэснийг “хүчний” гэж, 3.2.2.9, 3.2.2.10 дахь заалтын “баталж” гэснийг “батлуулж” гэж, 3.2.2.10 дахь заалтын “саад тотгорыг” гэснийг “саадыг” гэж, 3.3.5.10 дахь заалтын “марс гэдэгт” гэснийг “Марс гарагтай” гэж, 3.3.6.7 дахь заалтын “концепцоор” гэснийг “агуулгаар” гэж, 4.1.1.3 дахь заалтын “мөрдөн хавчигдсан” гэснийг мөрдөн хавчигддаггүй байх” гэж, 4.1.2.1 дэх заалтын “ёс зүй” гэснийг “ёс зүйг баримтлан” гэж, 4.3.2.4 дэх заалтын “IoT” гэснийг “юмсын интернэт” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.4.1 дэх заалтын “хөдөлгөөн” гэсний өмнө “замын” гэж, 2.1.1.29 дэх заалтын “хөтөлбөрт” гэсний өмнө “сургалтын” гэж, 2.1.4.2 дахь заалтын “шигшээ” гэсний өмнө “үндэсний” гэж, 2.2.1.6 дахь заалтын “эдийн засгийн” гэсний дараа “хувьд” гэж, 3.2.2.5 дахь заалтын “төлбөрөөс” гэсний өмнө “ажлын байрны” гэж, 3.4.1.1 дэх заалтын “төрөхийн” гэсний өмнө “унаган” гэж, 4.2.1.12 дахь заалтын камерын гэсний дараа “хяналтын” гэж, 4.3.1.3 дахь заалтын “зэрэг бүх салбарт” гэснийг “болон бусад салбарт” гэж, 4.4.2.1 дэх заалтын “суурь” гэсний өмнө “гадаад бодлогын” гэж тус тус нэмэх. Санал хураалт. 17-9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.1.7 дахь заалтын “дээд зэргээр” гэснийг, 2.2.4.2 дахь заалтын “дижитал” гэснийг, 3.1.1.3 дахь заалтын “Монгол Улсын Үндсэн хуульд заасан” гэснийг, 3.2.2 дахь заалтын “багц” гэснийг, 3.2.2.4 дэх заалтын “цахим” гэснийг, 3.3.4.4 дэх заалтын “ялангуяа” гэснийг, 4.3.2.5 дахь заалтын “аливаа” гэснийг тус тус хасах. Санал хураалт.

Ингээд “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, ажлын хэсгийн болон Байнгын хороод, гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт хийж дууслаа.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулъя.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. Баярлалаа. Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүддээ.

16.15 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ